



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ
“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ
УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ”
ТӨСӨЛ



Тайланг боловсруулсан зөвлөх баг:

Г.Сувд, зөвлөх

Б.Мөнхбүрэн, зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Ж.Хүрэлбаатар, Завхан аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

© 2022 НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр.

Зохиогчийн бүх эрхийг хамгаалсан.

ISBN:

ISBN 978-9919-9938-3-2



9 789919 993832

ННА: 65.052

ДАА: 657

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ

“МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйл ажиллагаа, санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээг Европын холбооноос Монгол Улсын Засгийн газарт үзүүлж буй төсвийн дэмжлэгийн бүрэлдэхүүн “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын холбооны санхүүжилтээр Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага хамтран хэрэгжүүлдэг. НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий зүйл: Энэхүү тайлан нь Европын холбоо (ЕХ)-ны санхүүжилтээр хэвлэгдсэн болно. Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд ЕХ болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт ЕХ, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, дахин хэвлэх, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

НЭГ.	
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	10
1.1 Судалгааны зорилго	11
1.2 Завхан аймгийн эдийн засгийн талаарх мэдээлэл	12
ХОЁР.	
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ҮЙЛ ЯВЦ	14
2.1 Орон нутгийн төсөв, түүний эрх зүйн зохицуулалт	15
2.2 Орон нутгийн төсвийн үйл явц	18
ГУРАВ.	
ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ	24
3.1 Төсвийн орлогын гүйцэтгэлийн шинжилгээ	25
3.1.1 Нийт орлогын гүйцэтгэл	25
3.1.2 Тусламж санхүүжилтийн орлогын гүйцэтгэл	29
3.1.3 Татварын орлогын гүйцэтгэл	27
3.1.4 Татварын бус орлогын гүйцэтгэл	37
3.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн шинжилгээ	42
3.2.1 Зарлагын шинжилгээ -Төсвийн шатлалаар	43
3.2.2 Зарлагын шинжилгээ - Эдийн засгийн ангиллаар	44
3.2.3 Зарлагын шинжилгээ -Төсвийн захирагчаар	51
3.2.4 Зарлагын шинжилгээ - Санхүүжилтийн эх үүсвэрээр	53
3.2.5 Зарлагын шинжилгээ - Хөтөлбөр, арга хэмжээгээр	54
3.2.6 Нэг хүнд ногдох төсвийн зарлага	56
3.2.7 Сургуулийн өмнөх боловсролын төсөв	58
3.2.8 Ерөнхий боловсролын сургуулийн төсөв	60
3.2.9 Эрүүл мэндийн төсөв	63
3.3 Тусгай сангийн төсвийн шинжилгээ	65
3.3.1 ОНХС-ийн төсвийн шинжилгээ	65
3.3.2 Сум хөгжүүлэх сан, түүний төлөвлөлт, гүйцэтгэл	70
3.4 Хөгжлийн бодлого төлөвлөлт болон орон нутгийн төсвийн уялдаа	75
3.4.1 Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсвийн уялдаа	75

ДӨРӨВ.

ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

80

4.1 Засаг дарга ба салбарын сайд хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн

81

ТАВ.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХЯНАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

88

5.1 Төсвийн дотоод хяналт

89

5.2 Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн хяналт, үнэлгээ

90

5.3 Төсвийн гадаад хяналт

91

ЗУРГАА.

ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

93

6.1 Дүгнэлт

93

6.2 Орон нутгийн төсөвт тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх санал зөвлөмж

100

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1.	Завхан аймгийн орон нутгийн төсвийн орлого, нэр төрлийн ангиллаар, жилээр	103
Хавсралт 2.	Завхан аймгийн орон нутгийн төсвийн зарлага, нэр төрлийн ангиллаар, жилээр	105
Хавсралт 3.	Завхан аймгийн орон нутгийн төсвийн татварын орлого	108
Хавсралт 4.	Завхан аймгийн татварын орлогын гүйцэтгэл, сумаар	109
Хавсралт 5.	Завхан аймгийн орон нутгийн төсвийн зарлага, сумаар	110
Хавсралт 6.	Завхан аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл	111
Хавсралт 7.	Малын тоо толгойн албан татварын тооцоолол, сумаар	112

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.	Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, 2017-2020 он	12
Хүснэгт 2.	Төсвийн харилцааг зохицуулдаг хууль, тогтоомжууд	15
Хүснэгт 3.	Завхан аймгийн ИТХ-аас төсөв баталсан цаглабар, 2017-2019 он	21
Хүснэгт 4.	Орон нутгийн жилийн төсвийн төсөлд тавигдах шаардлагыг хангасан байдал	21
Хүснэгт 5.	Аймгийн төсвийн тэнцэл, 2018-2020 он, сая.төг	22
Хүснэгт 6.	Аймгуудын төсвийн орлого, зарлагын байдал, 2020 он, сая.төг	23
Хүснэгт 7.	Аймгийн төсвийн гүйцэтгэл, 2016-2020 он, сая.төг	25
Хүснэгт 8.	Завхан аймгийн төсвийн орлогын бүтэц, 2016-2020 он, сая.төг	26
Хүснэгт 9.	Завхан аймгийн орон нутгийн төсвийн тусламж санхүүжилтийн орлогын бүтэц, 2016-2020 он, сая.төг	27
Хүснэгт 10.	Аймгийн төсвийн орлогын бүтцийн шинжилгээ, 2018 он, сая.төг	30
Хүснэгт 11.	Аймгийн төсвийн орлогын төлөвлөлтийн байдал, 2020 он, сая.төг	31
Хүснэгт 12.	Аймгийн ИТХ-аар тогтоосон татвар хураамжийн хувь хэмжээ	32
Хүснэгт 13.	Татвар ноогдуулах суурь үзүүлэлтийн түүвэр судалгаа	34
Хүснэгт 14.	Завхан аймгийн татварын орлого аймаг, сумаар 2016-2020 он, сая.төг	34
Хүснэгт 15.	Сумын татварын орлогын гүйцэтгэл, 2016-2020 он, сая.төг	35
Хүснэгт 16.	Сумдын төсвийн зарлагад орлогын эзлэх хувь, сая.төг	36
Хүснэгт 17.	Татварын бус орлогын өөрчлөлт, 2018-2020 он, сая.төг	38
Хүснэгт 18.	ОНӨҮГ-уудын санхүүгийн тайлан, 2020 он, сая.төг	38
Хүснэгт 19.	Татварын орлогод үзүүлэх нөлөөлөл, 2020 он	40
Хүснэгт 20.	Малын тоо, толгойн албан татварын тооцоолол, 2021 он	41
Хүснэгт 21.	Завхан аймгийн төсвийн зарлага, 2016-2020 он	42
Хүснэгт 22.	Завхан аймгийн сумдын төсвийн зарлага, 2016-2020 он, сая.төг	43
Хүснэгт 23.	Завхан аймгийн төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар, 2016-2020 он, сая.төг	
Хүснэгт 24.	Завхан аймгийн төсвийн зарлага, Эдийн засгийн ангиллаар, 2016-2020 он, сая.төг	49
Хүснэгт 25.	Аймгийн төсвийн зарлагын зүйлээр өөрчлөлт, 2016-2020 он, хувиар	52
Хүснэгт 26.	Завхан аймгийн тусгай шилжүүлгийн төсвийн өсөлт, сая.төг, хувиар	
Хүснэгт 27.	Аймгийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, 2016-2020 он, сая.төг	53
Хүснэгт 28.	Зарлагын шинжилгээ-хөтөлбөр, арга хэмжээгээр, 2020 он, сая.төг	55
Хүснэгт 29.	Нэг хүнд ногдох төсвийн зарлага, 2016-2020 он	56

Хүснэгт 30.	Завхан аймгийн СӨБ-ын 2020 оны төсвийн зарлага, сая.төг	58
Хүснэгт 31.	ЕБС-ийн төсвийн зарлагын бүтцийн шинжилгээ, 2020 он, сая.төг	60
Хүснэгт 32	Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, мян.төг	61
Хүснэгт 33.	ЕБС-ийн хувьсах зардлын тооцоолол, 2020 он, сая.төг	62
Хүснэгт 34.	ЕБС-ийн сургуулийн үндсэн үзүүлэлт, 2020 он, сая.төг	63
Хүснэгт 35.	Эрүүл мэндийн салбарын төсвийн үзүүлэлт, сая.төг, хүний тоо	64
Хүснэгт 36.	Завхан аймгийн хөрөнгийн зардлын гүйцэтгэл, 2016-2020 он, сая.төг	65
Хүснэгт 37.	ОНХС болон Малын тоо толгойн албан татварын хөрөнгийн зарцуулах чиг үүрэг	66
Хүснэгт 38.	Завхан аймгийн сумдын жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн, 2020 он, мян.төг	70
Хүснэгт 39.	Сум хөгжүүлэх сангийн хуваарилалт, 2011-2014 он, сая.төг	71
Хүснэгт 40.	Сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээлэл /2021.06.30/	71
Хүснэгт 41.	Завхан аймгийн Сум хөгжүүлэх сангийн орлогын мэдээлэл, 2016-2020 он, сая.төг	72
Хүснэгт 42.	Завхан аймгийн Сум хөгжүүлэх сангийн зарлагын мэдээлэл, сая.төг	73
Хүснэгт 43.	ЗД-ын үндсэн чиглэлийн төсөв, 2018-2019 он, сая.төг	76
Хүснэгт 44.	Завхан аймагт хэрэгжиж байгаа дэд хөтөлбөрт зарцуулсан төсвийн мэдээлэл, 2016-2020 он	76
Хүснэгт 45.	Завхан аймгаас салбарын яамдад хүргүүлсэн хөрөнгө оруулалтын санал, шийдвэрлэлтийн байдал, 2019-2021 он, мян.төг	78
Хүснэгт 46.	Завхан аймгийн хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүй, 2016-2020 он	79
Хүснэгт 47.	Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, 2018-2020 он	79
Хүснэгт 48.	Салбарын сайд, ЗГ-ын зарим байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлт, 2020 он	81
Хүснэгт 49.	Аймгийн ЗД-тай байгуулсан гэрээний биелэлт, байгууллагаар	82
Хүснэгт 50.	Аймгийн ЗД-ын ХХҮГ-ын даргатай байгуулсан гэрээний биелэлт, 2020 он	83
Хүснэгт 51.	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сая төг, хувиар	84
Хүснэгт 52.	Завхан аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, 2016-2020 он, сая.төг	85
Хүснэгт 53.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн авлага, 2020 он, мян.төг	86
Хүснэгт 54.	Завхан аймгийн аудитаар илэрсэн зөрчил, сая.төг	92

ЗУРАГ

Зураг 1.	Завхан аймгийн төсвийн орлого, зарлага, 2016-2020 он, сая.төг	25
Зураг 2.	Нийт орлого ба тусламжийн дүнгийн өөрчлөлт, 2016-2020 он	26
Зураг 3.	Төсвийн орлогын бүтэц, 2016-2020 он	26
Зураг 4.	Аймгийн төсвийн орлого, зарлага, 2020 он, тэрбум.төг	27
Зураг 5.	Завхан аймгийн татварын орлогын бүтэц, хувиар, 2016-2020 он	29
Зураг 6:	Завхан аймгийн татварын орлого аймаг, сумаар 2016-2020 он, сая.төг	35
Зураг 7.	Төсөвт төвлөрүүлж буй орлого, 2021 он, сая.төг	39
Зураг 8.	Завхан аймгийн төсвийн зарлагын бүтэц, шатлалаар, хувиар, 2016-2020 он	43
Зураг 9.	Аймгийн төсвийн зарлагын бүтэц, хувиар, 2020 он	45
Зураг 10.	Завхан аймгийн төсвийн зарлага /эдийн засгийн ангиллаар/	45
Зураг 11.	Завхан аймгийн урсгал зардлын бүтэц, 2020 он	50
Зураг 12.	Нийт зардалд цалин, тогтмол зардлын эзлэх хувь, 2016-2020 он	50
Зураг 13.	Завхан аймгийн төсвийн зарлага /ТЭЗ-аар/	52
Зураг 14.	Завхан аймгийн зардлын эх үүсвэр, хувиар, 2016-2020 он	54
Зураг 15.	Санхүүжилтийн эх үүсвэр, орон нутгийн орлогын харьцаа, 2016-2020 он	54
Зураг 16.	ДНБ-д төсвийн зарлагын харьцаа, эзлэх хувийн жин	57
Зураг 17.	СӨБ-ын төсвийн зарлагын бүтэц, 2020 он	59
Зураг 18.	Аймгийн нийт сурагчдын тооны өөрчлөлт, 2016-2020 он	60
Зураг 19.	Завхан аймгийн ЕБС-ийн зардлын бүтэц	61
Зураг 20.	Завхан аймгийн ОНХС-ийн гүйцэтгэл, 2016-2020 он, сая.төг	67
Зураг 21.	Завхан аймгийн ОНХС-ийн бүтэц /2018-2020 он/	67
Зураг 22.	ОНХС-ийн хөрөнгө оруулалт салбараар, 2018-2021 он, сая.төг	68
Зураг 23.	ОНХС-ийн төлөвлөгөөнд иргэдийн оролцоо, 2018-2020 он	68
Зураг 24.	Завхан аймгийн ОНХС-ийн урамшуулалд хамрагдалт, урамшуулал, мян.төг	69
Зураг 25.	Завхан аймаг, улсын дундаж үзүүлэлттэй харьцуулалт, 2020 он	69
Зураг 26.	Завхан аймгийн Сум хөгжүүлэх сангийн зээлийн чанар байдал	72
Зураг 27.	Сум хөгжүүлэх сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, 2016-2020 он, сая.төг	74
Зураг 28.	Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүн, 2020 он	74
Зураг 29.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан хөрөнгө, бий болсон ажлын байрны өсөлт, бууралт, хувиар	85
Зураг 30.	Санхүүгийн хяналт, аудитын тайлан, 2016-2020 он, сая.төг	89

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ГБХЭХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НБХ	Нийгмийн бодлогын хэлтэс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУ	Олон улс
ОУВС	Олон улсын валютын сан
УИХ	Улсын Их Хурал
ҮСГ	Үндэсний статистикийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТСНДТ	Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоо
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТХ	Татварын хэлтэс
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХШУДАХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ЭМД	Эрүүл мэндийн даатгал



НЭГ.
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Судалгааны зорилго

НҮБХХ-ийн “Тогтвортой хөгжлийн зорилт 2030 хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн зүгээс “Завхан аймгийн орон нутгийн төсвийн шинжилгээ”-г орон нутгийн мэдээлэл, кэйс судалгаанд үндэслэн боловсруулж, тус тайланг боловсруулав. Энэхүү орон нутгийн төсвийн шинжилгээний зорилго нь аймгийн дунд хугацааны хөгжлийн зорилтыг хангахад төсвийн харилцааны механизм хэрхэн нөлөөлж байгааг орон нутгийн төсвийн шинжилгээ, судалгаагаар дамжуулан дүгнэлт гарган, бодлогын зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны энэхүү зорилго нь дараах зорилтуудыг агуулсан. Үүнд:

- I.** Орон нутгийн төсвийн сүүлийн 3-5 жилийн төлөвлөлт, хэрэгжилтийн явц, орлого, зарлагын гүйцэтгэлийг эх үүсвэрээр болон салбараар шинжлэх, төсөвлөлттэй холбоотой мэдээллүүдэд шинжилгээ хийх;
- II.** Аймгийн төсвийн бодлого, төлөвлөлт, орлого бүрдүүлэх үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлтүүдийг судлах;
- III.** Төсвийн хүрээнд хийгддэг төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, зарлага хуваарилалт, тайлагналт, хяналт-үнэлгээ, шинжилгээний арга, аргачлал, үйл явцыг судалж тухайн нөхцөлд гарсан кэйс, судалгааны дүгнэлтэд үндэслэн зөвлөмж, санал боловсруулах тус тус багтсан.

Энэхүү судалгаа нь Сангийн яам (СЯ), салбарын бусад яам, Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ), ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс (СТСХ), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (ХОХБТХ) болон орон нутгийн холбогдох бусад төрийн байгууллагаас гаргасан үндсэн мэдээллийн эх сурвалж, НҮБХХ болон бусад судлаачдын гаргасан хоёрдогч мэдээллийн эх сурвалжид үндэслэн хийгдсэн болно. Түүнчлэн, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхдээ тоон өгөгдлийг задлан шинжлэх аргыг ашигласан болно.

Уг судалгааг хийхийн тулд шинжилгээ хийх тоо мэдээллийг улсын нэгдсэн төсөв, аймаг, сумдын батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийн тоо мэдээлэлд үндэслэн харьцуулсан, задлан шинжлэх аргаар дүгнэлт боловсруулж, зөвлөмж гаргасан. Мөн шат шатны байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийж, оролцогч талуудаас холбогдох мэдээлэл, үнэлгээ, баримт бичгүүдийг цуглуулж, нэмэлт мэдээлэл авах замаар хоёрдогч тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан. Мэдээллийн эх сурвалжууд нь зарим талаар давхцаж байсан бөгөөд энэ нь янз бүрийн эх сурвалж бүхий мэдээллийг ашиглаж, харьцуулан судлах, боломжийг судалгааны багт олгосон юм.

1.2 Завхан аймгийн эдийн засгийн талаарх мэдээлэл



Завхан аймаг нь Монгол Улсын баруун хэсэгт баруун талаараа Ховд, Увс аймаг, хойд талаараа Тува улс, зүүн талаараа Хөвсгөл, Архангай, урд талаараа Баянхонгор, Говь-Алтай аймагтай хиллэдэг бөгөөд 1923 онд байгуулагдсан таван аймгийн нэг юм. **82.5 мян.км.** хавтгай дөрвөлжин газар нутаг бүхий тус аймаг нь **24 сум, 116 багтай** бөгөөд нийт хүн амын тоо **72.4 мянга**, Улаанбаатар хотоос **1,104 км** зайтай оршдог, эртний түүхтэй, байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутаг юм.

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн тогтоолоор Хантайшир уулын аймгийг татан буулгаж, Завхан аймгийг байгуулах шийдвэр гарсан. Хантайшир уулын аймгийн Нөмрөг уулын хошуу /Хуучин Засагтхан аймгийн Цогтой вангийн хошуу/, Цэцэн сартуул хошуу /хуучин Засагтхан аймгийн Цэцэн сартуул вангийн хошуу/, Гурван сайхан Жаргалант/ хуучин Засагтхан аймгийн Баатар вангийн хошуу/, Цэцэрлэгмандал уулын аймгийн Отгонхайрхан уулын хошуудаас /хуучин Сайн ноён хан аймгийн Хошууч мэргэн засгийн хошуу/ анх Завхан аймгийг байгуулжээ. Үүнээс хойш Завхан аймгийн бүтэц бас өөрчлөгдсөн, тухайлбал 1931 онд дахин салж одоогийн Говь- Алтай аймаг, 1933 онд Завхан аймаг нийлж, 1940 онд дахин салж одоогийн Говь- Алтай аймгийг байгуулсан ба 1942 онд Гурвансайхан Жаргалант уулын хошуунаас үүссэн Хөхморьт, Дэлгэр, Баян-Уул сумдыг Завхан аймгийн харьяалаас гаргаж, шилжүүлэн өгчээ.

Хүснэгт 1. ЗАВХАН АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2017-2020 ОН

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020
Нийт өрх	мян.өрх	21.5	21.8	21.8	21.2
Малчин өрх	мян.өрх	9.1	9.1	8.9	9.3
Суурин хүн ам	мян.хүн	72.1	72.9	73.1	73.2
Хүний хөгжлийн индекс	коэф	0.664	0.665	0.694	0.714
Хүний хөгжлийн индекс /улсын дундаж/	коэф	0.751	0.759	0.763	0.775
Шинээр төрсөн хүүхэд	хүн	1,448	1,601	1,435	1,371
Шилжиж ирсэн хүн	хүн	843	713	468	1081

Шилжиж явсан хүн	хүн	891	599	-	-
Нас барсан хүн	хүн	395	384	389	351
Гэрлэлт	хос	408	388	352	315
Гэр бүл цуцлалт	хос	23	30	26	28
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	хүн	457	465	710	643
Бүртгэлтэй ажилгүйчүүд 12 сард	хүн	1,690	1,285	1,452	1,206
НД сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо	хүн	10,090	10,847	11,197	14,278
Олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ	сая.төг	39,055.7	44,446	50,586.7	55,582.5
ХХҮГ-ын халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт авсан хүний тоо	хүн	25,114	25,251	36,350	34,257
Олгосон тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт	сая.төг	8,371.4	10,666.1	11,556.3	11,067.7
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт /оны үнээр/	сая.төг	13,382.2	31,133.2	37,770.7	34,785.0
Барилга угсралт, их засварын ажил /оны үнээр/	сая.төг	104,971.2	161,854.1	208,746.2	61,898.4
Хэрэглээний үнийн индекс	хувиар	104.1	100.2	100.1	100.4
Малын тоо бүгд	мян.тол	3,597.3	3,555.4	3,849.9	3,607.8
Тэмээ	мян.тол	7.5	7.8	8	8.1
Адуу	мян.тол	207.4	222.5	243.7	236.7
Үхэр	мян.тол	192.2	205	228.7	225.0
Хонь	мян.тол	1,837.7	1,827.4	1,951	1,799.8
Ямаа	мян.тол	1,352.5	1,292.7	1,418.5	1,338.2
Бойжсон төл	мян.тол	1,235.1	1,000.8	1,305.5	1,233.6
Тариалсан талбай /бүгд/	га	1,863.4	2,471	3,371.1	3,503.3
Хураасан ургац /бүгд/	тн	4,987.4	6,397.5	6,680.4	9,793.1
Төмс	тн	2,127.5	1,987.8	1,952.9	1,783.9
Хүнсний ногоо	тн	1,120.2	1,338.5	1,703.3	1,587.5
Бэлтгэсэн өвс хадлан	мян.тн	15.4	15.2	16.8	14.3
Их эмч	тоо	181	178	182	184
Ерөнхий боловсролын сургууль	тоо	30	30	29	30
Суралцагчид	мян. хүүхэд	14.7	14.5	15.2	15.5
Хүүхдийн цэцэрлэгийн тоо	тоо	39	40	40	41
СӨБ хамрагдсан хүүхдийн тоо	мян. хүүхэд	6.5	5.8	5.8	5.2
Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум. төг	313.2	356.5	-	-
Татварын орлого дүнгээр	сая.төг	1,2743.1	1,3679.1	1,4530.1	1,3174.1
Төсвийн зарлага нийт дүнгээр	сая.төг	62,045.8	70,804.7	75,401.2	92,108.7
Амьжиргааны доод түвшин	төгрөг	166,500	178,000	190,700	212,600
Амьжиргааны доод түвшин (Улсын дундаж)	төгрөг	171,400	181,700	195,500	207,800
Бүртгэлтэй аж ахуйн нэгж	тоо	1,910	2,019	-	2,210
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	221	235	247	271



ХОЁР.

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ БА ҮЙЛ ЯВЦ



2.1 Орон нутгийн төсөв, түүний эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлд “Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь бие даасан төсөвтэй байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн төсвийн эх үүсвэр нь татварын болон татварын бус орлого, улсын төсвийн санхүүжилт, хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгийг энэ хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулна. Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна” гэж заажээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэр, Засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана”, 58 дугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий Засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн Засаг, нийгмийн цогцолбор мөн”, 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 59.2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн Засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно” гэж тус тус заасан байна.

Дээрх хуулийн заалтууд нь орон нутгийн төсвийн харилцааг зохицуулах гол үндэс бөгөөд нэг талаас засаг захиргааны нэгж бүр өөрт хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсвийг хэрхэн бүрдүүлж, захиран зарцуулах, нөгөө талаас Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээнд орон нутгийн төсөв нь улсын төсөв, нийгмийн даатгалын төсөв, эрүүл мэндийн даатгалын төсөвтэй хэрхэн харилцах эрх зүйг зохицуулсан байна.

Энэхүү зохицуулалт нь Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд илүү тусгалаа олсон байдаг. Тухайлбал: хуулийн 21.1 заалтад “Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.”, 21.2 заалтад “Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.”, 21.3 заалтад “Аймаг, нийслэлийн төсвийн дээд шатны төсөв нь улсын төсөв, сум, дүүргийн төсвийн дээд шатны төсөв нь аймаг, нийслэлийн төсөв байна.”, 21.4 заалтад “Төсвийн шатлал бүрд ногдох орлого, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан байна.

Хүснэгт 2. ТӨСВИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛДАГ ХУУЛЬ, ТОГТООМЖУУД

Хуулийн нэр	Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ
1 ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ (2010)	Энэ хуулиар нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагыг тогтоох, хэрэгжүүлэх, түүнд хяналт тавихад төрийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүсгийн хуримтлал бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

2	ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ (2011)	Энэ хуулиар төсөв, түүний зарчим, тогтолцоо, бүрэлдэхүүн, ангиллыг тогтоож төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх, төсвийн харилцаанд оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж, төсөв боловсруулах, батлах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Түүний дотор орон нутгийн төсөв, төсөв хоорондын харилцаа, төсвийн талаар орон нутгийн ИТХ, Засаг даргын бүрэн эрх, орон нутгийн төсвийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах зэргийг хуульчилж өгсөн байна.
3	ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ (2006)	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулж байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бөгөөд нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засгийн үндэс, төсөв, орон нутгийн удирдлагын эрх хэмжээг зохицуулсан байна.
4	ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ (2020)	Энэ хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд чиглэсний дотор аймаг, нийслэл, хотын хөгжлийн төлөвлөлтийн талаарх зохицуулалтуудыг тусгасан.
5	ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ (2019)	Энэ хуулиар Монгол Улсад татвар бий болгох, хувь хэмжээг тогтоох, ногдуулах, хураах, тайлагнах, хянах эрх зүйн үндэс болон татвар төлөгч, татварын албаны эрх, үүргийг тодорхойлсон. Мөн энэ хуулиар татварын хувь хэмжээг тогтооход Засгийн газар, нийслэл, аймгийн эрх мэдлийг зааж өгсөн.
6	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ (1996)	Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад орших ба Үндсэн хууль, Иргэний хуульд тодорхойлсон төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад үйлчилнэ.

7	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ (2005)	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, уг ажиллагаанд хяналт тавих, гомдол гаргаж шийдвэрлүүлэх, энэхүү хуулийг зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан бөгөөд төрийн худалдан авалтыг мэргэжлийн түвшинд ил тод, нээлттэй зохион байгуулснаар төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх, худалдан авах ажиллагаанд оролцогчид тэгш, шударга, авлигаас ангид өрсөлдөх боломжийг бий болгох, иргэдийн зүгээс хяналтыг хэрэгжүүлэх ач холбогдолтой.
8	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ (2020)	Төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх этгээд болох Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход чиглэсэн.
9	ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬ (2014)	Энэ хуулийн зорилт нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Эх сурвалж : www.legalinfo.mn

Эдгээр хуулиудыг дагаж эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас баталсан дүрэм, журмууд мөрдөж байгаагаас орон нутгийн төсөвтэй холбоотой дараах гол журмууд үйлчилж байна, үүнд:

1. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”.
2. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн үйл ажиллагааны журам”.
3. Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”.
4. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”.
5. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” зэрэг болно.

Нутгийн удирдлагын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төсөв, татвар, санхүүгийн дорвитой өөрчлөлтийг хийх, орон нутгийн бие даасан байдал, хариуцлага, санаачилгыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталж, 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөх гэж байна. Энэ хуулиар орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн ба хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Татварын хууль, Төсвийн тухай хуульд зохих өөрчлөлтүүд орсон.

Тухайлбал сум, дүүргийн төсөвт орох төсвийн орлогын нэр төрөл, хэмжээ дараах байдлаар нэмэгдсэн, үүнд:

- **Малын тоо толгойн татварыг бий болгож, ОНХС-гийн санхүүжилтийн эх үүсвэр болгосон.**
- **Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)-ын тухай хуулийн 7.1 заалтад заасан цалин, хөлс түүнтэй адилтгах орлогоос авах албан татвар.**
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар.**
- **Газрын төлбөрийн 40 хувь нь сумын төсөвт орохоор болсон.**

Өмнө нь улсын төсөвт 100 хувь ордог байсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь аймаг, нийслэлийн төсөвт орохоор зохицуулагдсан байна.

2.2 Орон нутгийн төсвийн үйл явц

Төсөв нь төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, гүйцэтгэлд үнэлгээ хийх гэсэн 4 үе шат бүхий 3 жилийг дамнасан тасралтгүй үйл ажиллагаа байдаг бөгөөд үүний дотор төсвийг төлөвлөх, батлах үйл явц нь “Төсвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу цаг хугацааны дэс дарааллаар явагддаг бүтэн жилийг хамарсан үйл явц юм. Үүнд:

1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх.
2. Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн, жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.
3. Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах.
4. Улсын Их Хурал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор хэвлэн нийтлэх.
5. Төсвийн ерөнхийлөн захирагч дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан жилийн төсвийн хязгаарын саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 6 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх.
6. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн ерөнхийлөн захирагч (ТЭЗ)-ийн жилийн төсвийн хязгаарын саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 6 дугаар сарын 20-ны дотор Засгийн газарт хүргүүлэх.
7. Засгийн газар ТЭЗ-ийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах.
8. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор ТЭЗ-ид хүргүүлэх.

9. Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох төсвийн захирагчид төсвийн удирдамжийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлэх.

10. Орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч сум, дүүргийн Засаг даргад суурь төсвийн саналыг жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх.

11. Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлэх.

12. Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг холбогдох ТЕЗ-ид жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад, үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын саналыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор тус тус хүргүүлэх.

13. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж авахаар бол холбогдох гэрээ, хэрэгжүүлэх хөтөлбөрийг төсвийн захирагч бүрээр боловсруулж, төсвийн төслийн хамт санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх үйл явц багтана.

Ийнхүү төсвийн төслийг боловсруулахдаа дараах гол асуудалд анхаарна. Үүнд:

1. “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн 7.3 заалтад заасны дагуу төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ.
2. Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаар болон төсвийн удирдамжид заасны дагуу төсвийн төслийг боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга нь төсвийн удирдамжид Төсвийн тухай хуулийн 27.4 заалт, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д заасны дагуу дараах зүйлийг тусгана. Үүнд:

1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоо болон гаргасан шийдвэрийн тайлбар.
2. Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаар.
3. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх бодлогын удирдамж.
4. Хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад тавигдах ерөнхий болон тусгай шаардлага.
5. Төсвийн төслийн санхүүжилтийн хүсэлт гаргах ерөнхий нөхцөл.
6. Төсвийн төсөл бэлтгэх тусгай маягт, түүний заавар.
7. Төсвийн төсөл хүргүүлэх хугацаа.

8. Засгийн газрын ирэх төсвийн жилд орон нутгийн хөгжлийг дэмжихэд баримтлах бодлого, чиглэл.
9. Төсөв хоорондын шилжүүлгийн төсөөлөл.
10. Тухайн жилд гарсан бодлогын өөрчлөлтүүд.
11. Төсвийн мэдээллийн системд өгөгдөл оруулах аргачлал.
12. Бусад зүйлс багтана.

Аймаг, нийслэлийн Засаг дарга төсвийн удирдамжаас гадна мөрийн хөтөлбөр, төлөвлөлтийн бусад шаардлага, төсвийн төслийн санал хүргүүлэх хугацаатай холбоотой бусад заавар, чиглэлийг холбогдох төсвийн захирагчид хүргүүлж болно.

Төсвийн төлөвлөлтийн дараагийн үе шат нь төсвийн төслийг өргөн барьж, эрх бүхий байгууллагаар батлуулах үйл явц бөгөөд энэ нь дараах цаглабарын дагуу явагдана. Үүнд:

1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлнэ.
2. Засгийн газар жилийн төсвийн төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.
3. Засгийн газар жилийн төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын гурван өдрийн дотор нийтэд мэдээлнэ.
4. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн суурь төсвийн дэлгэрэнгүй мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 10 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ.
5. Төрийн аудитын төв байгууллага жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.
6. Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн, жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батална.
7. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
8. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батална.
9. Сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
10. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батална.
11. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батална.

12. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Орон нутгийн жилийн төсвийн төсөл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх;
2. Төсвийн тэнцэл алдагдалгүй байх;
3. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх;
4. Эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
5. Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байхыг шаарддаг.

Хүснэгт 3. ЗАВХАН АЙМГИЙН ИТХ-ААС ТӨСӨВ БАТАЛСАН ЦАГЛАБАР, 2017-2019 ОН

	Төсвийн төслийг өргөн барьсан огноо	ИТХ-аар төсөв баталсан огноо
Аймгийн 2017 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл 2018 оны төсөв батлах тухай	11/25/2017	12/04/2017
Аймгийн 2019 оны төсөв батлах тухай	11/25/2018	12/03/2018
Аймгийн 2020 оны төсөв батлах тухай	11/23/2019	12/02/2019

Эх үүсвэр: ИТХ-ын тогтоол, 2020 он

Орон нутгийн жилийн төсвийн төсөлд тавигдах шаардлагыг бүрэн хангасан эсэхийг судалж үзэхэд төсвийн жилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөг ИТХ-ын тогтоолоор батлаагүй, харин Аймгийн Засаг даргын захирамжаар батлан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4. ОРОН НУТГИЙН ЖИЛИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

	Шалгуур үзүүлэлтүүд	Шалгуур хангасан эсэх		
		2018	2019	2020
1	Төсвийг алдагдалгүй баталсан эсэх	Тийм	Тийм	Тийм
2	Үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх	Тийм	Тийм	Тийм
4	Хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх	Тийм	Тийм	Тийм
5	Эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх	Тийм	Тийм	Тийм

6	Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.	үгүй	үгүй	Үгүй
---	--	------	------	------

Эх үүсвэр: Аймгийн ИТХ-ын тогтоол, шийдвэр

Тус аймгийн 24 сумын ИТХ жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор ирэх жилийн төсвөө баталж хэвшсэн байна.

Сумын төсөв баталсан тогтоол нь шалгуурыг хангасан эсэх, мэдээллийг бүрэн багтаасан эсэхийг Отгон, Шилүүстэй сумдын 2020 оны төсөв баталсан тогтоол дээр авч үзлээ.

Отгон, Шилүүстэй сумд нь орон нутгийн төсвийг баталсан тогтоолдоо

- Сумын тухайн оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээ.
- Сумын тухайн оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ.
- Сумын тухайн оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээ.
- Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээ.
- Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүн, хөрөнгийн зардлын дүн.
- ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн.
- Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт зэргийг тусгасан байна.

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулж батлахдаа төсвийн тэнцэл алдагдалгүй байх шаардлагыг Завхан аймгийн төсвийн төлөвлөлт хангасан эсэхийг сүүлийн 3 жилийн мэдээлэлд үндэслэн үзээд ерөнхийд нь хангаж байна гэж үзлээ.

Хүснэгт 5. АЙМГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, 2018-2020 ОН, САЯ.ТӨГ

ҮЗҮҮЛЭЛТ	2018		2019		2020	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	67,153.3	нийт зарлага цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	68,576.1	нийт зарлага цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	84,016.0	нийт зарлага цэвэр зээлийн дүнд эзлэх хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	64,587.0	96.1	64,481.7	94.0	80,098.6	95.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,566.3	3.9	4,094.4	6.0	3,900.2	4.7
Нийт эх үүсвэрийн дүн	67,153.3		68,576.1		83,998.7	
Төсвийн тэнцэл	0.0		0.0		-17.3	

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

УИХ-аар баталсан 2020 оны төсвийн тухай хуульд аймгуудад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг батлахдаа орон нутгийн суурь орлого, суурь зарлагын тооцооллыг хийж, зөрүүгээр нь санхүүгийн дэмжлэгийг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 6. АЙМГУУДЫН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БАЙДАЛ, 2020 ОН, САЯ.ТӨГ

	Аймгийн нэр	Суурь орлого		Аймгийн нэр	Суурь орлого		Аймгийн нэр	Суурь орлого
1	ӨМНӨГОВЬ	138,566.0	1	ӨМНӨГОВЬ	50,864.9	1	ӨМНӨГОВЬ	87,701.1
2	ОРХОН	62,911.5	2	ОРХОН	34,320.0	2	ОРХОН	43,352.6
3	ДОРНОГОВЬ	26,973.8	3	ДОРНОГОВЬ	32,978.2	3	ДОРНОГОВЬ	6,329.5
4	ДАРХАН-УУЛ	23,467.9	4	ДАРХАН-УУЛ	32,388.0	4	ДАРХАН-УУЛ	4,360.7
5	СЭЛЭНГЭ	22,277.9	5	СЭЛЭНГЭ	28,969.6	5	СЭЛЭНГЭ	799.1
6	ТӨВ	22,024.0	6	ТӨВ	27,857.2	6	ТӨВ	-2,335.1
7	БУЛГАН	21,633.0	7	БУЛГАН	27,669.1	7	БУЛГАН	-4,677.7
8	ДОРНОД	18,601.1	8	ДОРНОД	27,303.6	8	ДОРНОД	-5,579.3
9	ӨВӨРХАНГАЙ	12,068.5	9	ӨВӨРХАНГАЙ	26,310.7	9	ӨВӨРХАНГАЙ	-7,741.3
10	ХЭНТИЙ	11,931.8	10	ХЭНТИЙ	24,724.9	10	ХЭНТИЙ	-10,364.0
11	ХӨВСГӨЛ	11,731.5	11	ХӨВСГӨЛ	22,613.1	11	ХӨВСГӨЛ	-10,753.7
12	ХОВД	11,292.0	12	ХОВД	22,574.1	12	ХОВД	-11,004.2
13	БАЯН-ӨЛГИЙ	9,870.4	13	БАЯН-ӨЛГИЙ	22,296.2	13	БАЯН-ӨЛГИЙ	-12,031.7
14	БАЯНХОНГОР	9,388.7	14	БАЯНХОНГОР	21,595.2	14	БАЯНХОНГОР	-12,793.1
15	УВС	9,080.0	15	УВС	19,569.0	15	УВС	-13,651.3
16	СҮХБААТАР	8,815.3	16	СҮХБААТАР	19,558.9	16	СҮХБААТАР	-15,235.1
17	ЗАВХАН	8,092.6	17	ЗАВХАН	17,992.8	17	ЗАВХАН	-15,551.4
18	АРХАНГАЙ	7,943.9	18	АРХАНГАЙ	17,802.0	18	АРХАНГАЙ	-19,576.5
19	ГОВЬ-АЛТАЙ	7,022.7	19	ГОВЬ-АЛТАЙ	17,611.7	19	ГОВЬ-АЛТАЙ	-19,580.9
20	ДУНДГОВЬ	5,961.1	20	ДУНДГОВЬ	17,138.4	20	ДУНДГОВЬ	-21,246.7
21	ГОВЬСҮМБЭР	5,113.6	21	ГОВЬСҮМБЭР	7,448.7	21	ГОВЬСҮМБЭР	-25,240.0
	Дүн	454,767.3		Дүн	519,586.3		Дүн	-64,819.0

Эх үүсвэр: ҮСХ-ны мэдээллийн нэгдсэн систем, 2021 он

Эндээс харахад Завхан аймгийн төсвийн суурь орлогыг 8,092.6 сая төгрөгөөр, зарлагыг 27,669.1 сая төгрөгөөр, төсвийн тэнцлийн алдагдал 19,576.5 сая төгрөгөөр улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг баталсан байна.

Аймгуудын төсвийн суурь орлого, суурь зарлага, тэнцлийг ихээх нь бага уруу нь мөнгөн дүнгээр эрэмбэлж үзэхэд Завхан аймаг нь суурь орлогын хэмжээгээр 17 дугаар байр, суурь зарлагын хэмжээгээр 7 дугаар байр, төсвийн тэнцлийн ашиг, алдагдлаар 18 дугаар байрт байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс 2012 оноос эхлэн аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтийг жил бүрээр гаргаж хэвшээд байна. 2020 оны аймгуудын өрсөлдөх чадварын судалгаанаас Завхан аймгийн эдийн засаг, төсөвтэй холбоотой зарим үзүүлэлтийг эрэмбэлж авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- **Эдийн засгийн үзүүлэлтээр 19-р байр**
- **Эдийн засгийн салбарууд 15-р байр**
- **Аймгийн төсөв 19-р байр**
- **Санхүү 12-р байранд** тус тус эрэмбэлэгдсэн байна.

Завхан аймгийн өрсөлдөх чадварын судалгааны үзүүлэлтүүдийг <http://aimagindex.mn/province/> цахим хуудаснаас дэлгэрүүлэн үзэж болно.



ГУРАВ.
ЗАВХАҢ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ТӨСВИЙН
ШИНЖИЛГЭЭ



3.1 Төсвийн орлогын гүйцэтгэлийн шинжилгээ

3.1.1 НИЙТ ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

НҮБХХ-ийн “Тогтвортой хөгжлийн зорилт 2030 хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хүрээнд хийж байгаа “Завхан аймгийн орон нутгийн төсвийн шинжилгээ”-ний нэг чухал хэсэг нь орон нутгийн төсвийн орлогын шинжилгээ юм.

Энэ хүрээнд Завхан аймгийн ИТХ-ын 2016-2020 оны тогтоол, ТЕЗ-ийн 2016-2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан болон Завхан аймаг дахь төрийн аудитын газрын “Орон нутгийн татварын нэр төрлүүдийн төлөвлөлт, гүйцэтгэл” 2018-2020 оны гүйцэтгэлийн аудит зэрэг мэдээллийг ашиглаж дүн шинжилгээ хийсэн болно.


Завхан аймгийн төсвийн нийт зарлагад аймаг өөрийн төсвийн орлогоор санхүүжүүлж буй хувь харьцааг эхний ээлжид авч үзэхэд 2016 онд нийт төсвийн зарлагын 12.8 хувийг аймгийн төсвийн орлогоор санхүүжүүлж байсан бол 2017 оноос энэ хувь хэмжээ нэмэгдэж 16.0-17.0 орчим хувь хүрсэн бөгөөд, үлдсэн 83.0 орчим хувийг дээд шатны төсвөөс авах тусламж, санхүүжилтийн орлогоор санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 7. АЙМГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

ҮЗҮҮЛЭЛТ	2016	2017	2018	2019	2020
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7
Аймгийн төсвийн орлогын дүн	7,516.8	10,573.2	10,526.5	11,562.4	12,918.7
Төсвийн орлогын нийт зарлагад эзлэх хувийн жин	12.8	17.2	16.0	17.3	16.9

Эх үүсвэр: Завхан аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан


Зураг 1. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2020 он

Түүнчлэн, аймгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнгийн жилийн өсөлтийг авч үзвэл өмнөх оноос 2017 онд 4.1 хувь, 2018 онд 9.1 хувь, 2019 онд 2.4 хувь, 2020 онд 16.6 хувиар тус тус өссөн байна.

Зураг 2. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮНГИЙН ӨӨРЧЛӨЛТ, 2016-2020 ОН




Ийнхүү өссөн шалтгааныг тогтоохын тулд төсвийн нийт орлогын бүтэц буюу ямар төрлийн орлого хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзэх шаардлагатай.

Завхан аймгийн төсвийн орлогын бүтцийг авч үзвэл 2016-2020 онд аймгийн нийт төсвийн 82.5-87.1 хувийг улсын төсвөөс авах тусламж санхүүжилтийн орлого, 11.6-13.9 хувийг татварын орлого, 1.3-4.6 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн болохыг дараах хүснэгт, зураг харуулж байна.

Хүснэгт 8. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Татварын орлого	6,771.4	11.6	8,443.1	13.9	8,445.6	12.8	9,302.8	13.8	9,292.4	11.8
Татварын бус орлого	745.4	1.3	2,130.1	3.5	2,080.9	3.2	2,259.6	3.3	3,626.3	4.6
Тусламж, санхүүжилтийн орлого	50,666.9	87.1	49,971.3	82.5	55,517.0	84.1	56,090.7	82.9	65,944.7	83.6
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	58,183.7	100.0	60,544.5	100.0	66,043.5	100.0	67,653.2	100.0	78,863.4	100.0

Зураг 3. ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, 2016-2020 ОН



Цаашид орлогын бүлэг тус бүр дээр нэр төрлөөр нь авч үзсэн. Тухайлбал, тусламжийн орлого, татварын орлого, татварын бус орлогын өөрчлөлтөд ямар нэр төрлийн орлогын өөрчлөлт хэрхэн нөлөөлснийг тодорхойлохыг зорилоо.

3.1.2 ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Улсын төсвөөс аймгийн төсөвт олгосон тусламжийн орлого нь 2017 онд өмнөх оноос 695.6 сая төгрөгөөр буурч байсан бол 2018 онд 5,545.7 сая төгрөг, 2019 онд 573.7 сая төгрөг, 2020 онд 9,854.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ


Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	11,049.2	10,606.5	13,131.0	14,482.4	18,898.0
ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	4,185.8	1,708.7	3,471.2	5,152.8	4,276.8
Тусгай зориулалтын шилжүүлэг	35,431.9	37,656.1	38,914.8	36,276.7	42,431.1
Эрүүл мэндийн даатгалын сангаас				178.9	338.8
Тусламжийн орлогын дүн	50,666.9	49,971.3	55,517.0	56,090.7	65,944.7
Өөрчлөлт /өмнөх онтой харьцуулахад/		-695.6	5,545.7	573.7	9,854.0

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2020 он

2017 онд 695.6 сая төгрөгөөр буурсан гол шалтгаан нь ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн дүн өмнөх оноос 2,477.1 сая төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Хамгийн өндөр өсөлтийг 2020 онд 9,854.0 сая төгрөгөөр өссөн өсөлт үзүүлсэн нь санхүүгийн дэмжлэг 4,415.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлэг 6,154.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

2020 онд тусламжийн орлогын дүн нэмэгдсэний дотор санхүүгийн дэмжлэгийн дүн өмнөх оноос 4,415.6 сая төгрөгөөр нэмэгджээ. Сангийн яамнаас 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 7.9 тэрбум төгрөгөөр, зарлагыг 26.8 тэрбум төгрөгөөр тус тус хянаж, УИХ-аас улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 18.9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Зураг 4. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, 2020 ОН, ТЭРБУМ.ТӨГ



2016-2020 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн тухайн жилийн бодлоготой уялдаж орон нутгийн төсөвт дараах өөрчлөлтүүд орсон нь тусламж, санхүүжилтийн орлогын дүнд нөлөөлсөн байна. Үүнд:

1. 2019 оноос орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллага, газар зохион байгуулалтын албаны байр ашиглалтын зардал /халаалт, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, түрээс, урсгал засвар үйлчилгээ/-ыг орон нутагт хариуцуулан, шаардагдах зардлыг тухайн орон нутгийн суурь зардалд нэмж тооцсон.
2. 2019 оноос орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал (тогтмол болон хувьсах)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн суурь зарлагад нэмж тусгасан.
3. 2019 оноос сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын нэр төрлийг нэмэгдүүлж, шаардагдах эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын сангаас санхүүжүүлж эхэлсэн.
4. Байнгын давтамжтай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг өрхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс шууд олгохоор тооцон 2019 оны орон нутгийн төсвөөс хассан.
5. 2020 оноос ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчийн үдийн цайг 600 төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолыг 1,650 төгрөг, дотуур байрны хоолыг 2,315 төгрөгөөр тооцож олгох болсон.
6. Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөвт төвлөрдөг байсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр, түүхий нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн орлогоос тухайн орон нутагт нь тодорхой хувийг 2019 оноос нэмж хуваарилж эхэлсэн. Ингэснээр орон нутаг өөрөө бие даан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах боломжийг бий болгосон. Үүнд: 1. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрөөр улсын төсөвт төвлөрөх орлогын 50 хувийг тухайн аймгийн орон нутгийн хөгжлийн санд; 2. Газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 30 хувийг тухайн орон нутгийн төсөвт; 3. Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн ОНХС-гийн эх үүсвэр болгон хуваарилж байна.
7. Өмнөх жилүүдэд ОНХС-гийн эх үүсвэр тогтмол буурч ирсэн бөгөөд 2017 онд хамгийн доод түвшинд хүрсэн байна, иймд 2018 оноос ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан. Үүний дотор “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс иргэдийн санаачилгыг дэмжих зорилгоор ерөнхий дэмжлэг, сумдын ОНХС-гийн үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан урамшууллыг олгодог болсон байна.
8. 2020 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоож, төсөвт байгууллагуудын зарим зардлын зарцуулалтын эрхийг бууруулж, төсвийн тодотголоор зардлыг бууруулан баталсан.

3.1.3 ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэх бөгөөд зарим нэр төрлийн татварын хувь хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд тогтоосон хязгаарт багтаан аймаг, сумын ИТХ хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд тогтоодог. Завхан аймгийн татварын орлогын бүтцийг дараах зургаар харуулав.

Зураг 5. ЗАВХАН АЙМГИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН БҮТЭЦ, ХУВИАР, 2016-2020 ОН



2016-2020 онд Завхан аймгийн төсвийн нийт орлогын 11.6-13.9 орчим хувийг татварын орлого бүрдүүлсэн бөгөөд татварын орлогын бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна.

- Татварын орлогын **66.5-75.1** хувийг орлогын албан татвар буюу хувь хүний орлогын албан татварын орлого
- Татварын орлогын **6.4-10.3** хувийг хөрөнгийн албан татвар буюу үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээврийн хэрэгслийн албан татварын орлого
- Татварын орлогын **16.9-26.0** хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого буюу улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого тус тус эзэлж байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрт ойн нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, ус рашааны нөөц, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогууд багтаж байна.

Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймгийн төсвийн орлого зарлагын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, төрийн сангийн зарлага, санхүүжилтийг гүйцэтгэх, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ, үнэлгээ хийх, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, Засаг даргын дэргэдэх агентлагуудын төсөв, санхүүгийн орлого, зарлагын үйл ажиллагаанд байнгын хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Төсвийн орлогын төлөвлөлтөд Санхүү, төрийн сангийн хэлтсийн оролцоо бага байгаа бөгөөд тус аймгийн төсвийн орлогын төлөвлөлтийг Татварын хэлтэс нь төлөвлөж хэрэгжүүлж байна. Завхан аймгийн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийн үйл явц гүйцэтгэлийн байдлыг 2018 болон 2020 оноор тооцож үзлээ.

Хүснэгт 10. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ, 2018 ОН, САЯ.ТӨГ

Зардлын зүйл	2018 он						
	Төсвийн санал	Сангийн яам хянасан	Аймгийн ИТХ-аар баталсан	Төсвийн саналд орсон өөрчлөлт	Сангийн яамны хянасан дүнд орсон өөрчлөлт	Гүйцэтгэл	Биелэлт
1. ТАТВАРЫН ОРЛОГО	5,280.3	6,656.6	6,677.5	1,397.2	20.9	7,925.5	118.7
Орлогын албан татвар	4,377.3	5,437.5	5,437.5	1,060.2	0.0	5,847.5	107.5
Хувь хүний орлогын албан татвар	5,377.3	6,267.5	6,267.5	890.2	0.0	6,772.5	108.1
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал	4,900.0	5,257.5	5,257.5	357.5	0.0	5,215.4	99.2
Үйл ажиллагааны орлого	36.5	130.0	130.0	93.5	0.0	84.9	65.3
Хөрөнгийн орлого /хүүгийн орлого/			460.8	460.8	460.8	890.2	193.2
Шууд бус орлого	440.8	880.0	419.2	-21.6	-460.8	582.0	138.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-1,000.0	-830.0	-830.0	170.0	0.0	-925.0	111.5
Хөрөнгийн орлого	371.0	418.6	439.5	68.5	20.9	651.7	148.3
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	110.0	125.0	125.0	15.0	0.0	307.4	245.9
Бууны албан татвар	41.0	49.5	49.5	8.5	0.0	55.4	111.9
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	220.0	244.1	265.0	45.0	20.9	288.9	109.0
Бусад татвар, төлбөр, хураамж	532.0	800.5	800.5	268.5	0.0	1,426.4	178.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	209.4	304.0	304.0	94.6	0.0	491.1	161.5
Улсын тэмдэгтийн хураамж	120.0	197.0	197.0	77.0	0.0	319.9	162.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	9.4	15.0	15.0	5.6	0.0	43.5	289.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	80.0	92.0	92.0	12.0	0.0	127.7	138.8
Газрын төлбөр	148.2	190.0	190.0	41.8	0.0	354.2	186.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	174.4	306.5	306.5	132.1	0.0	581.1	189.6
Үүнээс: Ойн ашигласны төлбөр	80.0	100.0	100.0	20.0	0.0	239.7	239.7
Ан амьтны нөөц ашигласны төлбөр				0.0	0.0	137.8	
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	90.0	200.0	200.0	110.0	0.0	194.8	97.4
Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр	4.4	6.5	6.5	2.1	0.0	8.8	135.4

Эх үүсвэр: Аймгийн ИТХ-ийн тогтоол, СТСХ-ын мэдээлэлд үндэслэн тооцов

2018 онд Завхан аймгийн татварын орлогын төслийг 5,280.3 сая төгрөгөөр төлөвлөснийг Сангийн яамнаас 1,397.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 6,677.5 сая төгрөгөөр хянасан байна. Ийнхүү хянахдаа хувь хүний орлогын албан татварын шууд бус орлогоос бусад нэр төрлийн орлогыг нэмэгдүүлжээ.

Аймгийн ИТХ-аар татварын орлогыг батлахдаа Сангийн яамны хянасан дүнг 20.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслэлийн татвар байна. Гүйцэтгэлээр 7,925.5 сая төгрөгийн орлого орсон нь аймгийн ИТХ-ын баталсан дүнгээс 1,248.0 сая төгрөгөөр буюу 18.7 хувиар давж биелжээ. Орлогын нэр төрлөөр төлөвлөгөөний гүйцэтгэлийг авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар, үйл ажиллагааны орлогын албан татвар, ус рашааны нөөц ашигласны төлбөрөөс бусад орлогууд 7.5-189.7 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 11. АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН БАЙДАЛ, 2020 ОН, СЯ.ТӨГ

Зардлын зүйл	2020 он						
	Төсвийн санал	Сангийн яам хянасан	Аймгийн ИТХ-аар баталсан	Төсвийн саналд орсон өөрчлөлт	Сангийн яамны хянасан дүнд орсон өөрчлөлт	Гүйцэтгэл	Биелэлт %
1. ТАТВАРЫН ОРЛОГО	6,620.3	7,598.9	7,631.0	1,010.7	32.1	9,292.4	121.8
Орлогын албан татвар	5,401.1	5,907.0	5,907.0	505.9	0.0	6,976.2	118.1
Хувь хүний орлогын албан татвар	6,261.1	6,767.0	6,767.0	505.9	0.0	7,650.0	113.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал,	5,208.0	5,481.0	5,481.0	272.0	0.0	6,534.0	119.2
Үйл ажиллагааны орлого	63.1	86.0	86.0	23.9	0.0	686.1	788.6
Хөрөнгийн орлого /хүүгийн орлого/	760.0	900.0	900.0	140.0	0.0	229.8	25.5
Шууд бус орлого	230.0	300.0	300.0	70.0	0.0	200.2	66.7
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-860.0	-860.0	-860.0	0.0	0.0	-753.1	87.6
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний ОАТ				0.0	0.0	79.2	
Хөрөнгийн орлого	407.6	611.9	644.0	236.4	32.1	749.6	116.4
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	130.0	300.0	300.0	170.0	0.0	331.9	110.6
Бууны албан татвар	46.6	54.0	54.0	7.4	0.0	59.1	109.4
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	231.0	257.9	290.0	59.0	32.1	358.5	123.6
Бусад татвар, төлбөр, хураамж	811.6	1,080.0	1,080.0	268.4	0.0	1,566.6	145.1
Бусад нийтлэг төлбөр, хураамж	290.9	319.0	319.0	28.1	0.0	407.7	127.8
Улсын тэмдэгтийн хураамж	189.0	210.0	210.0	21.0	0.0	262.3	124.9
Түгээмэлтархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.0	17.0	17.0	5.0	0.0	27.7	163.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	89.9	92.0	92.0	2.1	0.0	117.7	127.9
Газрын төлбөр	180.0	240.0	240.0	60.0	0.0	276.7	115.3
Байгалийн нөөц ашигласны төлбөр	340.7	521.0	521.0	180.3	0.0	865.5	166.1

Үүнээс: Ойн ашигласны төлбөр	120.0	180.0	180.0	60.0	0.0	324.5	180.3
Ан амьтны нөөц ашигласны төлбөр		85.0	85.0	85.0	0.0	5.3	6.2
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	214.0	250.0	250.0	36.0	0.0	318.6	127.4
Байгалийн ургамал нөөц ашигласны төлбөр	6.7	6.0	6.0	-0.7	0.0	217.1	3,618.4

Эх үүсвэр: Аймгийн ИТХ-ийн тогтоол, СТСХ-ын мэдээлэлд үндэслэн тооцов

2020 онд татварын орлогыг 6,620.3 сая төгрөгөөр төлөвлөж, хянуулсныг Сангийн яамнаас 7631.0 сая төгрөгөөр хянаж, 1010.7 сая төгрөгөөр нэмэгдүүлснийг аймгийн ИТХ-аар батлахдаа 32.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь мөн авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар байна.

Жилийн эцэст 9292.4 сая төгрөгийн татварын орлого орсон нь батлагдсан төлөвлөгөөнөөс 1661.4 сая төгрөгөөр буюу 21.8 хувиар давж биелжээ. Хувь хүний орлогын албан татварын 2 төрлийн орлого болон ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос бусад бүх нэр төрлийн орлогууд давж биелсэн байна.

Дээрхээс дүгнэлт хийхэд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлтийг хийхдээ татварын бааз, суурьт үндэслэн орлого дайчлан төлөвлөдөггүй, суурь орлогыг нэмэгдүүлж батлах эрх нь тухайн орон нутгийн ИТХ-д хуулиар олгогдсон байхад Сангийн яамнаас орон нутгийн суурь орлогыг хянасан дүнг авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвараас бусад дүнд өөрчлөлт оруулаагүй баталсан байна. Түүнчлэн “Төсвийн тухай” хуулийн 64.1.2 дахь хэсэгт тухайн жилийн төсөв, түүний тодотголыг хэлэлцэж батлах эрхи йг ИТХ-ын бүрэн эрхээр хуульчлан баталсан байхад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2019, 2020 онд аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 65 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг 250.5 сая төгрөгөөр, 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 78-р тогтоолоор аймгийн төсвийн орлогыг 982.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

Татварын ерөнхий хуулийн 8.3 заалтад заасны дагуу хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, газрын төлбөр, нохойны албан татвар, байгалийн ургамал ашигласны төлбөр, рашаан ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-аас тусгайлан эрх олгосны дагуу тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоохоор заасан. Завхан аймгийн ИТХ-аас эдгээр татвар, төлбөр, хураамжийн хувь, хэмжээг тогтоосон хязгаарт багтааж хэрхэн баталсан талаарх бүрэн хэмжээний мэдээлэл олдсонгүй тул олдсон цөөн хэдэн тогтоолуудыг танилцуулж байна.

Хүснэгт 12. АЙМГИЙН ИТХ-ААР ТОГТООСОН ТАТВАР ХУРААМЖИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Татварын нэр төрөл	ИТХ-ын тогтоол
1	Бичил худалдаа, ажил үйлчилгээ эрхлэгчдийн сард төлөх татварын хувь хэмжээг тогтоох тухай	Аймгийн ИТХ-ын 2019 оны 58-р тогтоол
2	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээг тогтоох тухай	Аймгийн ИТХ-ын 2011 оны 19 дүгээр тогтоол
3	Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх нэгж тариф	2019 оны 56 дугаар тогтоол
4	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээ тогтоох тухай	2012 оны 58 дугаар тогтоол
5	Тээврийн хэрэгслийг түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай	2018 оны 42 дугаар тогтоол
6	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам	2019 оны 51-р тогтоол

Эх үүсвэр: Аймгийн ИТХ-ийн тогтоол, Татварын хэлтсийн мэдээлэл, 2021 он

Бүх сумдад дараах төлбөр, хураамжийг хувь хэмжээг сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна. Үүнд:

- Хог хаягдлын үйлчилгээний хураамж
- Газрын үнэлгээ, төлбөрийн бүсийн хил зааг, газрын төлбөр
- Малын тоо толгойн албан татвар багтсан.

Татварын хувь хэмжээг тогтоосон тогтоолуудаас харахад хуулиар тогтоосон хязгаарын хамгийн доод хэмжээгээр тогтоосон байгаа ба зарим тогтоолуудыг цаг хугацааны хувьд ч шинэчлэх шаардлагатай гэдэг нь ажиглагдаж байна. Тухайлбал: Хуульд үл хөдлөх хөрөнгийн албан татварын хязгаарыг 0.6-1.0 хувиар тогтоосон бол аймгийн ИТХ-ын тогтоолоор 0.6 хувиар тогтоосон байна. Мөн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татварын хувь хэмжээг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан байх бөгөөд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд 2021 оны 7 сарын 07-ны өдөр орсон өөрчлөлтөөр авто болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэмжээ хязгаарт өөрчлөлт орж 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөх тул ИТХ-ын тогтоолыг шинэчлэх шаардлагатай болж байна.

Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь орлогыг тооцоходоо татвар ноогдуулах хязгаарын хамгийн доод хувь хэмжээгээр тооцдог тул ИТХ-аас хуульд заасан хязгаарын хүрээнд орон нутгийн төсвийн нийт орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм. Цаашид аймгийн ИТХ-ын зүгээс татварын хувь, хэмжээг тогтоосон эрх зүйн актуудыг эргэн харж, хуульд нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

Үл хөдлөх хөрөнгө, галт зэвсэг, газар, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийг холбогдох бүртгэлийн байгууллагаас авч Татварын хэлтсийн татварын баазын мэдээлэлтэй тулгаж үзлээ. 2020 онд Улсын бүртгэлд бүртгэлтэй 8,150 үл хөдлөх хөрөнгө байгаа ба татвар ноогдуулсан үл хөдлөх хөрөнгө 1,351 байна. Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө, орон сууц, иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц, нийтийн эзэмшлийн барилга байгууламж зэргийг үл хөдлөх хөрөнгийн татвараас чөлөөлөхөөр заасан байдаг. Харин эдгээр чөлөөлөгдөх үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг холбогдох байгууллагууд гаргаж өгөх боломжгүй гэсэн тул татвар ноогдуулах үл хөдлөх хөрөнгийн бодит зөрүүг тооцож чадаагүй болно. Авто тээврийн үндэсний төвийн харьяа Завхан аймаг дахь Авто тээврийн төвд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо Татварын хэлтсийн татвар ноогдуулсан тээврийн хэрэгслээс 11,060 тээврийн хэрэгслээр зөрүүтэй байна. 2020 онд тээврийн хэрэгслийн системийн хувьд шинэчлэл хийж, хасалт хийсэн тээврийн хэрэгслүүд нь татварын өглөгтэй учир татварын систем дээрээс хасалт хийгдээгүй, Татварын ерөнхий газар (ТЕГ) 2020 онд программын шинэчлэл хийж шинэ систем нэвтрүүлсэн бөгөөд уг шилжилттэй холбоотой галт зэвсэг эзэмшигчдийн бүртгэл давхардаж шивэгдсэн зэргээс мэдээллийн зөрүү үүссэн талаар татварын хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд танилцуулж байна. Иймд аймгийн орлогын татварыг бүрдүүлэх гол хүчин зүйлс болох татварын бааз суурийн судалгааг холбогдох байгууллагуудын баталгаажсан статистик мэдээлэлтэй тулгаж, цаашдын үйл ажиллагаандаа ашиглах нь чухал юм.

Хүснэгт 13. ТАТВАР НООГДУУЛАХ СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

ҮХХ-ийн бүртгэл	Үл хөдлөх хөрөнгө	АТБӨЯХ	Галт зэвсэг
Татварын хэлтсийн дүн	1,351	20,599	3,712
Улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө	8,150		
Авто тээврийн үндэсний төвийн харьяа Завхан аймаг дахь Авто тээврийн төвд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл		11,060	
Цагдаагийн газарт бүртгэлтэй галт зэвсэг			2,635
Зөрүү	-6,799	9,539	1,026

Эх үүсвэр: Аймгийн ТХ, УБГ, АТҮТ-ийн статистик мэдээлэл, 2021 он

Татварын орлогыг тооцохдоо бүртгэлийн байгууллагын мэдээлэлтэй тулган баталгаажуулж зөрүүг арилгах, бүртгэл мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Аймгийн татварын орлогыг сумдаар нь авч үзье.


Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум дүүргийн төсвөөс бүрддэг. 2016-2020 онд Завхан аймгийн төсөвт нийтдээ 42,255.3 сая төгрөг төвлөрсөн байх бөгөөд үүнээс дунджаар 23,6 хувь буюу 9,985.9 сая төгрөг нь сумдын төсөвт, 76,4 хувь буюу 32269.3 сая төгрөг нь аймгийн төсөвт төвлөрчээ. Жилд дунджаар сумын төсөвт 1997.2 сая төгрөг, аймгийн төсөвт 6,453.9 сая төгрөг төвлөрч байсан байна. 2016 онтой харьцуулахад суманд төвлөрсөн татварын орлого 2020 онд 1,232.6 сая төгрөг буюу 120.1 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 14. ЗАВХАН АЙМГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО АЙМАГ, СУМААР 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	Татварын нийт орлого					
	Сая. Төгрөг			Хувийн жин		
	Сум	Аймаг	Дүн	Сум	Аймаг	Дүн
2016	1,026.4	5,745.0	6,771.4	15.16	84.84	100.00
2017	1,935.5	6,507.7	8,443.1	22.92	77.08	100.00
2018	2,370.4	6,075.1	8,445.6	28.07	71.93	100.00
2019	2,394.7	6,908.2	9,302.8	25.74	74.26	100.00
2020	2,259.0	7,033.4	9,292.4	24.31	75.69	100.00
Дүн	9,985.9	32,269.3	42,255.3	23.63	76.37	100.00
5 жилийн дундаж	1997.2	6453.9				

Эх үүсвэр: Завхан аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан

Зураг 6: ЗАВХАН АЙМГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО АЙМАГ, СУМААР 2016-2020 ОН /ХУВИАР/



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2020 он

Таван жилийн дунджаар орон нутгийн татварын орлогын 23.6 хувийг сумдын төсөвт төвлөрсөн татварын орлого эзэлж байгаа бөгөөд сумдын татварын орлогод сумдын бүрдүүлсэн татварын хувийн жинг харахад Улиастай сумын бүрдүүлсэн орлого нийт татварын орлогын 22.1 хувь, Тосонцэнгэл, Их-Уул сумын бүрдүүлсэн орлого 9.9-14.0 хувь, Дөрвөлжин, Эрдэнэхайрхан, Идэр, Нөмрөг, Шилүүстэй, Яруу, Тэлмэн сумд 3.0-4.6 хувь, бусад сумд нь 1.2-2.9 хувийг тус тус бүрдүүлжээ.

Хүснэгт 15. СУМЫН ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Сумын нэр	Татварын орлого						
	2016	2017	2018	2019	2020	2016-2020 онд бүрдүүлсэн татварын нийт орлого	Хувийн жин
УЛИАСТАЙ	122.0	577.2	711.0	386.5	406.2	2,203.0	22.1
ТОСОНЦЭНГЭЛ	121.9	222.6	293.8	401.4	356.1	1,395.8	14.0
ИХ УУЛ	91.8	198.9	157.2	148.2	393.4	989.6	9.9
ДӨРВӨЛЖИН	44.6	45.4	69.1	111.7	191.7	462.4	4.6
ЭРДЭНЭХАЙРХАН	68.0	97.2	105.6	100.6	80.7	452.2	4.5
ИДЭР	51.1	72.6	116.4	97.9	98.8	436.8	4.4
НӨМРӨГ	26.7	61.6	76.4	183.3	42.2	390.2	3.9
ШИЛҮҮСТЭЙ	60.4	55.4	89.3	108.5	34.4	348.0	3.5
ЯРУУ	25.7	36.2	67.6	146.1	56.0	331.6	3.3
ТЭЛМЭН	31.3	48.7	68.3	90.4	58.1	296.9	3.0
ТҮДЭВТЭЙ	34.5	39.8	44.2	85.6	81.4	285.5	2.9
АЛДАРХААН	31.1	32.5	51.4	70.5	72.2	257.5	2.6
БАЯНХАЙРХАН	36.5	48.0	48.7	49.5	47.5	230.2	2.3
ОТГОН	23.0	35.2	51.2	63.5	42.7	215.7	2.2

ЦЭЦЭН-УУЛ	24.9	36.5	50.5	48.4	50.5	210.8	2.1
БАЯНТЭС	29.9	39.4	42.4	42.6	46.1	200.5	2.0
СОНГИНО	32.7	49.3	49.4	24.5	32.0	187.9	1.9
ТЭС	27.0	53.2	51.6	25.3	29.1	186.2	1.9
САНТМАРГАЦ	29.4	37.0	54.7	49.5	12.1	182.7	1.8
УРГАМАЛ	23.2	27.6	34.9	57.9	28.1	171.7	1.7
ЦАГААНХАЙРХАН	22.8	36.6	35.6	42.8	33.4	171.2	1.7
ЗАВХАНМАНДАЛ	28.9	28.5	36.2	16.5	32.1	142.2	1.4
АСГАТ	19.3	29.2	30.4	27.3	13.5	119.8	1.2
ЦАГААНЧУЛУУТ	19.7	26.8	34.3	16.3	20.6	117.8	1.2
Сумын төсвийн орлогын дүн	1,026.4	1,935.5	2,370.4	2,394.7	2,259.0	9,985.9	23,6
Аймгийн төсвийн орлого	5,745.0	6,507.7	6,075.1	6,908.2	7,033.4	32,269.3	76,4
Аймгийн нийт дүн	6,771.4	8,443.1	8,445.6	9,302.8	9,292.4	42,255.3	100.0

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2020 он

Үүнээс гадна татварын орлогоороо төсвийн зарлагын хэдэн хувийг санхүүжүүлж байгааг судалж үзэхэд Эрдэнэхайрхан сум хамгийн өндөр буюу 6.6 хувийг санхүүжүүлсэн бол Цагаанчулуут сум хамгийн бага буюу 1.68 хувийг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 16. СУМДЫН ТӨСВИЙН ЗАРЛАГАД ОРЛОГЫН ЭЗЛЭХ ХУВЬ, САЯ.ТӨГ

Сумын нэр	Төсвийн нийт зарлага								
	2016	2017	2018	2019	2020	016-2020 оны төсвийн зарлагын дүн	2016-2020 онд бүрдүүлсэн татварын нийт орлого	2016-2020 онд бүрдүүлсэн татварын нийт орлого	
ЭРДЭНЭХАЙРХАН	1,125.8	1,304.2	1,265.2	1,555.3	1,596.6	6,847.1	452.2	6.60	
ИХ УУЛ	2,552.8	2,714.9	2,690.5	3,362.9	3,696.6	15,017.7	989.6	6.59	
ДӨРВӨЛЖИН	1,379.1	1,327.0	1,327.6	1,614.6	1,912.5	7,560.8	462.4	6.12	
ТОСОНЦЭНГЭЛ	3,930.7	4,504.2	4,510.1	5,281.3	6,426.2	24,652.4	1,395.8	5.66	
ШИЛҮҮСТЭЙ	1,134.6	1,235.0	1,293.0	1,425.8	1,594.0	6,682.3	348.0	5.21	
ЯРУУ	1,226.2	1,081.5	1,129.1	1,365.1	1,630.1	6,431.9	331.6	5.16	
ИДЭР	1,427.8	1,655.7	1,466.2	1,871.4	2,098.8	8,519.9	436.8	5.13	
НӨМРӨГ	1,564.9	1,560.2	1,509.6	1,796.9	2,039.4	8,471.0	390.2	4.61	
ТҮДЭВТЭЙ	1,117.3	1,187.0	1,425.2	1,497.4	1,609.7	6,836.6	285.5	4.18	
АЛДАРХААН	1,101.7	1,155.0	1,173.4	1,454.9	1,596.2	6,481.1	257.5	3.97	
УЛИАСТАЙ	10,053.9	10,765.9	10,946.6	11,666.1	12,577.5	56,010.1	2,203.0	3.93	

ТЭЛМЭН	1,531.7	1,499.1	1,555.0	2,003.4	2,372.6	8,961.8	296.9	3.31
БАЯНХАЙРХАН	1,258.6	1,212.3	1,227.3	1,613.1	1,742.8	7,054.0	230.2	3.26
ЦАГААНХАЙРХАН	1,023.3	1,057.9	1,016.8	1,224.0	1,482.9	5,805.0	171.2	2.95
ЦЭЦЭН-УУЛ	1,288.3	1,339.7	1,449.7	1,623.3	1,845.0	7,546.0	210.8	2.79
СОНГИНО	1,256.4	1,287.7	1,278.7	1,575.1	1,715.0	7,112.9	187.9	2.64
ОТГОН	1,420.0	1,527.9	1,458.5	1,857.2	2,059.1	8,322.6	215.7	2.59
УРГАМАЛ	1,055.7	1,239.0	1,268.2	1,408.8	1,746.0	6,717.7	171.7	2.56
ЗАВХАНМАНДАЛ	986.8	1,114.2	1,075.7	1,285.1	1,432.6	5,894.5	142.2	2.41
САНТМАРГАЦ	1,352.3	1,407.5	1,351.5	1,678.1	2,048.2	7,837.7	182.7	2.33
БАЯНТЭС	1,830.1	1,692.3	1,760.8	2,015.2	2,304.3	9,602.6	200.5	2.09
АСГАТ	1,074.2	1,062.0	1,129.4	1,394.4	1,742.4	6,402.5	119.8	1.87
ТЭС	1,900.0	2,040.7	1,942.3	2,209.9	2,461.2	10,554.2	186.2	1.76
ЦАГААНЧУЛУУТ	1,210.0	1,184.4	1,156.2	1,608.7	1,853.0	7,012.3	117.8	1.68
Сумын дүн	43,802.3	46,155.5	46,406.5	54,387.7	61,582.7	252,334.7	9,985.9	3.96
Аймгийн төсөв	15,113.1	15,201.5	19,418.4	12,320.6	14,874.0	15,385.5	32,269.3	209.74
Дүн	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7	267,720.2	42,255.3	15.78

Эх үүсвэр: ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Аймгийн хэмжээнд төсөвт төвлөрч байгаа татварын орлого нь аймгийн төсвийн нийт зарлагын 15.8 хувийг санхүүжүүлсэн бол сумдын хэмжээнд сумын төсөвт төвлөрсөн татварын орлого нь сумын төсвийн зарлагын 10.0 хүрэхгүй хувийг санхүүжүүлсэн байна. Өөрөөр хэлбэл сумууд төсвийн нийт зарлагынхаа 90 орчим хувийг дээд шатны төсвөөс авах тусламж, санхүүжилтийн орлогоор санхүүжүүлж байна.

3.1.4 ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн орлогын нэг бүрэлдэхүүн нь татварын бус орлого бөгөөд дараах төрлийн орлогоос бүрдэнэ. Үүнд:

- Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг;
- Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;
- Хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого тус тус багтсан.

Үүнээс татварын бус орлогын бүрэлдэхүүнд төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг орон нутагт дараах байдлаар төлөвлөж, бүртгэж, тайлагнаж байна. Үүнд:

- 1. Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого**
- 2. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого**

Сум хөгжүүлэх сан нь Төсвийн тухай хуулийн 4.1.50 дах хэсэгт заасан “эргэлтийн сан” гэж үйл ажиллагаа

нь нэгээс дээш төсвийн жил дамжин байнга хэрэгжих, өөрийн эх үүсвэрийг хуульд заасан үйл ажиллагаанд зарцуулж, түүнээс орох орлого, эсхүл зарцуулсан хөрөнгийн эргэн төлөлтийг тухайн үйл ажиллагааг дахин санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай данс юм. Энэ нь бөгөөд Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-аар үйл ажиллагаа нь зохицуулагддаг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдсан сан юм. Сумын ИТХ-аар сумын төсвийг батлахдаа тухайн жилд зээл болон хүүгийн эргэн төлөлтөөс орох орлого, түүнээс буцаан олгох зээл болон сангийн үйл ажиллагаанд зарцуулах зарлагын хэмжээг баталдаг. Сум хөгжүүлэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгайлан бүлэг болгон шинжилгээ хийсэн хэсгээс харна уу.

Хүснэгт 17. ТАТВАРЫН БУС ОРЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ, 2018-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2018	2019	2020
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,080.9	2,259.6	3,626.3
Нийтлэг татварын бус орлого	2,080.9	2,259.6	3,626.3
Хувьцааны ногдол ашиг	0.0	0.0	0.0
Хүүгийн орлого	0.0	552.9	1094.3
Торгуулийн орлого	0.0	27.8	763.1
Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого	2,080.9	1,672.6	1,639.3
Үүнээс: СХС-ийн орлого	1,469.4	1,308.3	1,446.6
Төсвийн байгууллагын орлого	611.5	364.3	192.7
Бусад орлого	0.0	6.2	129.6

Эх үүсвэр: Аймгийн татварын хэлтсийн тайлан, 2021 он

Завхан аймгийн татварын бус орлогыг сүүлийн 3 жилийн үзүүлэлтээр авч үзвэл татварын бус орлогын дүн жилээс жилд өсөлттэй байгаа нь хадгаламжийн хүүгийн орлого болон “Зөрчлийн тухай” хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор хүү, торгуулийн орлого өссөн нь гол нөлөөллийг үзүүлж байна.

Завхан аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ)-ын үр дүн дараах байдлаар нэгтгэгдсэн байна.

Хүснэгт 18. ОНӨҮГ-УУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, 2020 ОН, САЯ.ТӨГ

ОНӨҮГ-ийн нэр	Хуримтлагдсан үр дүн /2020-12-31-ний өдрөөр/
Амь-Ус трейд	-1,132.0
Баруун бүсийн тамирчдыг олимпод бэлтгэх төв	-34.1
Очир-Илч	-919.5
Тосон очирт хайрхан	-926.2
Шинэ дөрвөлжин	-0.7

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Эндээс харахад ОНӨҮГ нь алдагдалтай ажиллаж байгаа тул төсөвт хувьцааны ногдол ашгийн орлогогүй байна.


УИХ-д өргөн барьсан 2022 оны төсвийн төсөлд тухайн төсвийн жилд баримтлах төсвийн төсөлд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор засаглал, бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогын шинэчлэлийг тус тус хэрэгжүүлэхээр заасан байна. Энэ бодлогын зорилтын хүрээнд Завхан аймаг ОНӨҮГ-уудын алдагдлыг бууруулж, ашигтай ажиллах, улмаар орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх талаар бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого 2018 оноос буурсан шалтгаан нь 2019 оноос эхлэн соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлогыг салбарын ажиллагчдын нийгмийн баталгааг сайжруулахад зарцуулахаар болж, эдгээр байгууллагад өөрийн орлогын төлөвлөгөө гаргаж өгөхөө больсонтой холбоотой байна.

2022 оноос мөрдөгдөх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага (ЗЗНДНТУ)-ын тухай хуульд анх удаа сумыг засаг захиргааны “үндсэн нэгж” гэж тодорхойлсон ба Төсвийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулиар анхан шатны нэгж болох сум, дүүргийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлд зарим арга хэмжээ авсан байна.

Тухайлбал, сум, дүүргийн төсөвт газрын төлбөрийн 40 хувь ордог байсныг 100 хувь болгосон. Гол хэсэг нь аймаг, нийслэлийн төсвийн орлогод хамаарч байсан хүн амын орлогын албан татварыг бүхэлд нь сум, дүүрэгт хамааруулсан. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар аймаг, нийслэлийн төсвийн орлогод орж байсныг мөн сум, дүүргийн төсвийн орлогод орохоор болсон. Малын тоо толгойн албан татварын тухай хууль батлагдаж, уг татварын орлого сум, дүүрэгт орохоор шийдвэрлэсэн. Харин аймаг, нийслэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг төвлөрүүлэх болсон. Учир нь энэ төрлийн татварын орлогыг нэмэгдүүлэх арга зам нь хувийн хэвшлийг дэмжих явдал бөгөөд уг асуудлыг аймаг, нийслэлд тодорхой хэмжээгээр хариуцуулсан гэж харагдаж байна. Орон нутгийн эдийн засгийн үндэс нь төсвийн орлогоос шууд шалтгаална. Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэхэд дээр дурдсан нэгжийн татварын болон татварын бус (өөрийн) орлогоос гадна Төсвийн тухай хуульд тусгасан улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг чухал үүрэгтэй хэвээр байхаар байна. Хуульд орсон өөрчлөлтөөр орлогын ангилалд өөрчлөлт орсон нь 2022 оноос мөрдөгдөх болсон бөгөөд үүндтэй холбогдуулан Завхан аймгийн сумдын өнөөгийн орлого болон сумаас аймаг, улсад төвлөрүүлдэг орлогыг судлахад дараах байдал ажиглагдаж байна.

ЗУРАГ 7. ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЖ БУЙ ОРЛОГО, 2021 ОН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Аймгийн татварын хэлтэс, 2021 он

2020 оны орлогын гүйцэтгэлээр Завхан аймгийн 24 сум улсын төсөвт 1,2 тэрбум, аймгийн төсөвт 7,8 тэрбум, сумын төсөвт 3,5 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байгаа нь суманд бий болж байгаа нийт орлогын 72 хувийг улс, аймгийн төсөвт төвлөрч, 28 хувь нь сумын төсөв үлдсэн байна. Тухайн онд улсын төсөвт төвлөрүүлдэг орлого 2.3 дахин (2.8 тэр.төг) багассан нь Дөрвөлжин суманд үйл ажиллагаа явуулдаг “Баян-Айраг Эксплорейшн” компаний татвар 2020 оноос өмнө аймгийн татварын орлогод бүртгэгдэн улсад шилждэг байсан бол өнгөрсөн оноос улсын татварт шууд төвлөрдөг болсонтой холбоотой. Мөн 2019 оны сүүлчээс эхлэлтэй КОВИД-19 халдварын тархалтаас үүдэн аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа санхүүгийн хямралд өртөж Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын орлогууд буурсан байна.

2022 оноос мөрдөгдөж эхлэх Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар орон нутгийн чиг үүрэг өргөжиж, тэр хэмжээгээр зардал нь нэмэгдэнэ.

Завхан аймгийн сумдын төсөвт хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 2022 онд нэмэгдэх орлогын тооцооллыг дараах байдлаар хийж байна.

Хүснэгт 19. ТАТВАРЫН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, 2020 ОН

Сумын нэр	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	Газрын төлбөр	Газрын төлбөрийн орлогын 40%	Хуулийн өөрчлөлтөөр сумын төсөвт нэмж төвлөрөх татварын дүн
АЛДАРХААН	67.0	4.2	0.6	0.2	72.1
АСГАТ	64.8	1.7	0.5	0.2	67.2
БАЯНТЭС	90.9	0.2	0.4	0.2	91.7
БАЯНХАЙРХАН	103.7	1.5	0.4	0.2	105.7
ДӨРВӨЛЖИН	328.8	75.8	138.7	55.5	598.9
ЗАВХАНМАНДАЛ	64.3	0.1	0.2	0.1	64.7
ИДЭР	95.3	1.9	0.6	0.2	97.9
ИХ-УУЛ	169.4	1.0	2.0	0.8	173.3
НӨМРӨГ	65.0	3.5	0.8	0.3	69.5
ОТГОН	73.7	0.9	0.4	0.1	75.1
САНТМАРГАЗ	85.8	1.4	0.4	0.2	87.8
СОНГИНО	101.1	0.0	0.4	0.1	101.6
ТОСОНЦЭНГЭЛ	537.8	8.7	12.2	4.9	563.5
ТҮДЭВТЭЙ	92.0	1.6	0.7	0.3	94.6
ТЭС	286.1	1.0	0.6	0.2	287.9
ТЭЛМЭН	93.7	2.2	0.9	0.4	97.2
УРГАМАЛ	67.3	2.1	0.4	0.2	70.0
УЛИАСТАЙ	3,280.0	159.4	155.3	62.1	3,656.9
ЦАГААНХАЙРХАН	64.7	1.4	0.4	0.2	66.7
ЦАГААНЧУЛУУТ	74.3	0.6	0.2	0.1	75.1

ЦЭЦЭН-УУЛ	74.2	0.8	0.3	0.1	75.3
ШИЛҮҮСТЭЙ	80.6	0.8	0.7	0.3	82.3
ЭРДЭНЭХАЙРХАН	75.7	5.1	0.6	0.2	81.6
ЯРУУ	68.1	2.0	0.3	0.1	70.5
НИЙТ ДҮН	6,104.2	278.0	317.9	127.1	6,827.2

Эх үүсвэр: Завхан аймгийн 2018-2019 оны орлогын гүйцэтгэлд үндэслэн тооцов.

2020 онд “Төсвийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт орж “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогыг нэмэлтээр тусгаж энэхүү орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна гэж заасан ба “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”-ийг баталсан. Энэхүү хуульд нэг малын тоо толгойд тухайн татварын жилд ногдуулах албан татварын хэмжээ нь 0-2,000 төгрөг байх ба албан татварын хэмжээг дээрх хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр тогтоохоор заасан. Завхан аймгийн сумдын ИТХ-аас малын тоо толгойн албан татварыг дунджаар адуунд 540, үхэрт 415, хонь 252, ямаа 351 төгрөгөөр тус тус тогтоосон байна.

Хүснэгт 20. МАЛЫН ТОО, ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛЛОЛ, 2021 ОН

Сумын нэр	Малын тоо /2020 оны жилийн эцсийн тооллогоор/						Төсвийн төсөөлөл /сая төг/
	бүгд	адуу	үхэр	тэмээ	хонь	ямаа	
АЛДАРХААН	282.9	17.4	16.9	0.5	108.6	139.6	92.4
АСГАТ	47.4	3.2	3.8	0.0	21.7	18.8	15.8
БАЯНТЭС	172.5	8.9	9.5	0.2	64.9	89.1	58.7
БАЯНХАЙРХАН	121.1	6.5	7.7	0.0	67.7	39.2	34.8
ДӨРВӨЛЖИН	176.7	12.0	4.3	2.4	64.4	93.5	62.7
ЗАВХАНМАНДАЛ	101.8	4.6	2.3	0.2	44.9	49.8	36.8
ИДЭР	125.8	10.1	10.9	0.0	70.5	34.3	43.4
ИХ-УУЛ	249.1	19.7	31.9	0.1	139.6	57.8	76.1
НӨМРӨГ	123.4	13.5	11.0	0.0	65.7	33.2	46.6
ОТГОН	202.8	13.9	14.7	0.2	99.4	74.6	97.5
САНТМАРГАЦ	155.7	10.8	6.9	0.8	72.6	64.6	47.8
СОНГИНО	124.3	8.2	7.1	0.0	65.7	43.2	37.6
ТОСОНЦЭНГЭЛ	166.1	17.8	19.0	0.0	77.1	52.1	94.7
ТҮДЭВТЭЙ	114.8	9.8	8.2	0.0	65.1	31.8	35.1
ТЭЛМЭН	150.9	12.7	11.1	0.2	92.3	34.7	88.5
ТЭС	119.2	7.7	8.3	0.1	53.2	49.9	37.5
УРГАМАЛ	114.1	6.2	2.5	2.1	53.4	49.9	32.1
ЦАГААНХАЙРХАН	99.0	4.2	6.0	0.0	47.7	41.1	26.4

ЦАГААНЧУЛУУТ	104.4	7.5	4.0	0.4	49.5	43.0	28.1
ЦЭЦЭН-УУЛ	170.4	7.2	6.8	0.3	100.5	55.7	45.2
ШИЛҮҮСТЭЙ	122.1	6.0	6.5	0.2	51.8	57.6	33.2
ЭРДЭНЭХАЙРХАН	213.4	10.3	7.3	0.2	132.5	63.2	32.9
ЯРУУ	202.5	12.5	8.3	0.1	128.4	53.2	55.7
УЛИАСТАЙ	147.3	6.4	10.1	0.1	62.6	68.3	39.5
Нийт дүн	3,607.8	236.8	225.0	8.1	1,799.8	1,338.2	1,199.1

Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (Legalinfo.mn)

3.2 ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

2016-2020 онд Завхан аймгийн төсвийн нийт зарлага 91.0-98.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан байх ба хамгийн өндөр хувийн гүйцэтгэлтэй жил нь 2018 он байсан бол хамгийн бага гүйцэтгэлтэй жил нь 2020 он байж, 7,559.3 сая төгрөг зарцуулаагүй байгаа нь улс орны хэмжээнд бий болсон цар тахлын нөхцөл байдалтай холбоотой. Учир нь 2020 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас Улсын онцгой комисс, Засгийн газрын шийдвэрээр соёл, урлаг, боловсролын байгууллагын үйл ажиллагааг хязгаарласан.

Хүснэгт 21. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2016-2020 ОН

Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн зөрүү
2016	60,158.1	58,915.3	97.9	1,242.8
2017	63,334.8	61,357.0	96.9	1,977.8
2018	67,153.3	65,824.9	98.0	1,328.4
2019	68,576.1	66,708.3	97.3	1,867.8
2020	84,016.0	76,456.7	91.0	7,559.3
Дүн	343,238.2	329,262.2	95.9	13,976.1

Эх үүсвэр: Завхан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он


Төсвийн зарлагын шинжилгээг “Төсвийн тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу дараах байдлаар хийлээ. Үүнд:

- Төсвийн шатлалаар
- Төсвийн захирагчаар
- Эдийн засгийн ангиллаар
- Хөтөлбөр, арга хэмжээгээр
- Санхүүжүүлэх эх үүсвэрээр

3.2.1 ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ -ТӨСВИЙН ШАТЛАЛААР

Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ гэж заасан. Завхан аймгийн төсвийн зарлагыг төсвийн шатлалаар нь шинжилж үзэхийн тулд нийт төсвийн зарлагын хэдэн хувийг аймгийн төсвийн зарлага, хэдэн хувийг сумын төсвийн зарлага эзэлж байгааг авч үзлээ. 2016-2020 онд Завхан аймгийн төсөв нь нийт дүнгээрээ 329262.2 сая төгрөгийн зарлага гарсны 76.6 хувийг сумын төсөв, 23.4 хувийг аймгийн төсвийн зарлага эзэлж байна. Он тус бүрээр нь авч үзвэл сумын төсвийн зарлага 70.5-81.5 хувь, аймгийн төсвийн зарлага 18.5-29.5 хувийг эзэлсэн байна.

ЗУРАГ 8. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ШАТЛАЛААР, ХУВИАР, 2016-2020 ОН



Эх үүсвэр: Завхан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

2016 оныг 2020 онтой харьцуулахад нийт төсвийн зарлага нь 29.8 хувь буюу 17541.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байх бөгөөд нийт зарлагад сумын төсвийн зарлагын эзлэх хувийн жин 6.2 хувь буюу 17780.4 сая төгрөгөөр нэмэгдэж, аймгийн төсвийн зарлагын дүн 6.2 хувь буюу 239.1 сая төгрөгөөр буурчээ. Аймгийн төсвийн зарлагад аймгийн төсвөөс шууд санхүүждэг аймгийн ЗДТГ, ИТХ, БОАЖГ, ОНӨГ гэх мэт байгууллагын зарлага хамаарна.

Аймгийн нийт төсөвт сум тус бүрийн зарлагын эзлэх хувийн жинг авч үзэхэд Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумаас бусад сумын төсөв нь 5.0-с доош хувийг эзэлж байна.

Хүснэгт 22. ЗАВХАН АЙМГИЙН СУМДЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Зарлагын дүн	Хувийн жин
ЦАГААНХАЙРХАН	1,023.3	1,057.9	1,016.8	1,224.0	1,482.9	5,805.0	2.3
ЗАВХАНМАНДАЛ	986.8	1,114.2	1,075.7	1,285.1	1,432.6	5,894.5	2.3
АСГАТ	1,074.2	1,062.0	1,129.4	1,394.4	1,742.4	6,402.5	2.5
ЯРУУ	1,226.2	1,081.5	1,129.1	1,365.1	1,630.1	6,431.9	2.5
АЛДАРХААН	1,101.7	1,155.0	1,173.4	1,454.9	1,596.2	6,481.1	2.6
ШИЛҮҮСТЭЙ	1,134.6	1,235.0	1,293.0	1,425.8	1,594.0	6,682.3	2.6
УРГАМАЛ	1,055.7	1,239.0	1,268.2	1,408.8	1,746.0	6,717.7	2.7

ТҮДЭВТЭЙ	1,117.3	1,187.0	1,425.2	1,497.4	1,609.7	6,836.6	2.7
ЭРДЭНЭХАЙРХАН	1,125.8	1,304.2	1,265.2	1,555.3	1,596.6	6,847.1	2.7
ЦАГААНЧУЛУУТ	1,210.0	1,184.4	1,156.2	1,608.7	1,853.0	7,012.3	2.8
БАЯНХАЙРХАН	1,258.6	1,212.3	1,227.3	1,613.1	1,742.8	7,054.0	2.8
СОНГИНО	1,256.4	1,287.7	1,278.7	1,575.1	1,715.0	7,112.9	2.8
ЦЭЦЭН-УУЛ	1,288.3	1,339.7	1,449.7	1,623.3	1,845.0	7,546.0	3.0
ДӨРВӨЛЖИН	1,379.1	1,327.0	1,327.6	1,614.6	1,912.5	7,560.8	3.0
САНТМАРГАЦ	1,352.3	1,407.5	1,351.5	1,678.1	2,048.2	7,837.7	3.1
ОТГОН	1,420.0	1,527.9	1,458.5	1,857.2	2,059.1	8,322.6	3.3
НӨМРӨГ	1,564.9	1,560.2	1,509.6	1,796.9	2,039.4	8,471.0	3.4
ИДЭР	1,427.8	1,655.7	1,466.2	1,871.4	2,098.8	8,519.9	3.4
ТЭЛМЭН	1,531.7	1,499.1	1,555.0	2,003.4	2,372.6	8,961.8	3.6
БАЯНТЭС	1,830.1	1,692.3	1,760.8	2,015.2	2,304.3	9,602.6	3.8
ТЭС	1,900.0	2,040.7	1,942.3	2,209.9	2,461.2	10,554.2	4.2
ИХ УУЛ	2,552.8	2,714.9	2,690.5	3,362.9	3,696.6	15,017.7	6.0
ТОСОНЦЭНГЭЛ	3,930.7	4,504.2	4,510.1	5,281.3	6,426.2	24,652.4	9.8
УЛИАСТАЙ	10,053.9	1,0765.9	10,946.6	11666.1	12577.5	56,010.1	22.2
Сумын дүн	43,802.3	46,155.5	46,406.5	54,387.7	61,582.7	252,334.7	76.6
Аймгийн төсөв	15,113.1	15,201.5	19,418.4	12,320.6	14,874.0	76,927.5	23.4
Нийт зарлагын дүн	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7	329,262.2	100.0

Эх үүсвэр: Завхан аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.2.2 ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ - ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн эдийн засгийн ангиллын дагуу төсвийг төлөвлөж, зарцуулж, тайлагнаж байгаа бөгөөд Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын дагуу төлөвлөлтийг хийж байна.


Судалгаанд Завхан аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мэдээллийг ашигласан болно.

Эдийн засгийн ангиллаар төсвийн зарлагыг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

- **Үйл ажиллагааны урсгал зардал:**
 - Цалин хөлс, нийгмийн баталгааны зардал
 - Байр ашиглалттай холбоотой зардал
 - Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардал
 - Бусад урсгал зардал
- **Хөрөнгийн зардал.**
- **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл / СХС-аас олгосон зээл/**

Судалгаанд хамрагдах хугацааны Завхан аймгийн төсвийн нийт зарлагын бүтцийг авч үзвэл нийт зардлын 91.0 хувийг үйл ажиллагааны урсгал зардал, 8.0 хувийг хөрөнгийн зардал, 1.0 хувийг зээлийн зардал эзэлж байна.


Зураг 9. АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ХУВИАР, 2020 ОН



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Он тус бүрээр төсвийн нийт зарлага, үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгийн зардал, зээлийн зардлын дүнг дараах зургаар харууллаа.

Зураг 10. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА /ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР/ Сая.Төг



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны урсгал зардалд дараах зардлуудыг хамааруулан авч үзнэ. Үүнд:

- **Цалин хөлс, нийгмийн баталгааны зардал:**
 - жишиг нормативаар тогтоосон орон тооны цалин, нэмэгдэл;
 - нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл;
 - нэг удаагийн тэтгэмж болон урамшуулал.
- **Байр ашиглалттай холбоотой зардал:**
 - түлш, халаалтын зардал;

- цахилгаан эрчим хүчний төлбөр;
- цэвэр, бохир усны төлбөр;
- байрны түрээсийн төлбөр.
- **Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны урсгал зардал дараах орцоос бүрдэнэ:**
 - бичиг хэргийн зардал;
 - тээвэр, шатахууны зардал;
 - албан томилолтын зардал;
 - нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал;
 - бага үнэтэй, түргэн элэгдэх эд зүйлсийн зардал;
 - хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал.
- **Бусад урсгал зардал дараах орцоос бүрдэнэ:**
 - бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр;
 - хичээл сургалтын зардал;
 - урсгал засварын зардал;
 - багаж, техник хэрэгслийн зардал;
 - шуудан холбоо, интернэтийн зардал;
 - ном хэвлэлийн зардал;
 - хог хаягдал зайлуулах зардал;
 - Засаг даргын нөөц хөрөнгө.
- **Хөрөнгийн зардалд дараах зардлыг хамааруулна. Үүнд:**
 - Орон нутгийн өмчийн барилга, байгууламж худалдаж авах эсхүл шинээр барих
 - Орон нутгийн өмчийн барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн их засвар
 - Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж, автомашин худалдаж авах

Хөрөнгийн зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХОС-аар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Хөрөнгийн зардлын дүн 2017 онд 3,155.3 сая төгрөг байсан нь хамгийн доод түвшинд хүрсэн тул 2018 оноос ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан. Үүний дотор “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс иргэдийн санаачилгыг дэмжих зорилгоор ерөнхий дэмжлэг, сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан урамшууллыг олгодог болсон байна. Хөрөнгийн зардлын төлөвлөлт гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг “Орон нутгийн хөрөнгө оруулалт ОНХС-ийн төлөвлөлт гүйцэтгэл” хэсэгт харууллаа.

Хөрөнгийн зардлыг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэрээр жагсаалтаар батална. Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ыг тус тус мөрдөж байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн ангилалд сумдын СХС-аас олгосон зээлийг төлөвлөн, зарцуулж, тайлагнаж байна.

СХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого нь уг сангаас олгох зээлийн эх үүсвэр болдог ба сангийн тухайн төсвийн жилийн орлого, зарлагын дүнг сумын ИТХ-аар батлан Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д заасны дагуу зарцуулна. Иймд тухайн жилд эргэн төлөлт хийгдсэн зээл, зээлийн хүүгийн орлогын дүнгээс буцааж олгох зээлийн хэмжээ хамаарна. Сум хөгжүүлэх сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Сум хөгжүүлэх сангийн төлөвлөлт, гүйцэтгэл хэсэгт харуулсан.

Хүснэгт 23. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2016		2017		2018		2019		2020		2020 оныг 2016 онтой харьцуулахад	
	ДҮН	УЗЭ %	ДҮН	УЗЭ %	ДҮН	УЗЭ %	ДҮН	УЗЭ %	ДҮН	УЗЭ %	Зардал сая Т-өөр	хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	53,540.6		56,725.1		58,044.3		59,458.5		68,886.8		15,346.2	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,095.5	82.36	44,823.9	79.02	47,865.6	82.46	58,105.4	97.72	67,672.2	98.24	23,576.7	15.88
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,804.8	53.80	28,627.5	50.47	29,854.3	51.43	36,204.2	60.89	43,552.3	63.22	14,747.5	9.42
Үндсэн цалин	23,788.0	44.43	23,726.0	41.83	22,856.2	39.38	27,474.9	46.21	31,116.3	45.17	7,328.3	0.74
Нэмэгдэл	23,34.1	4.36	2,508.9	4.42	4,379.6	7.55	5,989.2	10.07	8,765.8	12.72	6,431.8	8.37
Унаа хоолны хөнгөлөлт	49.8	0.09	60.9	0.11	188.4	0.32	268.3	0.45	327.4	0.48	277.5	0.38
Урамшуулал	1,357.3	2.54	1,051.7	1.85	1,264.0	2.18	1,798.2	3.02	2,594.7	3.77	1,237.4	1.23
Гэрээт ажлын хөлс	1,275.7	2.38	1,280.1	2.26	1,166.1	2.01	673.6	1.13	748.2	1.09	-527.5	-1.30
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,313.9	6.19	3,160.7	5.57	3,592.9	6.19	4,554.5	7.66	5,728.5	8.32	2,414.6	2.13
Тэтгэврийн даатгал	2,279.8	4.26	2,190.6	3.86	2,496.5	4.30	3,151.0	5.30	4,006.6	5.82	1,726.8	1.56
Тэтгэмжийн даатгал	196.0	0.37	223.8	0.39	262.4	0.45	364.2	0.61	443.1	0.64	247.1	0.28
ҮОМШӨ-ний даатгал	245.1	0.46	218.3	0.38	219.9	0.38	276.6	0.47	343.5	0.50	98.4	0.04
Ажилгүйдлийн даатгал	63.4	0.12	55.7	0.10	61.5	0.11	69.0	0.12	91.5	0.13	28.2	0.01
Эрүүл мэндийн даатгал	529.6	0.99	472.3	0.83	552.6	0.95	693.7	1.17	843.7	1.22	314.1	0.24
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,904.4	9.16	5,448.7	9.61	5,778.6	9.96	6,284.8	10.57	7,495.3	10.88	2,591.0	1.72
Гэрэл, цахилгаан	354.9	0.66	373.2	0.66	389.7	0.67	460.0	0.77	397.2	0.58	42.2	-0.09
Түлш, халаалт	4,400.6	8.22	4,915.3	8.67	5,219.3	8.99	5,657.6	9.52	6,940.0	10.07	2,539.4	1.86
Цэвэр, бохир ус	137.6	0.26	151.6	0.27	161.1	0.28	167.0	0.28	158.2	0.23	20.5	-0.03
Байрны түрээс	11.2	0.02	8.6	0.02	8.6	0.01	0.3	0.00	0.0	0.00	-11.2	-0.02
Хангамж, бараа материалын зардал	1,344.7	2.5	1,360.4	2.4	1,772.8	3.1	1,751.9	2.9	1,930.8	2.8	586.0	0.29
Бичиг хэрэг	159.2	0.30	178.1	0.31	225.7	0.39	295.2	0.50	332.2	0.48	173.1	0.19
Тээвэр, шатахуун	786.5	1.47	860.9	1.52	1,034.4	1.78	1,072.2	1.80	1,002.5	1.46	216.0	-0.01
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125.6	0.23	124.5	0.22	136.9	0.24	158.2	0.27	205.7	0.30	80.1	0.06
Ном, хэвлэл	17.7	0.03	17.0	0.03	20.6	0.04	21.0	0.04	47.2	0.07	29.5	0.04
Хог хаягдал зайлуула х, х ортон мэрэгчдийн устгал, ариутгал	51.5	0.10	44.8	0.08	66.5	0.11	17.8	0.03	20.4	0.03	-31.1	-0.07
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204.3	0.38	135.0	0.24	288.7	0.50	187.6	0.32	322.8	0.47	118.5	0.09
Нормативт зардал	2,643.5	4.94	2,572.8	4.54	2,702.1	4.66	2,991.8	5.03	2,428.8	3.53	-214.7	-1.41
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300.3	0.56	337.9	0.60	317.1	0.55	452.8	0.76	437.3	0.63	137.0	0.07
Хоол, хүнс	2,252.8	4.21	2,110.4	3.72	2,219.3	3.82	2,368.2	3.98	1,782.0	2.59	-470.8	-1.62
Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.4	0.17	124.5	0.22	165.7	0.29	170.8	0.29	209.5	0.30	119.1	0.14
Эд хогшил, урсгал засварын зардал	341.3	0.64	473.9	0.84	549.5	0.95	453.4	0.76	384.2	0.56	42.9	-0.08
Багаж, техник, хэрэгсэл	27.2	0.05	30.5	0.05	32.5	0.06	97.6	0.16	136.3	0.20	109.1	0.15
Тавилга	27.3	0.05	0.0	0.00	4.7	0.01	3.1	0.01	17.2	0.02	-10.1	-0.03

Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3.4	0.01	0.0	0.00	0.0	0.00	3.4	0.01	6.5	0.01	3.1	0.00
Урсгал засвар	283.4	0.53	443.3	0.78	512.3	0.88	349.3	0.59	224.2	0.33	-59.2	-0.20
Томилолт, зочны зардал	207.6	0.39	230.5	0.41	255.1	0.44	484.3	0.81	214.6	0.31	7.0	-0.08
Дотоод албан томилолт	207.6	0.39	230.5	0.41	255.1	0.44	484.3	0.81	214.6	0.31	7.0	-0.08
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	957.8	1.79	978.5	1.73	1,260.7	2.17	2,825.8	4.75	2,599.3	3.77	1,641.5	1.98
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	925.6	1.73	947.2	1.67	1,231.9	2.12	2,580.8	4.34	2,328.9	3.38	1,403.3	1.65
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8.4	0.02	8.5	0.01	8.6	0.01	14.2	0.02	19.7	0.03	11.3	0.01
Даатгалын үйлчилгээ	10.6	0.02	7.6	0.01	7.0	0.01	18.2	0.03	19.6	0.03	9.0	0.01
Тээврийн хэрэгслийн татвар	3.3	0.01	3.3	0.01	6.7	0.01	6.5	0.01	7.6	0.01	4.3	0.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	0.5	0.00	1.0	0.00	1.1	0.00	2.3	0.00	2.3	0.00	1.8	0.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7.6	0.01	7.8	0.01	2.0	0.00	7.5	0.01	215.1	0.31	207.5	0.30
Газрын төлбөр	1.1	0.00	1.0	0.00	0.3	0.00	4.1	0.01	4.6	0.01	3.6	0.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.7	0.00	2.1	0.00	3.2	0.01	192.2	0.32	1.4	0.00	0.7	0.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,577.5	2.95	1,970.7	3.47	2,099.5	3.62	2,554.6	4.30	3,338.5	4.85	1,761.0	1.90
Бараа үйлчилгээний бусад зардал	1,555.8	2.91	1,918.1	3.38	1,812.6	3.12	2,063.7	3.47	2,645.1	3.84	1,089.3	0.93
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21.7	0.04	52.7	0.09	286.8	0.49	491.0	0.83	693.4	1.01	671.7	0.97
ТАТААС	20.0	0.04	29.5	0.05	20.3	0.03	34.0	0.06	13.8	0.02	-6.2	-0.02
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20.0	0.04	29.5	0.05	20.3	0.03	34.0	0.06	13.8	0.02	-6.2	-0.02
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,425.1	17.60	1,1871.7	20.93	1,0158.4	17.50	1,319.0	2.22	1,200.8	1.74	-8224.2	-15.86
Бусад урсгал шилжүүлэг	9,425.1	17.60	1,1871.7	20.93	1,0158.4	17.50	1,319.0	2.22	1,200.8	1.74	-8224.2	-15.86
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,921.4	12.93	6,944.5	12.24	7,245.5	12.48	278.3	0.47	127.1	0.18	-6794.3	-12.74
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12.7	0.02	476.5	0.84	51.6	0.09	47.3	0.08	68.5	0.10	55.8	0.08
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	689.8	1.29	660.5	1.16	723.0	1.25	724.1	1.22	383.7	0.56	-306.1	-0.73
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,328.1	2.48	883.0	1.56	1,144.0	1.97	247.8	0.42	563.1	0.82	-765.0	-1.66
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	349.0	0.65	1,692.4	2.98	865.3	1.49	0.0	0.00	0.0	0.00	-349.0	-0.65
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124.0	0.23	1,214.8	2.14	129.1	0.22	21.5	0.04	58.4	0.08	-65.6	-0.15

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Төсвийн байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2020 оны гүйцэтгэлийг 2016 оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 15,346.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байх ба энэ нь бараа, ажил үйлчилгээний зардлын бүлгийн дүн 23,576.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, татаасын дүн 6.2 сая төгрөгөөр буурсан, урсгал шилжүүлгийн дүн 8,224.2 сая төгрөгөөр буурснаас тус тус шалтгаалсан байна.

Бараа, ажил үйлчилгээний зардлын дүн 15,346.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 14,747.5 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 2,414.6 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 2,591.0 сая төгрөг, үүний дотор түлш халаалтын зардал 2,539.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урсгал зардлын өөрчлөлтөд дараах хүчин зүйл нөлөөлсөн. Үүнд:

- 2019, онд Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэн.
- Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн дагуу төрийн үйлчилгээний албан хаагчид ажилласан жилийн нэмэгдэл авдаг болсон. Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах бодлого баримтлан цалин, нэмэгдэл хөлсийг нэмэгдүүлсэн.
- Нийгмийн даатгалын тухай хуулиар шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн.
- Төсвийн жилүүдэд төсвийн байгууллагын тээвэр шатахуун, түлш халаалтын зардлыг индексжүүлэн нэмэгдүүлэх бодлого баримталсан ба 2016-2020 онд нийт соёлын төв 4, эрүүл мэндийн төв 3, цэцэрлэг 8, ЕБС-ын хичээлийн байр 5, сумдын ЗДТГ-ын барилга 4 шинээр ашиглалтад орсон. Мөн Завхан аймгийн 21 сум нэгдсэн халаалтад холбогдож төрийн үйлчилгээний барилга, байгууламжийн халаалтын зардал нэг дахин өссөн.
- 2020 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласан тул нормативт зардал, үүний дотор хоол хүнс, үдийн цайны зардлын хэмжээ өмнөх онуудаас буурсан.
- Байнгын давтамжтай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг өрхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс шууд олгохоор тооцон 2019 оны орон нутгийн төсвөөс хассантай холбоотойгоор урсгал шилжүүлгийн зардал, түүний дотор нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ буурсан.

Завхан аймгийн төсвийн урсгал үйл ажиллагааны зардлын бүтцийг 2020 оны тоон мэдээлэл дээр тулгуурлан авч үзлээ. 2020 оны байдлаар урсгал үйл ажиллагааны зардалд зардал тус бүрийн эзлэх хувийн жин дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 24. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2020	
	дүн	Урсгал зардалд эзлэх хувь
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,552.3	63.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,728.5	8.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,495.3	10.9
Хангамж, бараа материалын зардал	1,930.8	2.8
Нормативт зардал	2,428.8	3.5
Эд хогшил, урсгал засварын зардал	384.2	0.6
Томилолт, зочны зардал	214.6	0.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,599.3	3.8
Бараа үйлчилгээний бусад зардал	3,338.5	4.8
ТАТААС	13.8	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,200.8	1.7
Бусад урсгал шилжүүлэг	1,200.8	1.7


Зураг 11. ЗАВХАН АЙМГИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН БҮТЭЦ, 2020 ОН



Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол

Завхан аймгийн 2020 оны урсгал зарлагын 82.4 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байгаа нь 2016 оноос 19.1 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 12. НИЙТ ЗАРДАЛД ЦАЛИН, ТОГТМОЛ ЗАРДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2016-2020 ОН



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Дээрх судалгаанаас харахад жил бүр цалин тогтмол зардлын нийт зардалд эзлэх хувь өсөж, хангамж бараа материалын болон бусад зардлуудын нийт зардалд эзлэх хувь жилээс жилд буурсаар байгаа нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх болон төрийн үйлчилгээний чанар үр дүнд сөрөг нөлөөллийг бий болгох юм.

3.2.3 ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ -ТӨСВИЙН ЗАХИРАГЧААР

Төсвийн тухай хуулиар төрийн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр заасны дагуу аймгийн Засаг дарга нь тусгай шилжүүлгийн байгууллагын хувьд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж, холбогдох улсын төсвийн ерөнхийлөн захирагч буюу яамдын сайдуудтай гэрээ байгуулан ажилладаг. Үүнд:

- БСШУСайдтай Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ), Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн төсвийн талаар


- Эрүүл мэнд (ЭМ)-ийн Сайдтай эрүүл мэндийн анхан шатны байгууллагын төсвийн талаар
- Барилга, хот байгуулалт (БХБ)-ын Сайдтай газрын харилцаа, кадастрын төсвийн талаар
- Хөдөлмөр, нийгмийн хамгаалал (ХНХ)-ын Сайдтай хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээний төсвийн талаарх гэрээг байгуулснаар орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болдог.

Судалгаанд хамрагдаж байгаа жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлэгт дараах бодлогын шинжтэй өөрчлөлтүүд гарсан нь төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөвт нөлөөлж, орон нутгийн төсвийн суурь зарлага, тусгай шилжүүлгийн санхүүжилтийн дүнд нөлөөлсөн байна. Үүнд:

1. 2019 оноос орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, эмнэлэг, хүүхдийн байгууллага, газар зохион байгуулалтын албаны байр ашиглалтын зардал /халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, түрээс, урсгал засвар үйлчилгээ/-ыг орон нутагт хариуцуулан шаардагдах зардлыг тухайн орон нутгийн суурь зардалд нэмж тооцсон.
2. 2019 оноос орон нутгийн музей, соёлын төв, номын сан, театр, биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал (тогтмол болон хувьсах)-ыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн суурь зарлагад нэмж тусгасан.
3. 2019 оноос сум, өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцын нэр төрлийг нэмэгдүүлж шаардагдах эх үүсвэрийг ЭМД-ын сангаас санхүүжүүлж эхэлсэн.
4. 2020 оноос ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчийн үдийн цайг 600 төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолыг 1,650 төгрөг, дотуур байрны хоолыг 2,315 төгрөгөөр тооцож олгох болсон.
5. Төрийн албаны тухай шинэчилсэн хуулийн үйлчлэлтэй холбоотойгоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн, нэмэгдүүлж баталсан бөгөөд төрийн үйлчилгээний албан хаагчид ажилласан жилийн нэмэгдэл, тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмж авдаг болсон, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлого баримталсан.
6. 2020 онд цар тахлын нөхцөл байдлын улмаас бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоож, төсөвт байгууллагуудын зарим зардлын зарцуулалтын эрхийг бууруулж, төсвийн тодотголоор зардлыг бууруулан баталсан.

Аймгийн нийт төсвийн зарлагад төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрийн эзлэх хувийн жинг тооцож үзэхэд дараах дүр зураг харагдаж байна.

Зураг 13. ЗАВХАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА /ТЕЗ-ААР/



Эх үүсвэр: Төсвийн ерөнхийлөн захирагчийн зардлын тайлан, 2021

Аймгийн нийт төсвийн зарлагын 51.2 хувийг БСШУСайдын багцын байгууллагууд буюу боловсролын байгууллагын төсөв, 38.7 хувийг аймгийн Засаг даргын багцын буюу орон нутгийн төсөвт байгууллагын төсөв, 9.1 хувийг ЭМ-ийн Сайдын багцын буюу өрхийн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвийн төсөв, 0.3 хувийг ХНХ-ын Сайдын багцад хамаарах Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)-ын төсөв, 0.6 хувийг БХБ-ын Сайдын багцад хамаарах Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (ГХБХБГ)-ын төсөв тус тус эзэлж байна.

Хүснэгт 25. АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЗҮЙЛЭЭР ӨӨРЧЛӨЛТ, 2016-2020 ОН, СЯА.ТӨГ, ХУВИАР

ТЕЗ	Байгууллага	2016	2017	2018	2019	2020	2020 оныг 2016 онтой харьцуулсан	
БСШУС	ЕБС	19,818.0	21,430.1	21,570.0	24,009.1	28,281.6	8,463.55	42.7
	СӨБ	7,737.4	8,101.8	8,617.3	9,795.2	10,882.9	3,145.47	40.7
	Соёлын үйлчилгээ	2,268.1	2,447.8	2,419.1			(2,268.05)	(100.0)
	Нийтийн биеийн тамир	230.3	329.4	629.2			(230.32)	(100.0)
	БСШУС-ын дүн	30,053.8	32,309.0	33,235.6	33,804.2	39,164.5	9,110.65	30.3
ЭМС	ЭМ-ийн анхан шатны үйлчилгээ	5,199.8	5,216.5	5,281.6	6,737.5	7,615.0	2,415.27	46.4
ХНХС	Хүүхэд хамгаалал	154.7	158.9	190.5	283.6	317.8	163.05	105.4
БХБС	Газрын харилцаа кадастр	236.3	221.6	444.1	527.6	649.5	413.22	174.9
	Тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн зарлагын дүн	35,644.6	37,906.1	39,151.8	41,352.9	47,746.8	12,102.19	34.0
АЗД	Орон нутгийн төсөв	23,270.7	23,450.9	26,673.0	25,355.4	28,709.9	5,439.2	23.4
Нийт дүн		58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7	17,541.4	57.3

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Хүснэгтээс харахад тусгай шилжүүлгийн төсвийн зарлага 2020 онд 47,746.8 сая төгрөг байгаа нь 2016 онтой харьцуулахад 12,102.2 сая төгрөгөөр буюу 34.0 хувиар өссөн байна. Үүнд:

Хүснэгт 26. ЗАВХАН АЙМГИЙН ТУСГАЙ ШИЛЖҮҮЛГИЙН ТӨСВИЙН ӨСӨЛТ, САЯ ТӨГРӨГ, ХУВИАР

Үзүүлэлт	Дүн	Өсөлт хувиар
Ерөнхий боловсролын сургуулийн төсөв	84,63.6	42.7
Сургуулийн өмнөх боловсролын төсөв	31,45.5	40.7
Эрүүл мэндийн байгууллагын төсөв	24,15.2	46.4
Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын төсөв	1,63.1	105.4
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төсөв	413.2	174.9

Аймгийн Засаг дарга буюу орон нутгийн төсөвт байгууллагын төсвийн зарлага нь 2020 онд 2016 онтой харьцуулахад 5,439.2 сая төгрөгөөр буюу 23.4 хувийн өсөлттэй байна.

Эндээс хамгийн өндөр өсөлттэй нь ГБХЗХГ, ГХБХБГ-ын төсөв байна. ГХБХБГ-ын төсөв 413.2 сая төгрөг буюу 174.9 хувиар өссөн шалтгааныг судалж үзэхэд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нийт өсөлтийн 91.9 хувийг эзэлж байна. Энэ нь нэг талаас Төрийн албаны тухай хуулийн шинэчлэл, төрийн албан хаагчдын цалингийн өсөлттэй холбоотой боловч голлох шалтгаан нь орон тооны өсөлт буюу 2016 онд 66 орон тоотой байсан бол 2020 онд 83 болсон нь сумын ЗДТГ-аас газрын даамлууд шилжиж ирсэнтэй холбоотой орон тоо болон зардал нэмэгдсэн байна.

ГБХЗГ-ын төсөв 163.1 сая төгрөг буюу 105.4 хувиар өссөн байх бөгөөд цалин хөлс, шимтгэлийн зардлын өсөлт нийт өсөлтийн 21.1 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 51.0 хувиар өссөн нь тус тус голлон нөлөөлсөн байна. Энэ өсөлтөд хүүхэд харах үйлчилгээний зардал гол нөлөөллийг үзүүлсэн байна.

3.2.4 ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ - САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР

Завхан аймаг 2016-2020 онд нийт дүнгээрээ 329,262.2 сая төгрөгийн төсвийн зарлага гаргасны 57.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 33.5 хувийг орон нутгийн төсвөөс, 5.7 хувийг ОНХНС-аас, 2.8 хувийг төсвийн байгууллагын өөрийн орлогоос, 0.2 хувийг ЭМД-ын сангаас санхүүжүүлсэн байна.


Хүснэгт 27. АЙМГИЙН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	Дүн	Хувийн жин
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7	329,262.2	
ЗАР ДЛЫГ САНХҮҮЖ ҮҮЛЭХЭХ ҮҮСВЭР	59,472.8	60,664.0	66,149.3	66,691.6	76,746.5	329,724.2	100.0
Тусгай шилжүүлгээс	35,431.9	37,656.1	38,914.8	36,276.7	42,431.1	190,710.7	57.8
ЭМД Сангаас				178.9	338.8	517.7	0.2
ОНХНС-аас	4,185.8	1,708.7	3,471.2	5,152.8	4,276.8	18,795.3	5.7

Орон нутгийн төсвөөс	18,185.2	19,169.1	21,682.4	23,410.6	28,060.4	110,507.7	33.5
Үүнээс: Санхүүгийн дэмжлэг	11,049.2	10,606.5	13,131.0	14,482.4	18,898.0	68,167.1	61.6
Орон нутгийн орлого	7,136.0	8,562.6	8,551.4	8,928.2	9,162.4	42,340.6	38.4
Төсөвт байгууллагын өөрийн орлогоос	1,669.8	2,130.1	2,080.9	1,672.6	1,639.3	9,192.8	2.8

Эх үүсвэр: Санхүүгийн тайлан, 2021 он


Зураг 14. ЗАВХАН АЙМГИЙН ЗАРДЛЫН ЭХ ҮҮСВЭР, ХУВИАР, 2016-2020 ОН



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

2016-2020 онд Завхан аймгийн төсвийн нийт зарлагын 11.9-14.1 хувийг орон нутаг өөрийн орлогоороо бүрдүүлжээ.

Зураг 15. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР, ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ХАРЬЦАА, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

3.2.5 ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ - ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГЭЭР

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа санхүүжилтийг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх; хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байхаар хуульчилсан бөгөөд Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловруулах журам"-ын 7.5.6-д аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр гаргаж төсвийн төслийн хавсралт байдлаар боловсруулж Аймаг сумын ИТХ-аас тухайн жилийн төсвийг баталсан тогтоолын нэгдүгээр хавсралтаар

батлах загвар маягтыг баталсан байна.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, зардлын зориулалт болон арга хэмжээний ангиллыг баталсан.

Аймаг сумын ИТХ-аас тухайн жилийн төсвийг баталсан тогтоолын нэгдүгээр хавсралтаар тухайн жилийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээг баталж байна. Ингэхдээ төсвийн захирагч болон чиг үүргээр хуваарилсан төсвийг хөтөлбөрийн ангиллын дагуу нэгтгэн, зорилт, хүрэх үр дүнг баталж байгаа боловч хөтөлбөрийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн зарцуулалтын гүйцэтгэлээр тооцож байна.

Завхан аймгийн 2020 төсвийн хөтөлбөрийн гүйцэтгэлийг доорх байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

Хүснэгт 28. ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ-ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГЭЭР, 2020 ОНЬ САЯ.ТӨГ

	Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
1	71502 Хот байгуулалт, тохижилт	779.9	782.3	100.3	-2.5
2	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	995.7	995.7	100.0	0.0
3	71105 Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр	13.8	13.8	100.0	0.0
4	72208 Ахмад настны хөгжил хамгаалал	94.2	94.2	100.0	0.0
5	71601 Нийгмийн эрүүл мэнд	1,079.1	1,074.1	99.5	4.9
6	70417 Мэргэжлийн хяналт	188.3	186.7	99.1	1.6
7	71101 Авто зам	1,257.6	1,238.1	98.4	19.5
8	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	7,744.8	7,615.0	98.3	129.8
9	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	325.4	317.8	97.7	7.6
10	70105 Орон нутгийн өөрөө удирд ёсны байгууллагын үйл ажиллагаа	2,423.9	2,353.4	97.1	70.5
11	71702 Соёл урлаг	3,705.2	3,572.5	96.4	132.7
12	71504 Газрын зураглал, кадастр	675.7	649.5	96.1	26.2
13	70106 ОН-ын гүйцэтгэх Засаглалын удирдлага	11,197.9	10,687.1	95.4	510.8
14	71403 Ойжуулалт	134.8	128.1	95.0	6.7
15	71902 Нийгмийн халамж	136.3	127.1	93.3	9.2
16	71802 Ерөнхий боловсрол	30,747.8	28,585.6	93.0	2162.2
17	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	170.8	157.4	92.2	13.4
18	71801 Сургуулийн өмнөх боловсрол	12,901.7	11,194.4	86.8	1707.3
19	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	6,576.0	5,014.5	76.3	1561.6
20	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	415.3	277.9	66.9	137.4
21	72210 Малчид,хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн Засагт ажиллагчдыг дэмжих	2,439.8	1,390.6	57.0	1049.2
22	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	12.0	0.9	7.2	11.1
	Дүн	84,016.0	76,456.7	91.0	7,559.4

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021 он

Хүснэгтээс харахад хот байгуулалт, тохижилт (71,502), хүрээлэн буй орчны бодлого, удирдлага (71,411), авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр (71,105), ахмад настны хөгжил, хамгаалал (72,208) хөтөлбөрүүдийн биелэлт 100.0 хувийн биелэлттэй байгаа бол сургуулийн өмнөх боловсрол (71,801) хөтөлбөр 86.8 хувийн гүйцэтгэлтэй, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт (70,503) хөтөлбөр 76.3 хувийн гүйцэтгэлтэй, мал аж ахуйг хөгжүүлэх (70,801) хөтөлбөр 66.9 хувийн гүйцэтгэлтэй, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн засагт ажиллагчдыг дэмжих (72,210) хөтөлбөр 57.0 хувийн гүйцэтгэлтэй, насан туршийн болон албан бус боловсрол (71,806) хөтөлбөр 7.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт 22 хөтөлбөрөөс 4 хөтөлбөрийн гүйцэтгэл 100.0 хувь, 13 хөтөлбөрийн гүйцэтгэл 99.5-92.2 хувь, 5 хөтөлбөрийн гүйцэтгэл 86.8-7.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ.

Нийт зарлагын гүйцэтгэл 91.0 хувь буюу 7,559.4 сая төгрөгөөр зардал хэмнэгдсэн мэт боловч хөтөлбөрийн гүйцэтгэлийг авч үзэхэд ерөнхий боловсрол (71,802) хөтөлбөр 2,162.2 сая төгрөг, сургуулийн өмнөх боловсрол (71,801) хөтөлбөр 1,707.3 сая төгрөг, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт (70,503) хөтөлбөр буюу ОНХС 1,561.6 сая төгрөг, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон албан бус эдийн Засагт ажиллагчдыг дэмжих (72,210) хөтөлбөр буюу сум хөгжүүлэх сан 1,049.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн дүнгээс дутуу зарцуулагдсан байна. Ийнхүү дутуу зарцуулагдсан нь КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас сургууль, цэцэрлэгийн танхимын үйл ажиллагааг зогсоосон болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа удааширсан, түүнчлэн сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Дээрх тайлангаас харахад хөтөлбөрийн гүйцэтгэлийн хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн байдлыг тайлагнаагүй зөвхөн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг тайлагнасан байна.

Ийнхүү төсвийн ангиллын дагуу зарлагын шинжилгээг хийхээс гадна төсвийн хуваарилалтын тэгш байдал, орон нутгийн иргэд төсвөөс хэрхэн үр ашгийг хүртэж байгааг судалж үзэх нь ач холбогдолтой юм.

3.2.6 НЭГ ХҮНД НОГДОХ ТӨСВИЙН ЗАРЛАГА

Нэг хүнд ногдох төсвийн зарлагын дүнг эхлээд тооцож үзье.

Хүснэгт 29. НЭГ ХҮНД НОГДОХ ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Сумын нэр	2016	2017	2018	2019	2020	Зарлагын дүн	Хүн амын тоо	1 хүнд ногдох төсвийн зарлага
АСГАТ	1,074.2	1,062.0	1,129.4	1,394.4	1,742.4	6,402.5	807	7.9
ЭРДЭНЭХАЙРХАН	1,125.8	1,304.2	1,265.2	1,555.3	1,596.6	6,847.1	1,034	6.6
ЗАВХАНМАНДАЛ	986.8	1,114.2	1,075.7	1,285.1	1,432.6	5,894.5	933	6.3
УРГАМАЛ	1,055.7	1,239.0	1,268.2	1,408.8	1,746.0	6,717.7	1,119	6.0
ЦАГААНЧУЛУУТ	1,210.0	1,184.4	1,156.2	1,608.7	1,853.0	7,012.3	1,173	6.0
ЦАГААНХАЙРХАН	1,023.3	1,057.9	1,016.8	1,224.0	1,482.9	5,805.0	1,002	5.8
НӨМРӨГ	1,564.9	1,560.2	1,509.6	1,796.9	2,039.4	8,471.0	1,608	5.3
САНТМАРГАЦ	1,352.3	1,407.5	1,351.5	1,678.1	2,048.2	7,837.7	1,564	5.0
СОНГИНО	1,256.4	1,287.7	1,278.7	1,575.1	1,715.0	7,112.9	1,421	5.0
ЦЭЦЭН-УУЛ	1,288.3	1,339.7	1,449.7	1,623.3	1,845.0	7,546.0	1,542	4.9


БАЯНХАЙРХАН	1,258.6	1,212.3	1,227.3	1,613.1	1,742.8	7,054.0	1,639	4.3
БАЯНТЭС	1,830.1	1,692.3	1,760.8	2,015.2	2,304.3	9,602.6	2,291	4.2
ДӨРВӨЛЖИН	1,379.1	1,327.0	1,327.6	1,614.6	1,912.5	7,560.8	1,835	4.1
ТҮДЭВТЭЙ	1,117.3	1,187.0	1,425.2	1,497.4	1,609.7	6,836.6	1,672	4.1
ЯРУУ	1,226.2	1,081.5	1,129.1	1,365.1	1,630.1	6,431.9	1,576	4.1
ТЭЛМЭН	1,531.7	1,499.1	1,555.0	2,003.4	2,372.6	8,961.8	2,293	3.9
ШИЛҮҮСТЭЙ	1,134.6	1,235.0	1,293.0	1,425.8	1,594.0	6,682.3	1,715	3.9
ТЭС	1,900.0	2,040.7	1,942.3	2,209.9	2,461.2	10,554.2	2,720	3.9
ИДЭР	1,427.8	1,655.7	1,466.2	1,871.4	2,098.8	8,519.9	2,205	3.9
ОТГОН	1,420.0	1,527.9	1,458.5	1,857.2	2,059.1	8,322.6	2,282	3.6
УЛИАСТАЙ	10,053.9	10,765.9	10,946.6	11,666.1	12,577.5	56,010.1	17,485	3.2
ТОСОНЦЭНГЭЛ	3,930.7	4,504.2	4,510.1	5,281.3	6,426.2	24,652.4	7,899	3.1
АЛДАРХААН	1,101.7	1,155.0	1,173.4	1,454.9	1,596.2	6,481.1	2,091	3.1
ИХ УУЛ	2,552.8	2,714.9	2,690.5	3,362.9	3,696.6	15,017.7	5,018	3.0
Дүн	43,802.3	46,155.5	46,406.5	54,387.7	61,582.7	252,334.7	64,924	3.9

Эх үүсвэр: Завхан аймгийн эдийн Засаг, нийгмийн жилийн танилцуулга-2020 он, судлаачийн тооцоолол

Хүснэгтээс харахад 1 хүнд ногдох төсвийн зарлагын дундаж нь 3.9 сая төгрөг байгаа бөгөөд дунджаас доогуур Отгон, Улиастай, Тосонцэнгэл, Алдархаан Их-Уул сумууд байна. Нэг хүнд ногдох төсвийн зарлагын дүнгээрээ Асгат, Эрдэнэхайрхан, Завханмандал, Ургамал, Цагаанчулуут сумууд хамгийн өндөр буюу 6.0-7.9 сая төгрөг байна. Хамгийн өндөр үзүүлэлттэй Асгат сумын дүнг хамгийн бага үзүүлэлттэй Их-Уул сумын дүнтэй харьцуулахад Асгат сумын дүн Их-Уул сумын дүнгээс 2.6 дахин их буюу 4.9 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь хүн амын тоо цөөн сумдын нэг хүнд ноогдох зардал өндөр харин олон хүн амтай сумдын нэг хүнд ноогдох зардал бага байгаатай холбоотой.

Завхан аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 2020 оны хэмжээ 2016 онтой харьцуулахад 488807.8 сая төгрөг болж, 60.8 хувиар өссөн бол төсвийн зарлагын хэмжээ нь 29.8 хувиар өсжээ. Ингэснээр төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин нь 2016-2020 онд жилээс жилд буурч, 2016 онд 19.4 хувь байсан бол 2020 онд 15.6 хувь болон 3.8 хувиар буурчээ. Өөрөөр хэлбэл ДНБ-ийн өсөлт нь төсвийн зарлагын өсөлтөөс түрүүлж байна гэдгийг харуулж байна.

ЗУРАГ 16. ДНБ-Д ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХАРЬЦАА, ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, судлаачийн тооцоолол

Төсвийн үр ашгийн бас нэг үзүүлэлт нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн асуудал юм.

3.2.7 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТӨСӨВ

2020 оны статистикийн мэдээллээр Завхан аймагт төрийн өмчийн 197, хувийн өмчийн 6, нийт 203 сургуулийн өмнөх боловсролын байгууллага буюу цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, түүнд 720 багш, ажилчид ажиллаж, нийтдээ 5245 хүүхэд хамрагдсан байна.

2020 онд Завхан аймгийн 203 цэцэрлэгийн зарлага 10,882.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд нийт 5,245 хүүхэд сургуулийн өмнө боловсролын байгууллагад хамрагдаж, 1 хүүхдэд дунджаар 2.1 сая төгрөг зарцуулсан байна. Үүнийг сум сумаар нь задалж, дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 30. ЗАВХАН АЙМГИЙН СӨБ-ЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ЗАРЛАГА, САЯ.ТӨГ

Сумын нэр	2020 оны төсвийн зарлага	Хүүхдийн тоо		1 хүүхдэд ногдох нийт зарлага	Байр ашиглалтын тогтмол зардал	Хувьсах зардал	1 хүүхдэд ногдох хувьсах зардал
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл				
ЯРУУ	213.4	88	66	3.2	11.7	201.7	3.1
ЦАГААНЧУЛУУТ	277.9	108	91	3.1	39.0	238.9	2.6
ЭРДЭНЭХАЙРХАН	167.4	90	55	3.0	14.6	152.8	2.8
АЛДАРХААН	155.6	80	54	2.9	22.7	132.9	2.5
УРГАМАЛ	239.4	100	93	2.6	26.6	212.8	2.3
ЗАВХАНМАНДАЛ	246.1	104	98	2.5	19.4	226.7	2.3
ЦАГААНХАЙРХАН	174.8	79	73	2.4	9.8	165.0	2.3
САНТМАРГАЦ	287.2	140	130	2.2	42.9	244.3	1.9
АСГАТ	212.4	110	101	2.1	19.4	193.0	1.9
ШИЛҮҮСТЭЙ	252.1	125	121	2.1	17.6	234.5	1.9
УЛИАСТАЙ	3,782.7	2,120	1,830	2.1	400.2	3382.5	1.8
ИХ-УУЛ	677.4	343	335	2.0	63.1	614.3	1.8
СОНГИНО	237.6	125	119	2.0	28.7	208.9	1.8
ТЭС	371.6	200	189	2.0	44.0	327.6	1.7
ТҮДЭВТЭЙ	180.9	113	92	2.0	14.0	166.9	1.8
БАЯНХАЙРХАН	201.9	115	103	2.0	5.3	196.6	1.9
ЦЭЦЭН-УУЛ	209.0	101	107	2.0	7.8	201.1	1.9
ИДЭР	260.3	175	134	1.9	35.2	225.1	1.7
ДӨРВӨЛЖИН	260.8	140	136	1.9	48.2	212.6	1.6
ТОСОНЦЭНГЭЛ	1,380.7	810	722	1.9	88.3	1292.4	1.8
ОТГОН	222.0	150	117	1.9	14.8	207.2	1.8
ТЭЛМЭН	319.7	195	171	1.9	43.1	276.6	1.6
НӨМРӨГ	191.9	94	107	1.8	25.1	166.8	1.6
БАЯНТЭС	360.0	202	201	1.8	12.2	347.8	1.7
	10,882.8	5,907	5,245	2.1	1,053.7	9,829.1	1.9

Эх үүсвэр: Аймгийн БСУГ-ын санхүүгийн тайлан, 2020 он

Хүснэгтээс харахад нэг хүүхдэд ногдох төсвийн зарлага нь Яруу, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан, Алдархаан, Ургамал, Завханмандал, Цагаанхайрхан, Сантмаргац суманд аймгийн дунджаас илүү байгаа бол Асгат, Шилүүстэй, Улиастай суманд аймгийн дундаж хэмжээнд, бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна.

Энэ нь төсвийн зарлагыг хэр үндэслэлтэй төлөвлөж, зарцуулсан болохыг харуулах нэг үзүүлэлт юм. Түүнчлэн төсвийг төлөвлөхдөө эрх бүхий байгууллагын баталсан нормативыг баримталж буй эсэх, нормативын дагуу төлөвлөж санхүүжүүлсэн бол гүйцэтгэлийн үзүүлэлтийг нормативтай хэрхэн уялдуулж байгааг авч үзэх шаардлагатай. Манай өнөөгийн практикт санхүүжилтийг батлагдсан хэмжээгээр олгож, харин үр дүнгийн гол үзүүлэлттэй уялдуулахгүй байна. Жишээ нь: сумын цэцэрлэгт 150 хүүхдээр тооцож төлөвлөсөн бол төлөвлөсөн хэмжээгээрээ санхүүжилт олгож, ингэхдээ гүйцэтгэл нь 120 хүүхэд эсвэл, 160 хүүхэд байгаа эсэхийг харгалзаж үзэхгүй байна. Өөрөөр хэлбэл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн үзүүлэлтийг тодорхой болгож, төсвийн зарцуулалттай уялдуулах нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсвөөс иргэдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг чанартай хүргэх зэрэг ач холбогдолтой.

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ аймгийн төвд 812.3 мянган төгрөг, аймгийн төвөөс бусад суманд 998.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Завхан аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын гүйцэтгэлийг тооцож үзэхэд аймгийн дундаж нь 1.9 сая төгрөг байгаа нь Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын нормативаас дунджаар 2 дахин илүү байна. Үүний шалтгаан нь 2016 оноос хойш үнийн өсөлт, инфляц, цалингийн өсөлт зэргийг харгалзан үзэж нормативыг шинэчлээгүйтэй холбоотой. Яруу, Цагаанчулуут, Эрдэнэхайрхан, Алдархаан, Ургамал, Завханмандал, Цагаанхайрхан сумдын хувьсах зардлын хэмжээ нь аймгийн дунджаас илүү, Сантмаргац, Асгат, Шилүүстэй сумдын хувьд аймгийн дундаж хэмжээнд, бусад сумууд аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

Зураг 17. СӨБ-ЫН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, 2020 ОН




Эх үүсвэр: Аймгийн БСУГ-ын санхүүгийн тайлан, 2020 он

Завхан аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зардлын бүтцийг 2020 оны мэдээлэл дээр тулгуурлан шинжилж үзэхэд нийт зардлын 77.8 хувийг цалин, шимтгэлийн зардал, 9.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 2.0 хувийг хангамж, бараа материалын зардал, 7.7 хувийг нормативт зардал, 0.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.1 хувийг томилолтын зардал, 0.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний зардал, 1.7 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

3.2.8 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ТӨСӨВ

Завхан аймгийн статистикийн мэдээллээр 2020 оны байдлаар 30 ерөнхий боловсролын сургуульд 15,535 хүүхэд суралцаж, 912 багш ажиллаж байна.

Зураг 18. АЙМГИЙН НИЙТ СУРАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, 2016-2020 ОН



Эх үүсвэр: Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн жилийн танилцуулга

Эдгээр 30 сургуульд зарцуулсан төсвийн шинжилгээг 2020 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл дээр үндэслэн дараах байдлаар хийлээ.


Хүснэгт 31. ЕБС-ИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ, 2020 ОН, САЯ.ТӨГ

Зардлын бүлэг	2020 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувийн жин
Цалин шимтгэл	23,624.8	22,535.5	79.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,023.9	3,849.6	13.6
Хангамж, бараа материалын зардал	502.7	454.0	1.6
Нормативт зардал	853.0	534.9	1.9
Эд хогшил, урсгал засварын зардал	51.9	36.3	0.1
Томилолт, зочны зардал	70.8	29.0	0.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175.5	106.8	0.4
Бараа үйлчилгээний бусад зардал	359.8	336.4	1.2
Урсгал шилжүүлэг	649.5	399.2	1.4
Дүн	30,312.0	28,281.6	100.0

Эх үүсвэр: Аймгийн БСУГ-ын санхүүгийн тайлан, 2020 он

Завхан аймгийн ЕБС-ийн төсвийн нийт зарлагын 79.7 хувийг цалин, шимтгэлийн зардал, 13.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.6 хувийг хангамж, бараа материалын зардал, 1.9 хувийг нормативт зардал, 0.1 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.1 хувийг томилолтын зардал, 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 1.2 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал, 1.4 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг 19. ЗАВХАН АЙМГИЙН ЕБС-ИЙН ЗАРДЛЫН БҮТЭЦ



Эх үүсвэр: Аймгийн БСУГ-ын санхүүгийн тайлан, 2020 он

Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит ЕБС-ийн бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг дараах байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 32. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ, МЯН.ТӨГ

Байршил	Сургуулийн ангилал	Багшийн цалин			Ажил олгогчийн төлөх шимтгэл			Бусад хувьсах зардал	Нийт хувьсах зардал		
		Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бага анги	Дунд анги	Ахлах анги		Бага анги	Дунд анги	Ахлах анги
Аймгийн төвөөс бусад сум	Багийн бага сургууль	576.8			63.5			42.8	683.1		
	Суурь боловсролын сургууль	309.0	481.0		34.0	52.9		21.9	364.9	555.9	
	Бүрэн дунд боловсролын сургууль	288.3	417.0	438.8	31.7	45.9	48.3	14.6	334.6	477.5	501.7
Аймгийн төв болон нийслэлийн захын дүүрэг	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	271.6	392.7	400.4	29.9	43.2	44.0	13.9	315.4	449.8	458.4
Нийслэл	Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургууль	246.7	355.1	373.6	27.1	39.1	41.1	13.1	286.9	407.3	427.8

Эх үүсвэр: БСШУЯ-ны мэдээллийн сайтаас

2020 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээллээс харахад ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ Засгийн газрын тогтоолоор баталсан нормативаас өндөр дүнтэй байгаа бөгөөд үүний шалтгаан нь 2016 оноос хойш үнийн өсөлт, инфляц, цалингийн өсөлт зэргийг харгалзан үзэж нормативыг шинэчлээгүйтэй холбоотой. Иймд боловсролын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэх, үнийн өсөлт, инфляцтай уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож байх зайлшгүй шаардлага байна.

Завхан аймгийн сумдын ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын тооцооллыг нийт суралцагчийн тоогоор хийсэн болно.

Хүснэгт 33. ЕБС-ИЙН ХУВЬСАХ ЗАРДЛЫН ТООЦООЛЛОЛ, 2020 ОН, САЯ.ТӨГ

Сумын нэр	2020 оны төсвийн зарлага	Хүүхдийн тоо	1 хүүхдэд ногдох нийт зарлага	Байр ашиглалтын тогтмол зардал	Хувьсах зардал	1 хүүхдэд ногдох хувьсах зардал
ЦАГААНХАЙРХАН	496.7	101	4.9	17.5	479.2	4.7
АЛДАРХААН	454.0	83	5.5	66.9	387.1	4.7
ЯРУУ	467.0	117	4.0	24.1	442.8	3.8
ЗАВХАНМАНДАЛ	647.9	161	4.0	43.4	604.5	3.8
ЭРДЭНЭХАЙРХАН	546.4	155	3.5	70.8	475.6	3.1
ЦЭЦЭН-УУЛ	767.6	273	2.8	50.1	717.4	2.6
ЦАГААНЧУЛУУТ	722.9	223	3.2	166.0	556.9	2.5
ДӨРВӨЛЖИН	680.1	228	3.0	127.3	552.8	2.4
САНТМАРГАЦ	874.2	306	2.9	145.5	728.7	2.4
БАЯНХАЙРХАН	690.0	275	2.5	38.0	652.0	2.4
УРГАМАЛ	576.3	208	2.8	117.1	459.2	2.2
АСГАТ	691.2	263	2.6	119.7	571.5	2.2
ШИЛҮҮСТЭЙ	769.8	344	2.2	43.5	726.3	2.1
ТҮДЭВТЭЙ	854.3	325	2.6	207.3	647.0	2.0
НӨМРӨГ	845.2	359	2.4	177.4	667.9	1.9
ОТГОН	817.6	411	2.0	55.5	762.1	1.9
ТЭЛМЭН	1,055.2	502	2.1	191.2	864.0	1.7
БАЯНТЭС	950.1	550	1.7	38.8	911.3	1.7
ИДЭР	934.0	468	2.0	171.9	762.1	1.6
СОНГИНО	640.6	338	1.9	90.6	550.0	1.6
ТЭС	1,134.3	633	1.8	203.5	930.8	1.5
ТОСОНЦЭНГЭЛ	3,467.3	2417	1.4	458.4	3008.9	1.2
УЛИАСТАЙ	7,488.0	5357	1.4	1159.0	6329.1	1.2
ИХ УУЛ	1,711.1	1438	1.2	66.3	1644.8	1.1
Дүн	28,281.6	15,535.0	64.5	3,849.6	24,432.0	1.6

Эх үүсвэр: БСУГ-ын санхүүгийн тайлан, судлаачийн тооцоолол

Завхан аймгийн хэмжээнд ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ нь 2020 оны байдлаар дунджаар 1.6 сая төгрөг байгаа бөгөөд Идэр, Сонгино сумд аймгийн дундаж хэмжээнд, Тэс, Тосонцэнгэл, Улиастай, Их-Уул сумд аймгийн дунджаас доогуур, бусад сумд нь аймгийн дунджаас илүү үзүүлэлттэй байна.

Цагаанхайрхан, Алдархаан сумдын ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ 4.7 сая төгрөг байгаа нь аймгийн дунджаас даруй 3 дахин, Яруу, Завханмандал, Эрдэнэхайрхан сумд аймгийн дунджаас 2.4 дахин их үзүүлэлттэй байна. Нэг хүүхдэд ноогдох зардлаар хамгийн их үзүүлэлттэй Цагаанхайрхан, хамгийн бага үзүүлэлттэй Их Уул сумдын ЕБС-ийн 2020 оны төсвийн гүйцэтгэлд үндэслэн нөлөөллийг тооцож үзэхэд сургуулийн нийт хувьсах зардлын 91.1-93.4 хувийг цалин шимтгэлийн зардал эзэлж байна.

Хүснэгт 34. ЕБС-ИЙН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2020 ОН, САЯ.ТӨГ

Үзүүлэлт	Цагаанхайрхан сумын ЕБС		Их Уул сумын ЕБС	
	2020 он			
	Төсвийн гүйцэтгэл		Төсвийн гүйцэтгэл	
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	496.7		1,711.0	
Үүнээс : ХУВЬСАХ ЗАРДАЛ	479.2		1,644.8	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384.1		1,364.4	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52.3		172.3	
АЖИЛЛАГСДЫН ТОО	33		115	
СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	103.0		1,365	
Нэг суралцагчид ноогдох хувьсах зардал	4.7		1.1	
Нэг суралцагчид ноогдох багш ажилчдын тоо	0.3		0.08	
Нийт хувьсах зардалд цалин, шимтгэлийн зардлын эзлэх хувь	91.1		93.4	

Эх үүсвэр: БСУГ-ын санхүүгийн тайлан, судлаачийн тооцоолол

Цагаанхайрхан сумын ЕБС-ийн сурагчдын тоо, Их Уул сумын ЕБС-ийн сурагчдын тооноос 13.2 дахин бага, харин багш ажилчдын тоо 3.2 дахин бага байна. Хэдийгээр сурагчдын тоо цөөн ч стандартаар байх шаардлагатай багш ажилчдын тоо, түүнд олгож байгаа цалин шимтгэлийн зардал нь цөөхөн хүүхэдтэй сургуулиудын нэг хүүхдэд ноогдох хувьсах зардал өндөр байхад шууд нөлөөлж байна.

3.2.9 ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСӨВ

Завхан аймгийн эрүүл мэндийн салбарын тоон үзүүлэлтийг аймгийн статистикийн мэдээллээс авч төсвийн зарлагатай уялдуулан шинжилгээ хийлээ.

2020 оны байдлаар Завхан аймагт эрүүл мэндийн 110 байгууллага үйл ажиллагаа явуулснаас орон нутгийн төсвөөс 19 сумын эмнэлэг, өрхийн 3 эмнэлэг нийт 22 байгууллага санхүүжиж, нийт 7,615.0 сая төгрөг зарцуулсан байна.

Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн жилийн танилцуулга



ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд нийт эрүүл мэндийн салбарын 110 байгууллага, 1136 эмч, ажилтан ажиллаж, 50 эмнэлэг, 50 эмийн сан, эм ханган нийлүүлэх төвүүд үйл ажиллагаа явуулж байна.

Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн жилийн танилцуулга

Хүснэгт 6.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Эрүүл мэндийн байгууллагын тоо	4545	3,155.3	6,366.7	5,670.2	6,179.3
Аймаг хөдөөгийн нэгдсэн, сум дундын эмнэлгийн тоо	4,185.8	1,708.7	3,471.2	5,152.8	4,276.8
Сумын эмнэлэг	359.7	1,446.6	2,895.4	517.4	1,902.5
Хувийн эмнэлэг					
Хувийн эмийн сан					
Эм ханган нийлүүлэх төв					
Эргэлтийн эмийн сан					
Эрүүл мэндийн салбарын ажиглагсадын тоо					
Их эмч					
Эм зүйч					

Завхан аймгийн сумдын төсвийн зарлагын гүйцэтгэлийг сумын хүн амын тоотой харьцуулж авч үзэхэд орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын хувьд нэг хүнд ногдох аймгийн дундаж зардал 140.0 мянган төгрөг байгаа бөгөөд энэ үзүүлэлтийг сум тус бүрээр авч үзэхэд Их-Уул, Улиастай сумаас бусад сум аймгийн дунджаас илүү байна.

Энэ нь Их-Уул болон Улиастай сум бусад сумтай харьцуулахад хүн амын тоо олон, нягтрал ихтэй холбоотой, түүнчлэн эдгээр сумдын хүн амын эмнэлгийн тусламж үйлчилгээ авах зардал нь бусад сумынхтай харьцуулахад бага байна.

Хүснэгт 35. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ, САЯ ТӨГ, ХҮНИЙ ТОО

Сум	2020 оны төсвийн гүйцэтгэл	Сумын хүн ам	Сумын 1 хүнд ногдох эмнэлгийн төсвийн зардал	ЭМД-ын санхүүжилт
АСГАТ	292.9	807	0.36	1.2
ЦАГААНХАЙРХАН	318.9	1,002	0.32	9.2
ЭРДЭНЭХАЙРХАН	324.4	1,034	0.31	14.1
УРГАМАЛ	329.7	1,119	0.29	10.7
ЦАГААНЧУЛУУТ	330.2	1,173	0.28	11.1
СОНГИНО	350.0	1,421	0.25	15.7
ЦЭЦЭН-УУЛ	342.5	1,542	0.22	15.4
ДӨРВӨЛЖИН	397.1	1,835	0.22	18.8
ЯРУУ	326.5	1,576	0.21	17.2
САНТМАРГАЦ	319.8	1,564	0.20	7.0
НӨМРӨГ	323.5	1,608	0.20	17.2
БАЯНХАЙРХАН	315.9	1,639	0.19	15.8
АЛДАРХААН	382.4	2,091	0.18	12.9
БАЯНТЭС	404.7	2,291	0.18	22.5
ОТГОН	401.5	2,282	0.18	15.7
ТЭЛМЭН	401.1	2,293	0.17	28.4
ИДЭР	380.7	2,205	0.17	24.6
ТЭС	403.8	2,720	0.15	26.5
ИХ-УУЛ	555.3	5,018	0.11	54.7
УЛИАСТАЙ-ӨРХИЙН ЭМНЭЛЭГ	714.1	17,485	0.04	
Дүн	7,615.0	52,705	0.14	338.8

Эх үүсвэр: Аймгийн ЭМГ-ын тайлан, 2021 он

2020 оноос эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйг шинэчлэн, эрүүл мэндийн багц хуульд өөрчлөлт оруулсан. Ингэснээр эмнэлгүүд үзсэн, эмчилсэн хүний тоогоор ЭМД-ын сангаас санхүүжилт авч, эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэхээр болсон бөгөөд 2020 онд Завхан аймгийн эмнэлгүүд ЭМД-ын сангаас авсан санхүүжилтийн хэмжээг харьцуулж авч үзлээ.

Завхан аймгийн эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагууд 2020 онд 423.6 сая төгрөгийн санхүүжилтийг ЭМД-ын сангаас авах төлөвлөгөөтэй байсан боловч гүйцэтгэлээр 338.8 сая төгрөгийн санхүүжилт авсан нь төлөвлөснөөс 84.8 сая төгрөгөөр дутуу байна.

ЭМД-ын сангийн санхүүжилтийг эмнэлгийн байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр болгож баталснаар эмнэлгийн үйлчилгээ авсан хүний тоо багасаж, төлөвлөсөн хэмжээндээ санхүүжилт авч чадахгүй бол эмнэлгийн ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх байтугай зардлаа бүрэн хэмжээнд санхүүжүүлж чадахгүйд хүрэх эрсдэл байна гэж үзэж байна. Иймд ЭМД-ын сангийн санхүүжилт нь эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөшүүрэг болж чадаж байгаа эсэхийг нарийвчлан судлах шаардлагатай.

3.3 Тусгай сангийн төсвийн шинжилгээ

3.3.1 ОНХС-ИЙН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ

Зардлын эдийн засгийн ангилалд дурдагдсан хөрөнгийн зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-аар төлөвлөж хэрэгжүүлнэ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын эх үүсвэр нь орон нутгийн төсвийн давсан орлого, дансны үлдэгдэл болон улсын төсвөөс орон нутгийн суурь зардалд тооцон олгосон хөрөнгийн зардлаас бүрдэж байна. Тус аймагт 2018 онд улсын төсвөөс орон нутгийн төсвийн суурь зарлагад 2,8 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд тооцон олгосон байна. Бусад жилүүдэд орон нутгийн төсвийн давсан орлого дансны үлдэгдлээс орон нутгийн хөрөнгө оруулалтад хуваарилан зарцуулсан байна.

Хүснэгт 36. ЗАВХАН АЙМГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, 2016-2020 ОН, СЯ.ТӨГ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Хөрөнгийн зардал	4545.46	3,155.3	6,366.7	5,670.2	6,179.3
ОНХС	4,185.8	1,708.7	3,471.2	5,152.8	4,276.8
ОНХО	359.7	1,446.6	2,895.4	517.4	1,902.5

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн тайлан, 2021 он

Тус аймгийн хувьд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын гол эх үүсвэр нь ОНХС-ийн хөрөнгө байна.

ОНХС-ийн үйл ажиллагааг засаг, захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 86 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан "ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-аар зохицуулж байна.

ОНХС нь дараах эх үүсвэрээс бүрдэж байна:

- **Тухайн жилийн татварын давсан орлогын дахин хуваарилалт**
- **Төсөл, хөтөлбөрийн байгууллагын дэмжлэг, тусламж**
- **ОНХНС-аас аймаг, сумдад хуваарилсан хөрөнгө**

Төсвийн тухай хуулиар ОНХНС-ийн хөрөнгийг аймаг, нийслэлд хуваарилахдаа дараах итгэлцүүрийг үндэслэн тогтоож байна.

- а** Орон нутгийн хөгжлийн индекс;
- б** Хүн амын тоо;
- в** Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ;
- г** Орон нутгийн татварын идэвх санаачилга;

ОНХС-ийн шинэчилсэн журмаар сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг “Төсвийн тухай” хуулийн 58 дугаар зүйлд заасан чиг үүрэг тус бүрээр дэлгэрүүлж оруулсан ба өрхийн орлогыг дэмжих, ажлын байр бий болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сургалт, сурталчилгааг санхүүжүүлэх чиг үүргүүд нэмэгдсэн. Мөн малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг нэмсэн.

ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэгч шалгаруулалт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, тайлагнал зэргийг ОНХС-ийн удирдлага, мэдээллийн системээр дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлэх, тайлагнах зохицуулалт орсон байна.

Хүснэгт 37. ОНХС БОЛОН МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАХ ЧИГ ҮҮРЭГ

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэг		Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх чиг үүрэг
Аймаг	Сум	
Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийг дэмжих	Иргэдийн эрүүлмэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологийг дэмжих	Бэлчээрийн менежментийг сайжруулах
Дэд бүтцийг сайжруулах /зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ/	Дэд бүтцийг сайжруулах /зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ/	Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх
Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах	Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах	Малын эрүүл мэндийг хамгаалах
Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах	Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
Аймгийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төсөв боловсруулах	Сумын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах	Малын чанарыг сайжруулах
Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх	Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах	Гэмт халдлага, гамшгаас хамгаалах Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх
Өрхийн орлогыг дэмжих чиглэл ээригэдийг чадавхжуулах сургалт, ажлын байр бий болгох	Өр хийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;	Малын тэжээлийн ургамал тариалах Тэжээлийн нөөц бүрдүүлэх Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа хийх


Ажлын байр бий болгох;
Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
сургалт, сурталчилгаа.

Хортон мэрэгчтэй тэмцэх, байгаль
орчныг хамгаалах

Эх үүсвэр: ОНХС-ийн үйл ажиллагааны шинэчилсэн журам, 2021 он

Завхан аймгийн ОНХС-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг сүүлийн 5 жилээр судалж үзэхэд 2016 онд 4,185.8 сая төгрөг байсан бол 2017 онд 1,708.7 сая төгрөг болсон нь хамгийн доод түвшинд хүрсэн тул 2018 оноос ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан. Үүний дотор "Тогтвортой амьжиргаа-3" төслөөс иргэдийн санаачилгыг дэмжих зорилгоор ерөнхий дэмжлэг, сумдын ОНХС-ийн үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд суурилсан урамшууллыг олгодог болсон байна. Ингэснээр ОНХС 2018 онд 20.3 хувиар 2019 онд 48.4 хувиар өсч, харин 2020 онд 17 хувиар буурсан байна.


Зураг 20. ЗАВХАН АЙМГИЙН ОНХС-ИЙН ГҮЙЦЭТГЭЛ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн тайлан, 2021 он

ОНХС бий болсноор аймаг, нийслэлд олгосон ОНХС-ийн шилжүүлгийн орлогын 70-аас доошгүй хувийг сум, дүүрэгт хуваарилж байсан бол 2017 оноос 30 хувь болж буурсан байна. Мөн Төсвийн тухай хуульд 2018 онд орсон өөрчлөлтөөр усны хөнгөлөлт, мал эмнэлгийн үйлчилгээ, нийтийн тээврийн үйлчилгээ, хөнгөлөлт, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулахтай холбогдох урсгал зардлыг ОНХС-аас санхүүжүүлдэг болсон байна.

Зураг 21. ЗАВХАН АЙМГИЙН ОНХС-ИЙН БҮТЭЦ, 2018-2020 ОН, САЯ ТӨГ, ХУВИАР



Эх үүсвэр: Завхан аймгийн ИТХ-ын тогтоол, санхүүгийн тайлангаас тооцов

ОНХС-ийн хөрөнгөөр хийсэн нийт хөрөнгө оруулалтын 10.6 хувийг боловсролын салбарт, 11.8 хувийг эрүүл мэндийн салбарт, 15.7 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 6.8 хувийг байгаль орчинд, 7.7 хувийг усан

хангамжид, 12.9 хувийг барилга байгууламжид, 3.6 хувийг төрийн удирдлагын үйл ажиллагаанд зарцуулж 30.9 хувийг тээвэр, холбоо, цахилгаанжуулалт зэрэг дэд бүтцийг сайжруулахад зарцуулсан байна.

Зураг 22. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ САЛБАРААР, 2018-2021 ОН, СЯЯ.ТӨГ




Төсвийн тухай хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг хэрэгжүүлэх гол асуудал нь төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, төсвийн гүйцэтгэл, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаанд иргэдийг оролцуулж, хяналт тавих боломж нөхцөлөөр хангаж, төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг шийдвэртээ хэрхэн тусгасан болон төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж байх үйл явц юм.

Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд “Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах” талаар тусгасан. Энэ нь ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шат бүрт хэрэгжиж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдтэй хамтран төлөвлөж хэрэгжүүлдэг бөгөөд энэ үйл явцад баг, хорооны Засаг даргаас эхлээд баг, хорооны иргэдийн Нийтийн хурал болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал хүртэлх бүх шатны байгууллагууд оролцон, хамтын шийдвэр гаргадаг. Тус аймгийн ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо хангасан байдлыг <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/> цахим сайтын мэдээллээс судлахад ОНХС-ийн төлөвлөлтөд оролцох иргэдийн оролцоо 2018 оноос 5.6 дахин нэмэгдэж, иргэдийн оролцоо сайжирсан байна.

Зураг 23. ОНХС-ИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ИРГЭДИЙН ОРОЛЦОО, 2018-2020 ОН, ХҮНИЙ ТОО




ОНХС-ийн төлөвлөлт гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайланд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг иргэдийн санал, асуулгад үндэслээгүй, хуулиар хориглосон орон

нутгийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн, зураг төсөвгүй, ТЭЗҮ батлагдаагүй хөтөлбөр арга хэмээг санхүүжүүлсэн талаар дурдсан байна.

Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2016 оноос хэрэгжүүлж буй Тогтвортой амьжиргаа-3 төслөөс орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 2017 оноос дэмжлэг үзүүлж сумдын ОНХС-гийн жилийн гүйцэтгэлд үнэлгээ хийж, сайн гүйцэтгэлтэй сумдад урамшуулал олгож эхэлсэн байна.

2016 онд нийт сумдын 36 хувь нь, 2020 онд 60.1 хувь нь урамшуулалд хамрагдсан байна.


Зураг 24. ЗАВХАН АЙМГИЙН ОНХС-ИЙН УРАМШУУЛАЛД ХАМРАГДАЛТ, УРАМШУУЛАЛ, МЯН.ТӨГ



Завхан аймгийн 24 сумын дундаж үнэлгээ 2016 онд 22.7 хувь, 2017 онд 29 хувь байсан бол 2018 онд 45.4 хувь, 2019 онд 48.6 хувь, 2020 онд 60.13 хувь болж 289.4 сая төгрөгийн урамшуулал авсан байна.

ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, дүрэм журмын хүрээнд сумдыг засаглалын 6 бүлэг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг байна.

Зураг 25. ЗАВХАН АЙМАГ, УЛСЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТТЭЙ ХАРЬЦУУЛАЛТ, 2020 ОН



Судалгааны үр дүнгээс харахад шалгуур үзүүлэлт тус бүрээр сайжирч, ахиц гарч байгаа хэдий ч улсын дунджаас доогуур хэвээр, ялангуяа ил тод байдал, өмчийн удирдлага, хяналтын үзүүлэлт 7-10 хувь доогуур байна. Цаашид ОНХС-гийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт, үнэлгээ, иргэдийн оролцоо, ил тод байдлыг илүү сайжруулж, түвшнээ ахиулахад анхаарах шаардлагатай.

Улсын хэмжээнд жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Баянхонгор аймгийн Гурванбулаг сум 92 хувьтай байсан бол Завхан аймгийн Цагаанхайрхан сум 80 хувиар дүгнэгдэж, 330 сумаас 31 дүгээр байрт орсон байна.

ХҮСНЭГТ 38. ЗАВХАН АЙМГИЙН СУМДЫН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, 2020 ОН, МЯН.ТӨГ

	Сум	ЖГҮ оноо	2020 оны ОНХС	Урамшууллын хувь	Урамшуулал
1	ЦАГААНХАЙРХАН	80.0	22,851.07	50.0	11,425.53
2	ЦАГААНЧУЛУУТ	79.0	24,735.13	40.0	9,894.05
3	БАЯНХАЙРХАН	75.0	43,341.26	40.0	17,336.51
4	АСГАТ	74.0	18,661.11	40.0	7,464.44
5	ОТГОН	70.0	57,348.44	40.0	22,939.37
6	ДӨРВӨЛЖИН	63.0	59,864.97	40.0	23,945.99
7	ЯРУУ	63.0	40,044.08	40.0	16,017.63
8	ТОСОНЦЭНГЭЛ	62.0	148,287.75	40.0	59,315.10
9	ИДЭР	62.0	40,790.40	40.0	16,316.16
10	ТЭЛМЭН	62.0	69,887.63	40.0	27,955.05
11	ТЭС	58.0	36,218.83	25.0	9,054.71
12	САНТМАРГАЗ	57.0	38,398.41	25.0	9,599.60
13	БАЯНТЭС	56.0	66,298.29	25.0	16,574.57
14	ЦЭЦЭН-УУЛ	56.0	37,161.08	25.0	9,290.27
15	ИХ УУЛ	55.0	113,373.54	25.0	28,343.39
16	ШИЛУУСТЭЙ	54.0	33,011.46	25.0	8,252.87
	Нийт дүн				293,725.25

Эх үүсвэр: ТА-III төслийн тайлан, 2020 он

3.3.2 СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН, ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сан (СХС)-г анх МУЗГ-ын 1996 оны 258 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар”-ыг МУЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталж, 2016 онд МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна. 2011-2017 оны хугацаанд тус сангийн удирдлага зохион байгуулалт Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй уялдан 2011 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын, 2012-2014 онд Хөдөлмөрийн сайдын, 2014-2016 онд Аж үйлдвэрийн сайдын, 2016 оноос хойш дахин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч байна. Дээрх нөхцөл байдлаас хамаарч орон нутагт сангийн удирдлага, зохион байгуулалтыг Хөдөлмөрийн хэлтэс, аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газар (ХХААГ), сумдад 2011-2013 оны 4 дүгээр сар хүртэл хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, 2013 оны 4 дүгээр сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 2017 оны 4 дүгээр сараас хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн хариуцан ажиллаж байсан нь сангийн удирдлага, зохион байгуулалт тогтворгүй явж ирснийг харуулж байна.

Тус сангийн хөрөнгийг бүрдүүлэх зорилгоор улсын төсвөөс 2011-2014 онд сумын хүн амын тоо, эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан дараах байдлаар мөнгөн хөрөнгийг хуваарилсан ба үүнээс хойш нэмж санхүүжилт олгоогүй байна.

Хүснэгт 39. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХУВААРИЛАЛТ, 2011-2014 ОН, САЯ.ТӨГ

	Хүн амын тоо	Сумын тоо	2011 он	2012 он	2013 он	2014 он	Нийт
1	3000 ХҮРТЭЛ	169	50.0	50.0	50.0	18.0	168.0
2	3000-5000	98	60.0	60.0	60.0	24.0	204.0
3	5000-С ДЭЭШ	31	75.0	75.0	75.0	30.0	255.0
4	ОНЦЛОХ СУМ	7	110.0	110.0	110.0	30.0	360.0
5	ТОСОНЦЭНГЭЛ	1	-	205.0	205.0	122.0	532.0
6	АЙМГИЙН ТӨВ	24	265.0	265.0	265.0	106.0	901.0

Эх үүсвэр: ХХҮГ-ын тайлан

Завхан аймгийн 21 сум нь 3,000-аас доош хүн амтай, Их-Уул, Тосонцэнгэл сумд 5,000-аас дээш хүн амтай бөгөөд Завхан аймагт 5.0 тэрбум төгрөг хуваарилагдсан байна.

СХС-ийн эх үүсвэр нь улсын төсвөөс олгосон эргэлтийн хөрөнгөөс гадна зээлийн хүү болон хугацаа хэтрүүлсэн зээлд ногдуулсан алданги, хандив, тусламжийн орлогоос бүрддэг.

МУЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д аймаг, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын чиг үүргийг тодорхой тусгаж өгсөн ба СХС-ийн орлого, зарлага, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ, хүүгийн хэмжээг сумын ИТХ-ын тогтоолоор баталж, хэрэгжилтийг сумын Засаг дарга хууль, журамд заасан чиг үүргийн хүрээнд ханган ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын 330 сумын СХС-ийн нийт хөрөнгө 98,453.1 сая төгрөг байгаагаас 14,354 зээлдэгчдэд 73,724.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл, сангийн дансанд 24,728.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. 9,526 зээлдэгчийн 48,655.7 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрч, чанаргүй зээлээр бүртгэгдсэн байгаа нь нийт хөрөнгийн 49 хувийг эзэлж байна.

Хүснэгт 40. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /2021.06.30/ МЯН.ТӨГ


Аймаг	Нийт санхүүжилт	Зээлдэгчийн тоо	Зээлийн үлдэгдэл	Дансны үлдэгдэл	Нийт хөрөнгө	Чанаргүй зээлдэгч	Чанаргүй зээлийн үлдэгдэл	Чанаргүй зээлийн хувь	
1	БАЯНХОНГОР	4,540.440	534	2,861.917	1,877.264	4,739.181	240	1,259.289	26.57
2	ДАРХАН-УУЛ	1,765.200	212	1,367.584	412.749	1,780.333	102	614.370	34.51
3	СҮХБААТАР	3,313.860	271	2,406.516	1,133.883	3,540.399	159	1,243.710	35.13
4	ДУНДГОВЬ	3,443.440	382	3,090.192	1,242.388	4,332.580	215	1,540.716	35.56
5	УВС	4,229.980	638	3,507.657	1,324.631	4,832.288	331	1,812.312	37.50
6	ГОВЬ-АЛТАЙ	3,954.160	595	3,048.061	1,591.732	4,639.794	305	1,814.985	39.12
7	АРХАНГАЙ	4,919.060	1,290	5,161.108	1,874.504	7,035.612	660	2,826.166	40.17
8	ХӨВСГӨЛ	5,608.260	969	4,770.628	1,705.988	6,476.616	526	2,665.458	41.16
9	БУЛГАН	3,905.120	675	3,680.414	1,288.051	4,968.466	436	2,313.665	46.57
10	ДОРНОГОВЬ	4,023.560	412	3,647.523	1,150.219	4,797.743	255	2,283.307	47.59
11	ДОРНОД	3,359.900	456	2,928.830	810,011	3,738.841	286	1,926.353	51.52
12	ӨМНӨГОВЬ	3,450.160	290	2,460.605	1,350.267	3,810.873	209	2,027.820	53.21

13	ОРХОН	1,127.800	191	891,242	419,925	1,311.167	130	722,611	55.11
14	ЗАВХАН	5,585.940	1,663	5,487.962	995,014	6,482.977	1,202	3,703.145	57.12
15	ХОВД	4,310.320	862	3,709.871	1,218.590	4,928.462	642	2,869.739	58.23
16	СЭЛЭНГЭ	4,938.900	849	4,571.200	1,200.233	5,771,434	665	3,390.432	58.75
17	ТӨВ	6,012.760	1,362	6,755.000	1,515.468	8,270.469	1,079	5,029.982	60.82
18	БАЯН-ӨЛГИЙ	3,925.600	1,040	3,327.016	799.348	4,126.365	798	2,538.190	61.51
19	ХЭНТИЙ	4,651.560	529	3,759.881	1,056.343	4,816.224	418	2,969.860	61.66
20	ӨВӨРХАНГАЙ	5,663.260	1,017	5,316.517	1,421.831	6,738.349	758	4,210.376	62.48
21	ГОВЬСҮМБЭР	1,270.720	117	975,216	339,763	1,314.979	110	893,270	67.93
Нийт дүн		84,000.000	14,354	73,724.950	24,728.211	98,453.162	9,526	48,655.764	49%

Эх сурвалж : ХХААХҮЯ

Завхан аймгийн сумдын сум хөгжүүлэх сан 1,663 зээлдэгчид дээр 5,487.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, дансны үлдэгдэл 995.0 сая төгрөг байна. 1,202 зээлдэгчийн 3,703.1 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байгаа нь нийт хөрөнгийн 57.1 хувийг эзэлж байна. Энэ нь улсын дунджаас 8 хувиар өндөр үзүүлэлттэй байна. Зээлийн үлдэгдэлтэй нийт зээлдэгчийн 72 хувь нь зээлийн төлөлтийн хугацаа хэтрэлттэй байна.

Зураг 26. ЗАВХАН АЙМГИЙН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ЧАНАР БАЙДАЛ, САЯ ТӨГ



Эх үүсвэр: Завхан аймгийн ЗДТГ-ын тайлан, 2020 он

СХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын ЗДТГ-ын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн сангийн мэргэжилтэн, төрийн бус байгууллага, иргэний төлөөллийг оролцуулан Сумын ИТХ-ын тогтоолоор батлан ажиллаж байна.

Сүүлийн 5 жилд Завхан аймгийн сумд СХС-ийн зээлийн эргэн төлөлт болон хүү алдангийн орлогоор нийт 6,678.4 сая төгрөг буюу жилд дунджаар 1335.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

ХҮСНЭГТ 41. ЗАВХАН АЙМГИЙН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГЫН МЭДЭЭЛЭЛ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

СУМ	2016	2017	2018	2019	2020
АЛДАРХААН	11.2	15.2	19.4	11.2	2.4
АСГАТ	8.3	18.3	44.8	32.7	47.4
БАЯНТЭС	18.6	8.9	23.1	30.7	47.7
БАЯНХАЙРХАН	43.7	41.7	66.2	46.3	42.4

ДӨРГӨН	56.7	55.0	28.3	32.8	10.5
ЗАВХАНМАНДАЛ	55.8	40.9	38.4	38.9	49.7
ИДЭР	41.1	38.1	44.7	28.2	30.2
ИХ-УУЛ	46.1	44.3	39.2	56.1	66.7
НӨМРӨГ	48.6	64.5	64.4	63.5	68.9
ОТГОН	25.6	87.9	70.0	43.0	90.3
САНТМАРГАЦ	19.8	32.6	20.2	7.5	21.3
СОНГИНО	35.6	50.3	88.7	33.4	35.5
ТОСОНЦЭНГЭЛ	23.0	38.8	86.8	93.5	122.3
ТЭС	39.7	11.0	10.5	1.5	3.8
ТЭЛМЭН	69.4	80.5	60.2	68.5	114.2
ТҮДЭВТЭЙ	68.3	38.1	45.7	45.6	34.6
УЛИАСТАЙ	206.0	282.2	305.5	310.5	254.8
УРГАМАЛ	64.1	62.1	83.6	54.4	81.8
ЦЭЦЭН-УУЛ	25.4	10.6	29.6	12.1	16.9
ЦАГААНХАЙРХАН	37.1	79.2	35.1	31.5	52.0
ЦАГААНЧУЛУУТ	85.3	67.8	63.3	98.6	57.1
ШИЛҮҮСТЭЙ	25.4	64.0	90.8	56.1	55.9
ЭРДЭНЭХАЙРХАН	70.0	0.0	78.5	62.8	71.7
ЯРУУ	75.9	23.7	32.4	48.9	65.9
НИЙТ	1,200.6	1,256.0	1,469.4	1,308.3	1,444.1

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ын мэдээлэл

Сумын ИТХ-ын тогтоол, төсөл сонгон шалгаруулах зөвлөл, сумын Засаг даргын шийдвэрийг үндэслэн СХС-аас зээлийг дараах байдлаар олгосон байна.

ХҮСНЭГТ 42. ЗАВХАН АЙМГИЙН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЛАГЫН МЭДЭЭЛЭЛ, САЯ.ТӨГ


Сум	2016	2017	2018	2019	2020
АЛДАРХААН	12.9	10.5	18.5	6.0	13.2
АСГАТ	7.3	3.2	21.3	50.2	65.6
БАЯНТЭС	12.0	21.0	20.3	33.1	44.5
БАЯНХАЙРХАН	35.8	34.1	31.0	90.5	51.7
ДӨРГӨН	21.6	61.9	9.2	90.5	26.1
ЗАВХАНМАНДАЛ	17.8	79.5	38.7	42.4	49.0
ИДЭР	35.3	33.0	25.4	41.1	60.2
ИХ-УУЛ	28.6	44.1	42.9	38.5	52.9
НӨМРӨГ	52.0	56.4	52.2	61.0	89.8
ОТГОН	28.9	60.4	24.0	77.3	59.3
САНТМАРГАЦ	0.0	74.1	0.9	34.0	0.5

СОНГИНО	35.1	37.1	65.8	59.7	0.0
ТОСОНЦЭНГЭЛ	24.7	33.2	50.5	122.1	121.6
ТЭС	15.1	43.0	4.6	1.0	1.2
ТЭЛМЭН	72.4	54.5	80.4	63.5	78.2
ТҮДЭВТЭЙ	44.9	51.9	34.7	48.5	45.3
УЛИАСТАЙ	143.1	287.0	437.3	313.5	243.3
УРГАМАЛ	3.0	95.2	120.3	35.8	100.7
ЦЭЦЭН-УУЛ	0.0	0.0	77.8	18.0	20.2
ЦАГААНХАЙРХАН	39.6	81.4	1.1	62.8	42.5
ЦАГААНЧУЛУУТ	101.6	61.7	15.4	118.5	86.4
ШИЛҮҮСТЭЙ	14.0	84.7	95.9	48.8	67.4
ЭРДЭНЭХАЙРХАН	4.0	163.0	90.5	102.0	6.2
ЯРУУ	77.5	0.0	40.9	57.8	64.9
НИЙТ	827.4	1,470.9	1,399.4	1,616.4	1,390.6

Эх үүсвэр: Аймгийн СТСХ-ын мэдээлэл

Завхан аймгийн СХС-ийн орлого буюу зээлийн эргэн төлөлт нь 2020 онд 2016 онтой харьцуулахад 20.0 хувиар, сангаас олгож байгаа зээлийн хэмжээ 68.0 хувиар өссөн байна.

ЗУРАГ 27. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ




Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэдээ, 2021 он

Тухайлбал 2020 оны СХС-ийн зарлагын төлөвлөгөө буюу эргэн төлөгдөх зээлд 2,439.8 сая төгрөгийг олгохоор төлөвлөсний 662.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, 1,777.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр сумдын ИТХ-аар баталжээ.

2016-2020 онд нийт 6,704.7 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангаас зарцуулсан ба 1,322 хүн зээлд хамрагдаж, 1,030 шинэ ажлын байр бий болсон байна.

Зураг 28. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, 2020 ОН



Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн тайлан, 2021

Сум хөгжүүлэх сангийн орлого зарлагын төсвийг сумын ИТХ-ын тогтоолоор баталж гүйцэтгэл нь сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдэж байна. Сум хөгжүүлэх сангаас тухайн жилд санхүүжүүлэх төслийн зориулалт болон нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг ИТХ-ын тогтоолоор баталж, сум хөгжүүлэх сангийн зээлийн ажлын хэсэг төслийг сонгон шалгаруулж, санхүүжүүлэх эрхийг сумын төрийн санд олгож, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж байна.

Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэл төсвийн хуульд заасан цаглабрын дагуу сумын сар, улирал, жилийн мэдээ, тайланд нэгтгэгдэж улмаар аймгийн мэдээ тайланд нэгтгэгдэн Сангийн яаманд тайлагнагдаж байна. Мөн сумын ЗДТГ-ын Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) хариуцсан мэргэжилтэн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын мэдээг сум хөгжүүлэх сангийн мэдээллийн санд шивж улмаар мэдээлэл нь ХХААХҮ-ийн яамны ЖДҮ-ийн газарт нэгтгэгдэж байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн үлдэгдэлтэй нийт зээлдэгчдийн 70 гаруй хувь нь зээлийн хугацаа хэтрэлттэй байгаа нь зээлийн эргэлтэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Төрийн аудитын байгууллагаас сумдын СХС-ийн хөрөнгийн зарцуулалт үр дүнд хяналт хийж байна. Тухайлбал Төрийн аудитын зүгээс СХС-ийн үйл ажиллагаанд 2019 онд хяналт, шалгалт хийсэн тайланд 2019 оны эхэнд аймгийн дүнгээр СХС 5,120.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 1,435.6 сая төгрөгийн зээл олгож, 1,064.4 сая төгрөгийн зээлийг төлүүлэн оны эцэст 5,491.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагийн 59.8 хувь буюу 3,253.9 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, үүний 41.4 хувь буюу 1,347.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд хандсан, шүүхийн захирамжийн 39.8 хувь буюу 536.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (ШШГГ)-тай гэрээ байгуулсан гэж дурьдсан байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт, бүрдүүлэлт нь орон нутгийн удирдлагуудын ажилд ихээхэн хүндрэл учруулж, санхүүгийн зөрчилд орох асуудалтай болж байгаа тул зээлийг банкаар дамжуулан олгох, Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байдал ажиглагдаж байна.

3.4 Хөгжлийн бодлого төлөвлөлт болон орон нутгийн төсвийн уялдаа

3.4.1 ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСВИЙН УЯЛДАА

Аймгийн дунд хугацааны болон богино хугацааны бодлогын баримт бичгүүд нь Монгол Улсын хөгжлийн урт болон дунд, богино хугацааны бодлоготой хэрхэн уялдаж байгаа талаар тусгайлсан шинжилгээ хийгдэж байгаа тул тухайн бодлогын баримт бичгүүд төсөвтэй хэрхэн уялдаж байгааг 2018-2020 оны төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй уялдуулан судалж үзлээ. Бодлогын баримт бичиг болон төсвийн уялдааг аймгийн ИТХ-ын 2017-2020 оны хуралдааны материал, холбогдох ИТХ-ын тогтоолууд болон тухайн жилийн орон нутгийн төсөв баталсан тогтоол, аймгийн төсвийн гүйцэтгэлд үндэслэн судаллаа.

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Завхан аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2018, 2019 оны үндсэн чиглэлд тухайн жилд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг тооцон ажилласан байна. Аймгийн хөгжлийн 4 жилийн хөтөлбөр болон жилийн үндсэн чиглэлийг төлөвлөж батлахдаа тухайн арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэрийг

тусган баталж, гүйцэтгэлийг тайлагнахдаа мөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр тайлагнасан байна.

Хүснэгт 43. ЗД-ЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨВ, 2018-2019 ОН, САЯ.ТӨГ

Он	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх нийт хөрөнгө		Үндсэн чиглэлд орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн	
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
2018	3,1618.5	3,0601.8	5,977.4	6,366.7
2019	4,7203.0			5,670.2

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн тайлан

Сүүлийн 5 жилийн байдлаар орон нутгийн нийт зардлын 8 орчим хувь нь тухайн жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэж байгаа бөгөөд энэ нь үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн 15-18 хувьтай тэнцэж байна. Бусад шаардлагатай эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийхэд бага ч гэсэн орон нутгийн төсвийг төлөвлөхдөө хөгжлийн бодлого зорилттой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Орон нутагт дээр дурьдсан хөгжлийн баримт бичгүүдээс гадна үндэсний болон орон нутгийн чанартай 27 дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (ХШҮДАХ) нь Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн биелэлт, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон, хяналт шинжилгээ хийж аймгийн ИТХ болон Засгийн газарт тайлагнадаг байна.

ХҮСНЭГТ 44. ЗАВХАН АЙМАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ДЭД ХӨТӨЛБӨРТ ЗАРЦУУЛСАН ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ, 2016-2020 ОН

	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хугацаа	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь	Зарцуулсан төсөв	Эх үүсвэр	
						ОНХО	ОНХС
1	Жимс жимсгэнэ дэд хөтөлбөр	2016	7	100%	-	-	
2	Хүнсний ногоо дэд хөтөлбөр	2017	13	100%	6.00		6.00
3	Авилгын эсрэг - авлигаас ангид аймаг дэд хөтөлбөр	2017	20	100%	9.00		9.00
4	Халдварт өвнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	2017	17	100%	-		
5	Эрх зүйн боловсрол- эрс шинэчлэл дэд хөтөлбөр	2017	10	100%	-		
6	Ахлдварт бус өвнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	2005	35	95.59%	51.50	1.50	50.00
7	Боловсрол, соёл урлагийн салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр	2017	32	94.19%	-	-	

8	Завханы улаан хальст сармис дэд хөтөлбөр	2013	17	94.12%	20.00	20.00	
9	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Завхан аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр	2017	60	90.50%	33.00	33.00	-
10	Бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр		21	89.52%	199.40	58.40	141.00
11	Эрүүл хүнс - эрүүл монгол хүн дэд хөтөлбөр	2019	20	89%	3.00		3.00
12	Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр	2015	48	88.30%	122.00		122.00
13	Сайн багш дэд хөтөлбөр	2016	19	86.84%	265.50	89.00	176.50
14	Ахмадын сургаал алт дэд хөтөлбөр	2017	12	86.67%	40.00		40.00
15	Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр	2010	27	86.67%	80.00	80.00	
16	Сайн бизнесмен дэд хөтөлбөр	2016	30	86%	27.30		27.30
17	Завханд үйлдвэрлэж - Завханчууд хэрэглэж экспортлох хөтөлбөр	2017	28	83.93%	60.00		60.00
18	Стандарттай Завхан дэд хөтөлбөр	2016	30	83.67%	3.00		3.00
19	Сайн малчин дэд хөтөлбөр	2016	50	83%	30.00		30.00
20	Элэг бүтэн монгол дэд хөтөлбөр	2017	6	80%	2.00		2.00
21	Ус дэд хөтөлбөр	2010	45	78.37%	242.10		242.10
22	Хүүхдэд ээлтэй орон нутаг дэд хөтөлбөр	2017	41	76.84%	3.00	3.00	-
23	Сайн оюутан дэд хөтөлбөр	2016	5	76%	145.50		145.50
24	Хог хаягдлын менежментийг сайжруулах дэд хөтөлбөр	2014	37	67.84%	134.70		134.70
25	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр		20	64%	-		-
26	Сайн эмч дэд хөтөлбөр	2016	30	61.67%	80.20		80.20
27	Жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр	2017	19	57.37%	-		-
Нийт дүн			699	85,1	1,557.20	284.90	1,272.30

Эх үүсвэр: Судлаачийн тооцоолол, 2021 он

Төсвийн төлөвлөлтөөс үзэхэд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсөвт тусгагдсан хөрөнгө тэр бүр тодорхойгүй байгаа ба гүйцэтгэлийг дэд хөтөлбөрийн тайлан мэдээлэлд үндэслэн холбогдох мэргэжилтнүүдээс тодруулж тооцлоо.

“Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай” хууль 2020 оны 5-р сард батлагдан хэрэгжиж эхлээд байна. Тус хуульд аймаг нийслэлийн Засаг дарга нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж тухайн шатны ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг тайлагнахаар заасан. Мөн орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинд үндэслэн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, бодлогын баримт бичигт хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл,

санхүүгийн эх үүсвэр, хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгасан байна гэж хуульд заасан. “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Завхан аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”, “2021 оны Завхан аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө” нь хуульд заасан хүрээнд боловсруулагдсан байгаа бөгөөд нийт 199 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 51272.3 сая төгрөгийг шаардлагатайгаас ОНХС, Орон нутгийн замын сангаас нийт 5.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2021 оны төсөвт тусгасан байна.

Орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төлөвлөж холбогдох яамдад хүргүүлснээр тодорхой хэсэг нь улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна. Орон нутагт барих аливаа барилга байгууламжийг заавал аль нэг яамны багцад тусгаж байгаа бөгөөд улсын төсвөөс орон нутгийн төсөвт хөрөнгө оруулалтын зориулалттай зардал 2018 онд тусгагдсан ба судалгаанд хамрагдсан бусад жилүүдэд тусгагдаагүй байна.

Хүснэгт 45. ЗАВХАН АЙМГААС САЛБАРЫН ЯАМДАД ХҮРГҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНАЛ, ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2019-2021 ОН, МЯН.ТӨГ

Санал хүргүүлсэн яам, газрууд	2019		2020				2021					
	Төсөвт тусгахаар хүргүүлсэн саналын тоо		Шийдэгдсэн байдал /тоогоор/		Төсөвт тусгахаар хүргүүлсэн саналын тоо		Шийдэгдсэн байдал /тоогоор/		Төсөвт тусгахаар хүргүүлсэн саналын тоо		Шийдэгдсэн байдал /тоогоор/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЭХЯ	3	7,320			8	12,032	2	2,220	4	11,850	1	1,600
БХБЯ	5	8,284	3	15,580	2	21,200	3	15,580	6	50,500	2	3,000
ЗТХЯ	9	162,293	6	424,343	5	21,305	3	7,843	12	265,882	4	2,274.3
ЭМЯ	9	4,756	4	2,130	4	4,956	5	7,111	8	4,758	2	2,325
БСШУСЯ	19	48,700	13	24,395	27	55,400	32	79,898	16	39,484	23	56,720
ХХААХҮЯ			1		1	300						
БОАЖЯ	6	3,444	1	3,000	4	3,294	2	1,858	3	305	1	3,000
ЗГХЭГ	5	5,315	3	3,730	5	9,835	6	4,510	6	11,585	3	3,600

Эх үүсвэр: Завхан аймаг ЭДТГ, Хэлтсүүдийн тайлан, 2021

Тухайлбал 2019 онд Завхан аймаг 7 яаманд 240.0 тэрбум төгрөгийн 56 санал хүргүүлснээс 30 санал нь шийдвэрлэгдсэн байна. 2019 оны төсөвт Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 211 км замын ажлыг гүйцэтгэхтэй холбоотой ихээхэн хэмжээний санхүүжилтийг Зам тээвэр, хөгжлийн яам (ЗТХЯ)-наас батлан ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Харин 2020 онд аймгаас хүргүүлсэн 128.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн 55 саналаас 119.0 тэрбум бүхий 54 санал батлагдсан байна. Сүүлийн гурван жилд орон нутгаас хүргүүлсэн саналын 73 хувийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн байна.

2016-2020 онд Завхан аймагт хийгдсэн томоохон хөрөнгө оруулалтын ажлуудын багцыг судалж үзвэл нийт хөрөнгө оруулалтын 78,8% буюу 493.0 тэрбум төгрөгийг зам гүүр барих, сэргээн засварлахад зарцуулсан бол нийгмийн үйлчилгээний салбар болох боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын салбарын хөрөнгө оруулалтад 16,95% буюу 106,8 тэрбум төгрөг, төрийн үйлчилгээг сайжруулахтай холбоотой багийн иргэдийн төв, сумдын тамгын газрын конторын барилгын хөрөнгө оруулалтад 4% буюу 25,1 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон үйлдвэр, орон нутгийн иргэдийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлтэй ажлуудад маш бага хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хүснэгт 46. ЗАВХАН АЙМГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ, 2016-2020 ОН

Улсын болон орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалт /сая.төг/	
Контторын барилга, автомашин	25,132.8
Сургууль, цэцэрлэгийн барилга	62,575.5
Соёлын төвийн барилга	26,154.4
Спорт	9,704.5
Эрүүл мэнд	7,935.4
Цахилгаан дамжуулах шугам	2,220.0
Авто зам	37,093.9
Улсын болон зээл, концессын гэрээгээр хийгдсэн авто зам	456,900.0
НИЙТ	627,716.5

Эх үүсвэр: Завхан аймаг ЭДТГ, Төрийн сан, 2021

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлд орон нутгийн жилийн төсвийн төсөлд Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргаж ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж, батлахаар журамласан боловч Завхан аймгийн 2019, 2020 оны ИТХ-ын тогтоолд тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны газрын тайлангаас худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын мэдээллийг авч, мэдээлэлд үндэслэн доорх дүгнэлт тооцооллыг хийлээ. Орон нутгийн урсгал зардал, орон нутгийн хөрөнгө оруулалт болон салбарын сайдын багцаас орон нутагт эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй зохион байгуулж байна.

Хүснэгт 47. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛ, 2018-2020 ОН

Хөрөнгийн эх үүсвэр	2 018		2019		2020	
	Нийт төсөвт өртөг	ХААН-ны дүн	Нийт төсөвт өртөг	ХААН-ны дүн	Нийт төсөвт өртөг	ХААН-ны дүн
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	20,258.50	8,575.5	40,501.9	40,501.9	26,444.6	23,765.8
Орон нутгийн төсвийн урсгал зардал	4,327.60	1,362.4	4,902.8	1,503.4	5,841.4	1,366.2
ОНХС, ОНХО	6,366.7	3,226.8	5,670.2	3,067.0	6,179.3	4,325.8
ДҮН	30,952.8	13,164.7	51,074.9	45,072.2	38,465.3	29,457.8
Нийт хөрөнгөнд ХАА зохион байгуулсан хөрөнгийн эзлэх хувь		42.5		88.2		76.6
Зохион байгуулсан цахим тендерийн тоо		63.0		67.0		80.0

Эх үүсвэр: Аймгийн ЭДТГ-ын худалдан авах ажиллагааны тайлан, 2021 он

Сүүлийн 3 жилд нийт 210 цахим тендерийг зохион байгуулсан нь 2018 онд нийт төсөвт өртгийн 42.5 хувь, 2019 онд 88.2 хувь, 2020 онд 76.6 хувийг тус тус хамарсан байна.



ДӨРӨВ.
ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН
НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



4.1 Засаг дарга ба салбарын сайд хооронд байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн

Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл болон салбарын хуулиудад заасан засаг даргын эрх үүргийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэхэд чиглэсэн гэрээг жил бүр оны эхэнд байгуулж тайлагнаж байна. Завхан аймгийн Засаг дарга 2020 онд Засгийн газрын гишүүн салбарын сайдтай 15 гэрээ байгуулан ажилласан бөгөөд үүнд нийт 555 зорилт, арга хэмжээг зохион байгуулахаар тусгаснаас 100 хувийн хэрэгжилттэй 491 арга хэмжээ буюу нийт арга хэмжээний 88.5 хувь, 70 хувийн хэрэгжилттэй 45 арга хэмжээ буюу 8.1 хувь, 30 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ буюу 1.1 хувь, хэрэгжих боломжгүй буюу үнэлэгдэх боломжгүй 13 арга хэмжээ буюу 2.3 хувь тус тус хэрэгжсэн байна.

Хүснэгт 48. САЛБАРЫН САЙД, ЗГЫН ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, 2020 ОН

Нэр	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн хувь						
		Бүрэн хэрэгжсэн 100 хувь	Хэрэгжих шатанд 70 хувь	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь	Хэрэгжээгүй	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хэрэгжилтийн хувь	
1	Шадар сайд	23 зорилт, арга хэмжээ	20	1	-	-	2	98.5
2	МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга	13 зорилт, арга хэмжээ	12	-	-	-	0	100.0
3	Хууль зүй, дотоод хэргийн яам	58 зорилт, арга хэмжээ	56	2	-	-	-	98.9
4	Сангийн яам	24 зорилт, арга хэмжээ	19	4	1	-	-	92.1
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	45 зорилт арга хэмжээ	38	6	1	-	-	94.4
6	Эрчим хүчний яам	12 зорилт, арга хэмжээ	11	1	-	-	-	97.5
7	Эрүүл мэндийн яам	43 зорилт, арга хэмжээ	37	5	-	-	1	96.4
8	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	37 зорилт, арга хэмжээ	29	8	-	-	-	93.5
9	Батлан хамгаалах яам	40 зорилт, арга хэмжээ	28	5	4	-	3	88.3
10	Барилга, хот байгуулалтын яам	68 зорилт, арга хэмжээ	48	17	2	1	-	88.9
11	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	24 зорилт, арга хэмжээ	15	4	-	-	5	93.7
12	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	95 зорилт, арга хэмжээ	85	6	1	3	-	93.9
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	24 зорилт, арга хэмжээ	18	6	-	-	-	92.5
14	Зам тээврийн яам	26 зорилт арга хэмжээ	24	-	-	-	2	100.0
15	Үндэсний хөгжлийн газар	12 зорилт, арга хэмжээ	6	-	1	-	5	90.0
	Нийт дүн	555	491	45	6	0	13	96.1

Эх үүсвэр: Завхан аймаг ЗДТГ-ын тайлан, 2021 он

Аймгийн Засаг даргаас салбарын сайдтай байгуулсан гэрээнд заасан хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлого хариуцсан хэлтсийн дарга, мэргэжилтнүүд болон Засаг даргын дэргэдэх агентлагийн дарга нартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон дүгнэсэн байна.

ХҮСНЭГТ 49. АЙМГИЙН ЗД-ТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, БАЙГУУЛЛАГААР

Аймгийн засаг даргатай байгуулсан 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

№	Байгууллагын нэр	Хэрэгжилтийн хувь
1	Улсын бүртгэлийн хэлтэс	97.5
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	97.3
3	Санхүүгийн хяналт, аудитын алба	95.7
4	Боловсрол соёл, урлагийн газар	95.3
5	Онцгой байдлын газар	95.1
6	Орон нутгийн өмчийн газар	94.8
7	Нийгмийн даатгалын хэлтэс	94.1
8	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	93.9
9	Шүүхийн шинжилгээний алба	93.8
10	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	93.5
11	Цагдаагийн газар	93.5
12	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	93.2
13	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	93.1
14	Мэргэжлийн хяналтын газар	93.1
15	Эрүүл мэндийн газар	93.0
16	Мал эмнэлгийн газар	93.0
17	Хүнс хөдөө аж ахуйн газар	92.8
18	Татварын хэлтэс	92.6
19	Биеийн тамир спортын газар	92.5
20	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	91.7
21	Статистикийн хэлтэс	91.4
22	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	91.3

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХШУДАХ-ийн тайлан, 2021 он

2020 онд Аймгийн Засаг даргатай салбарын сайдын байгуулсан гэрээний хэрэгжилтийн үр дүнг ХНХ-ын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээнд жил бүр тусгагдаж байгаа “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох” хөтөлбөр-3 арга хэмжээний хэрэгжилтээр төлөөлүүлэн авч үзэхэд доорх байдалтай байна.

Хүснэгт 50. АЙМГИЙН ЗД-ЫН ХХҮГ-ЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ, 2020 ОН

Үзүүлэлт	Хүрэх төвшин	Хүрсэн төвшин	Хувь
3.1 Байнгын ажлын байр шинээр бий болгоно	1,400	1,451	70
3.2 Хөгжлийн бодлого төлөвлөлт, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан орон нутгийн ажилгүй ядуу иргэдийн амьжиргааг дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажилгүйдлийн түвшнийг бууруулна.	4.3	2.9	100
3.3 Дэд бүтэц, хөрөнгө оруулалт, санхүү зээлийн бодлогын уялдааг хангаж зохистой хөдөлмөрийн бодлого зорилтыг орон нутгийн онцлогт нийцүүлэн тодорхойлж хэрэгжүүлснээр тогтвортой хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлнэ.	71.3	74.9	105
3.4 ХЭ-ийг дэмжих тухай хуульд заасан хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр, ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх.	990.6	806.7	74.6
3.5 Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	380.0	0	0
Хөтөлбөр-3 хэрэгжилтийн үнэлгээ			56.4

Эх үүсвэр: ХНХ-ын төсвийн ерөнхийлөн захирагч болон Завхан аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийн жилийн эцсийн тайлангаас

Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд аймаг, нийслэл өөрийн төсвөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь дэд сантай байх бөгөөд дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байхаар журамласан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.1-28.3 дахь заалтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 02 дугаар тогтоолоор “Аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийг баталсан. Зөвлөл нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн түншлэгч талуудын оролцоог хангах, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн бодлого үйл ажиллагааг удирдан зохицуулж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн төсвийг бүрдүүлэх, хуваарилах, асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргах, сангийн орлого зарлагын байдалд хяналт тавих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх зэрэг чиг үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Аймгийн зөвлөлийн дарга нь аймгийн Засаг дарга бөгөөд аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн дарга, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл зэрэг төр, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Завхан аймаг нь хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгайлсан хөтөлбөргүй, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт **“Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ”** зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 6 аж ахуйн нэгжид 451.0

сая төгрөгийн зээл “Сайн бизнесмен” хөтөлбөрийн хүрээнд 2017-2020 онд сум хөгжүүлэх сангаас 24 сумын 849 иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжиж 3 тэрбум 473 сая төгрөгийн, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 12 аж ахуйн нэгжид 1 тэрбум 962 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 589 ажлын байр шинээр бий болсон байна.

Завхан аймгийн 2020-2025 оны үндсэн чиглэл болон 2020-2024 оны аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт **“Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлнэ”** зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгаж санхүүжүүлэх эх үүсвэр, суурь түвшин, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

Хүснэгт 51. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР, САЯ ТӨГ, ХУВИАР

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			
					2021	2022	2023	2024
Зорилт: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ХҮРГЭЖ, ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛНЭ								
Ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна	онт	40.0	хувь	25.7	24.5	22	22	20
Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ	онт		хувь	80	80	83	85	86
Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ	онт	20.0	хувь	23	28	31	35	40
Ажлын байрны захиалгад нийцүүлсэн бодлогоор ажилгүйдлийн түвшинг бууруулна	онт	80.0	хувь	4,3	5,6	4	3	3
Үйлчилгээний салбарт ажиллагсдыг мэргэжлийн сургуульд бэлтгэнэ	онт	15.0	хүний нөөц	250	280	300	330	350
Аймгийн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг өргөжүүлнэ	онт	10.0	бирж	0			1	
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв байгуулна	онт	40.0	төвийн тоо				1	
Зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудын мэдээллийн санг бий болгоно	онт	2.0	бүртгэгдсэн ахмадын тоо	175	200	230	250	300

Эх үүсвэр: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн тайлан, 2021 он

Завхан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дэд санд 2016-2020 онд 4,039,5 сая төгрөг хуваарилагдаж, төсөл хөтөлбөрт 16,786 хүнийг хамруулсан бөгөөд тус арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнд 3,832 шинэ ажлын байр бий болсон байна.


Хүснэгт 52. ЗАВХАН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ

Хөтөлбөр	2016	2017	2018	2019	2020
Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	45.1	30.4	28.9	20.5	10.3
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	225.0	281.5	290.8	288.5	110.1
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	160.5	403.4	346.4	486.3	318.3
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	30.7	58.5	91.3	212.9	119.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	76.1	60.5	59.0	61.7	78.2
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	14.0	30.1	30.3	40.8	31.1
ДҮН	551.4	864.4	846.7	1,110.7	667.8
Хамрагдсан хүний тоо	2,909	3,312	3,703	3,850	3,012
Бий болсон ажлын байр	328	759	1,093	1,022	630

Эх сурвалж: Завхан аймгийн ХХҮГ-ын тайлан

Тус аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилагдан зарцуулсан хөрөнгө, бий болсон ажлын байрыг өмнөх онтой харьцуулахад 2017 онд хөрөнгө 56.7 хувиар, бий болсон ажлын байр 10.1 хувиар өссөн, 2018 онд хөрөнгө 2.1 хувиар буурсан, бий болсон ажлын байр 44 хувиар өссөн, 2019 онд хөрөнгө 31.2 хувиар өссөн, бий болсон ажлын байр 0.7 хувиар буурсан, 2020 онд хөрөнгө 40 хувиар, бий болсон ажлын байр 38.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 29. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙРНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ, ХУВИАР



Зохион байгуулалттай болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажлын байрыг дэмжих эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох зорилтын хүрээнд жил бүр эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгосон байна.

2020 оны жилийн эцэст Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн авлага өмнөх жилээс 200.0 сая төгрөгөөр нэмэгдэж 2,106.5 сая төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 53. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ ОЛГОСОН ЗЭЭЛИЙН АВЛАГА, 2020 ОН, МЯН.ТӨГ

Үзүүлэлт	2020.01.01	2021.01.01
Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	576,021.5	718,009.9
ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	138,382.4	156,365.4
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	830,418.6	769,244.3
Ахмад мэргэжилтний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	37,015.9	49,025.9
Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	315,324.3	411,342.5
Татаас санхүүжилтийн авлага	9,606.8	2,520.0
Дүн	1,906.769.6	2,106.508.1

Эх сурвалж: Завхан аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ХЭДС-гийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аймаг, сум нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилагдсан хөрөнгөөс гадна Сум хөгжүүлэх сангаас ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хөрөнгө зарцуулж, ямар үр дүнд хүрсэн талаар дээр дурдсан болно.

Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд аймгийн Засаг дарга, ЗДТГ болон салбар хариуцсан агентлагууд анхаарч, байгууллагын болон ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийн үр дүнг тооцон дүгнэж ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас салбарын сайдтай байгуулах гэрээнд тусгах санал хүргүүлдэг боловч эдгээрийг гэрээнд бүрэн тусгахгүйгээр, харин орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, хэрэгжих боломжгүй, хөрөнгө их шаардсан ажлуудыг гэрээнд тусгасан нь гэрээний биелэлтэнд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний 8.1 дэх заалтад "Аймгийн шүүхийн шинжилгээний албанд хэргийн газрын үзлэг болон шинжилгээ хийхэд шаардлагатай орчин үеийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх", 8.3 дах заалтад "Шүүхийн шинжилгээний албанд томилогдсон албан хаагчдын албаны орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх" зэрэг асуудлууд тусгагдсан байна.

Иймээс салбарын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төлөвлөлт, боловсруулалтыг хийхдээ ЗЗНДНТУ-ын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудлыг тусгах, харин чиг үүрэгт хамаарахгүй асуудлыг тусгасан тохиолдолд үүнд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэсэн нөхцөлд гэрээнд тусгах нь зүйтэй.

ХНХ-ын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсвийн хэрэгжилт, үр дүнгийн судалгаа, шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Завхан аймгийн хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн судалгаанд хамрагдсан бусад орон нутгийн байгууллагуудын нэгэн адил тодорхойгүй байна.
- Завхан аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө 2020 онд огцом буурсан нь сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд бий болдог ажлын байр 38.4 хувиар буурахад нөлөөлсөн байна.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас болон Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа нь хөрөнгийн үр ашгийг бууруулж энэ чиглэлээр зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орох эрсдэлтэй болж байна. Төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийг сайн судалж, зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах замаар зээлийн эрсдэлийг бууруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай.

- Аймаг, сумын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хамрагдалтын талаарх мэдээллийг тодорхой болгож, мэдээллийн хүртээмжийг сайжруулах.

- Завхан аймаг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөргүй ч аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох зорилтот арга хэмжээг тусган, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд аймаг, нийслэл өөрийн төсвөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь дэд сантай байх бөгөөд дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байхаар журамласан. Завхан аймгийн хувьд одоогоор орон нутгийн төсвөөс дэд санд хуваарилалт хийгдээгүй байна. Төсвийн тухай хуулийн 6.4.6-д “хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх” –аар хуульчилсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь тухайн төсвийн орлогын 0.3 хувиас доошгүй хувийг хөдөлмөр эрхлэлтийн дэд санд төвлөрүүлэхээр тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.



ТАВ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХЯҢАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



5.1 Төсвийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хөтөлбөрийн үр дүнгийн хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитыг хэрэгжүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ТЕЗ-ийн дотоод аудитыг арга зүйгээр хангана. Дотоод аудитын дүрмийг Засгийн газар батална” гэж заасны дагуу аймгийн дотоод аудитын чиг үүргийг Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлж байгаа бөгөөд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.


Үүнээс гадна аймгийн ЗДТГ-ын СТСХ, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс аймгийн хэмжээнд өөрсдийн чиг үүргийн дагуу хяналтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд анхан шатанд төсөвт байгууллага бүрт дотоод хяналтын баг Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолд заасны дагуу төсвийн шууд захирагчийн шийдвэрээр байгуулагдан ажиллаж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ХЯНАЛТ

Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 10 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Төсвийн тухай хууль, дотоод аудитын дүрэмд заасны дагуу ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах зорилготой ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016-2020 онд нийт 589 нэгж, байгууллагад санхүүгийн хяналт шалгалт явуулж 951 удаагийн акт, зөрчил, торгуулийн арга хэмжээ авч тогтоосон төлбөрийн хэмжээ 773.3 сая төгрөгт хүрчээ. Үүнд төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулах, төсвийн хэмнэлтийг горимыг алдагдуулах зөрчлүүд голлож байна.

Зураг 30. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН ТАЙЛАН, 2016-2020 ОН, САЯ.ТӨГ



Эх үүсвэр: Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албаны тайлан, 2020 он

2018 онд илрүүлсэн зөрчил, тогтоосон төлбөрийн дүн урд оны мөн үетэй харьцуулахад 8.9 хувиар буурсан дүнтэй байна. 2019 онд 11 төрийн байгууллага, 19 сан, төсөл арга хэмжээ, 13 сумын 78 төсөвт байгууллага, 26 сан, нэгж бүхий нийтдээ 100 байгууллага, нэгжид иж бүрэн хяналт шалгалт хийж 155.3 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, тайлант хугацаанд 111.7 сая төгрөгийг буюу 71.9 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 114 төсөвт байгууллага, нэгжийн 111 нэгжид аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийж 138.9 сая төгрөгийн төлбөр тогтоож 90.6 хувийг буюу 125.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Аймгийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах үүргийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн явцад улирал бүр дотоод аудит хийж, төсвийн 199 байгууллага 3-р улирлын байдлаар 22,209 мэдээлэл байршуулахаас 21,563 мэдээлэл байршуулж 97.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Мэдээллээ байршуулаагүй, тайлан удаа дараа илгээгээгүй 25 албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, зөрчлийг арилгуулах саналыг аймгийн төвийн 5 байгууллага, 20 сумын төсвийн шууд захирагчид хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг тооцон ажилласан байна.

Дээр дурдагдсан хяналт шалгалтын тоон мэдээллээс харахад тухайн байгууллагын гол үйл ажиллагаа санхүүгийн хяналт шалгалт уруу чиглэж байгаа тул цаашид үр дүнд чиглэсэн хяналтыг хэрэгжүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.

5.2 Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн хяналт, үнэлгээ

ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс (СТСХ) нь орон нутгийн төсвийн орлого зарлагын төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарлага санхүүжилтийг гүйцэтгэх, тайлагнах, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд эдийн засгийн шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, татварын орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын удирдамж, чиглэлээр хангах, сумын төрийн санд дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 36.6 заалтад төв төрийн сан нь аймаг, нийслэлийн төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлэхээр заасны дагуу аймгийн төрийн сан сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу гүйцэтгэж байна.

Төрийн сангийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үндсэн арга нь эрсдэлийн үнэлгээ юм. Завхан аймгийн төрийн сангаас сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд 2016-2020 онд эрсдэлийн үнэлгээг 19 үзүүлэлтээр хийжээ.

Эрсдэлийн үнэлгээний тайлангаас харахад гүйлгээний бүрдэл дутуу, санхүүжилт цаг хугацаандаа орж ирэхгүй зэрэг эрсдэл өндөр байна. Мөн санхүүжилт цаг хугацаандаа ирдэггүй, зарцуулах эрх удаан нээгддэг, татварын орлого сар бүрийн сүүлд бүрддэгээс болж санхүүжилт нь батлагдсан хуваариас зөрүүтэй олгогддог байна.

24 сумын төрийн сангийн нэгжийн эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хоёрыг нэгтгэн дүгнэхэд сүүлийн жилүүдэд Улиастай сумын үнэлгээ өсөж байгаа нь эрсдэл өндөртэй байгааг харуулж байгаа бол нийлбэр оноогоор Цагаанхайрхан, Цагаанчулуут сумууд эрсдэлгүй үнэлэгджээ.

5.3 Төсвийн гадаад хяналт

Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн аудитын тухай хуульд зааснаар төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага юм.

Түүнчлэн “Төсвийн тухай” хуулийн 6.5 дугаар хэсэгт зааснаар төсвийн ил тод байдлыг хангах зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах, төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангана гэж заажээ. Өөрөөр хэлбэл иргэд шууд болон иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж өгчээ.

Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь хэсэгт тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх бүрэн эрхийг ИТХ-д олгосон байна.

Дээрх эрх зүйн актуудын үндсэн дээр төрийн аудитын байгууллага, шат шатны ИТХ, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд төсвийн гадаад хяналтыг хэрэгжүүлж байна.

2016-2020 онд аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, салбарын тулгамдсан асуудлуудад судалгаа, хяналт-үнэлгээ хийж ИТХ-аар асуудал хэлэлцүүлэн батлуулах зорилготой бодлогын хороодыг байгуулжээ.

2020 оны АИТХ-ын 2 дугаар хуралдаанаар Завхан аймгийн хурлын 41 төлөөлөгчдөөс бүрдсэн дараах 5 бодлогын хороог байгуулсан байна. Үүнд:

- **Нутгийн удирдлага, хууль эрх зүй, хүний эрхийн хороо,**
- **Нийгмийн бодлогын хороо,**
- **Эдийн засгийн бодлогын хороо,**
- **Хүнс, хөдөө аж ахуй, ногоон хөгжил байгаль орчны бодлогын хороо,**
- **Үйлдвэрлэл, дэд бүтэц, хот байгуулалтын бодлогын хороо.**

Эдгээр хороод нь аймгийн ИТХ-аар асуудал хэлэлцүүлэхэд хариуцсан салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, зөвлөмж, шаардлагатай дүгнэлтийг танилцуулах үүрэгтэй боловч зорилгод чиглэсэн үйл ажиллагааг төдийлөн үр дүнтэй зохион байгуулж чадахгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас аймаг, сумдын ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд жил бүр аудит хийж, дүгнэлт өгч байна. Тухайлбал: аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд “Завхан аймгийн ТЕЗ-ийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг гүйцэтгэлийн шатанд дотоод хяналт үр нөлөөтэй” гэж үзсэн байна.

ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 24 төсвийн төвлөрүүлэн захирагч, 7 төрийн / орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 220 төсвийн шууд захирагч, нийт 251 байгууллагын санхүүгийн тайланг хамруулан аудит хийсэн байна. Эдгээрээс 127 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 20 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 3 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлтийг тус тус өгчээ.

Аудитаар төсвийн төлөвлөлт, зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, бусад тооцоололтой холбоотой нийт 6,438.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,617.8 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,319.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 91.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,409.8 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Хүснэгт 54. ЗАВХАН АЙМГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, САЯ.ТӨГ

	2019		2020	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан шаардлага	50	2,211.3	40	1,588.8
Төлбөрийн акт	43	104.2	70	313.9
Зөвлөмж	461	2,092.9	1,285	10,052.7
Залруулга	161	8,370.1	204	4,862.4
НИЙТ ЗӨРЧИЛ	729	12,801.0	1,628	16,881.9

Эх үүсвэр: Завхан аймгийн Төрийн аудитын тайлан

Сүүлийн 2 жилийн хугацаанд нийт давхардсан тоогоор 640 гаруй байгууллага (2020 онд санхүүгийн тайлангийн-305, гүйцэтгэлийн-8, нийцлийн-5)-д хяналт, шалгалт хийж, улмаар 2019 онд нийт 12.8 тэрбум төгрөгийн 729 зөрчил илэрч байсан бол 2020 онд зөрчлийн тоо 1.2 дахин, зөрчлийн хэмжээ 31.8 хувиар өсөж 16.8 тэрбум төгрөг болжээ. Зөрчлийн ангиллаар зөвлөмж 78.9 хувийг эзэлж байна.

2020 оны байдлаар аймгийн хэмжээнд гарсан зөрчил, алдааг задлан авч үзвэл: Нягтлан бодох бүртгэл (НББ), тайлагналтай холбоотой 290 удаагийн 10.0 тэрбум төгрөгийн зөрчил бий болсон нь нийт зөрчлийн дүнгийн 59.5 хувийг эзэлж байгаа бол төсвийн арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах тал дээр гаргасан зөрчил 2.7 тэрбум төгрөг байна. Нийт зөрчлийн тоогоор хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн хувьд төсвийн болон бусад санхүүгийн хууль, журмыг зөрчсөн 1,071 зөрчил байгаа нь нийт дүнгийн 65.8 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ

Фото зургийг Ч.Ихбаяр

Завхан аймгийн 2016-2020 оны төсвийн мэдээлэл дээр тулгуурлан хийсэн энэхүү судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

6.1 Дүгнэлт

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР

Завхан аймгийн татварын орлогын шинжилгээг 2016-2020 оны мэдээлэлд тулгуурлан хийж үзэхэд:

- Аймгийн төсвийн нийт орлого 2016 онд 58,183.8 сая төгрөг байсан бол 2020 онд 78,863.4 сая төгрөг болж 35.5 хувийн өсөлттэй, үүний дотор татварын орлого 2016 онд 6,771.4 сая төгрөг байсан бол 2020 онд 9,302.8 сая төгрөг болж 37.4 хувийн өсөлттэй байна. Ийнхүү орлогын хэмжээ нэмэгдсэний дүнд 2016 онд төсвийн нийт зарлагын 12.8 хувийг аймаг, суманд бий болсон орлогоор санхүүжүүлж байсан бол 2020 онд энэ харьцаа 16.9 хувь болж өсжээ. Гэвч татварын орлогын төлөвлөлтийг татварын бааз, суурьтай уялдуулж сайжруулах шаардлага байгаа нь жил бүр орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелж байгаагаас харагдаж байна. Тухайлбал: татварын орлогын төлөвлөгөө 2018 онд 18.7 хувь, 2019 онд 32.4 хувь, 2020 онд 21.8 хувиар тус тус давж биелсэн байна.
- Орон нутгийн өөрийн орлогын бүтэц сүүлийн 5 жилд төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд маш цөөн эх үүсвэрээс хамааралтай хэвээр байна. Тухайлбал 2020 оны байдлаар орон нутгийн төсвийн татварын орлогын
- 75.1 хувийг ХХОАТ-ын орлого, 10.3 хөрөнгийн албан татвар, 9.3 хувийг байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос тус тус бүрдүүлж байна. Эдгээр 3 төрлийн орлого нь орон нутгийн төсвийн татварын орлогын 94.7 хувийг бүрдүүлж байна.
- Татварын ерөнхий хуулийн 8.3-т заасны дагуу хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж, газрын төлбөр, нохойны албан татвар, байгалийн ургамал ашигласны төлбөр, рашаан ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тухайн татварын харилцааг зохицуулсан хуульд УИХ-аас тусгайлан эрх олгосны дагуу тогтоосон хязгаарт багтаан аймаг, нийслэлийн ИТХ тогтоохоор

заасан. Аймаг, сумын ИТХ нь хуулиар тусгайлан олгосон эрх хэмжээний хүрээнд өөрийн орон нутагт мөрдөх татварын хувь хэмжээг батлан, мөрдүүлдэг боловч Завхан аймгийн ИТХ-аас эдгээр татвар, төлбөр, хураамжийн хувь, хэмжээг тогтоосон хязгаарт багтааж хэрхэн баталсан талаарх бүрэн хэмжээний мэдээлэл олдсонгүй. Олдсон цөөн хэдэн тогтоолуудаас харахад хуулиар тогтоосон хязгаарын хамгийн доод хэмжээгээр тогтоосон байгаа төдийгүй зарим тогтоолуудыг цаг хугацааны хувьд ч шинэчлэх шаардлагатай болсон байна.

- Сангийн яамнаас төсвийн суурь орлого, суурь зарлагын тооцоолол дээр үндэслэн улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг баталдаг. Сангийн яамны хянасан суурь орлогын дүнг авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвараас бусад татварыг нэмэгдүүлэлгүйгээр ИТХ-аар баталсан байна. Өөрөөр хэлбэл татварын хувь хэмжээний хамгийн бага интервалаар тооцож орон нутгийн төсвийн орлогыг хянаж байгаа боловч аймгийн ИТХ-ын тогтоолоор татварын хувь хэмжээг батлахдаа доод хэмжээгээр баталснаас нийт орлогын хэмжээ нэмэгдэхгүй байна.
- “Төсвийн тухай” хуулийн 64.1.2 дахь хэсэгт тухайн жилийн төсөв, түүний тодотголыг хэлэлцэж батлах эрхийг ИТХ-ын бүрэн эрхээр хуульчлан баталсан байхад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2019, 2020 онд аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 29- ний өдрийн 65 дугаар тогтоолоор аймгийн төсвийн орлогыг 250.5 сая төгрөгөөр, 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 78-р тогтоолоор аймгийн төсвийн орлогыг 982.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан.
- Завхан аймагт орон нутгийн өмчит таван аж ахуйн нэгж байгаа бөгөөд тэдгээр нь 2020 оны жилийн эцсийн байдлаар бүгд алдагдалтай байна. УИХ-д өргөн барьсан 2022 оны төсвийн төсөлд тухайн төсвийн жилд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор засаглал, бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогын шинэчлэлийг тус тус хэрэгжүүлэхээр заасан байна. Энэ бодлогын зорилтын хүрээнд Завхан аймаг ОНӨҮГ-уудын алдагдлыг бууруулж, ашигтай ажиллах, улмаар орон нутгийн төсөвт ногдол ашиг төвлөрүүлэх талаар бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Сумдын төсвийн орлого бүрдүүлэлт, аймгийн төсвийн орлогод эзлэх хувийн жинг тооцож, дүгнэлт хийхэд 2016-2020 онд сумдын төсөвт нийтдээ 9,985.9 сая төгрөгийн татварын орлого төвлөрсөн нь аймгийн нийт татварын орлогын 23.6 хувь болж байна. Аймгийн татварын нийт орлогод эзлэх хувийн жинг авч үзэхэд Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумдаас бусад сумын орлого 5.0-с доош хувийг эзэлж байна. Энэ нь сумын төсөв дээд шатны төсвөөс ихээхэн хараат байдалтай, үндсэндээ тусламж санхүүжилтийн орлогоор зарлагаа санхүүжүүлж байгааг харуулж байна.
- Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг баталж, орон нутгийн төсвийн эх үүсвэр болгосноор жилд нэг тэрбум орчим төгрөгийн татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ОНХС-аар дамжуулан орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломж нээгдэж байна.
- Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийн нөлөөллөөр аймаг, сумын орон нутагт орох татварын нэр төрлийг нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор 2022 онд сумын төсөвт орох татварын орлого 6.8 тэрбум орчим төгрөгөөр нэмэгдэх тооцоолол гарч байна. Ингэснээр аймгаас өгөх санхүүгийн дэмжлэгт найдсан идэвхгүй байдал өөрчлөгдөж, орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх талаар сумын удирдлагуудын санаачилга, хариуцлага дээшилж орон нутгийн төсвийн бие даасан байдалд ахиц гарах юм. Түүнчлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.

- Тус аймаг болон сумын хүн ам цөөн, ялангуяа сумдад дэд бүтэц муу хөгжсөн, үйлдвэрлэл, худалдаа хөгжих боломж муу зэрэг нөхцөл байдал нь орлогын тогтвортой эх үүсвэр бий болох боломжийг хязгаарлаж байгаа хэдий ч байгаа нөхцөл байдал дээрээ тулгуурлан орлогоо үндэслэлтэйгээр, орлогын эх үүсвэрийг дайчлан төлөвлөж батлахгүй байгаагаас жил бүр орлогын төлөвлөгөө өндөр хувиар давж биелж байна. Мөн татварын орлого төлөвлөсөн суурь үзүүлэлтүүд бүртгэлийн байгууллагын бүртгэл, мэдээллээс зөрүүтэй байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР

Төсвийн тухай хуульд заасан ангиллын дагуу Завхан аймгийн төсвийн зарлагад шинжилгээ хийгээд дараах дүгнэлтийг гаргалаа.

- Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд заасны дагуу аймгийн орон нутгийн төсвөөр 19 чиг үүрэг, сумын орон нутгийн төсвөөр 10 чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ба одоогоор төлөөлөн хэрэгжүүлэх 5 чиг үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн орон нутгийн төсвийн нийт зарлагын 76.6 хувийг сумын төсвийн зарлага, 23.4 хувийг аймгийн төсвийн зарлага эзэлж байна. Нийт төсвийн зарлагын 61.3 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардал, 38.7 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал эзэлж байгаа бөгөөд нийт зарлагын 91 хувийг үйл ажиллагааны урсгал зардал, 8 хувийг хөрөнгийн зардал, 1 хувийг зээлийн зардал тус тус эзэлж байна.
- Завхан аймгийн төсвийн нийт зарлагын 90.1 хувийг урсгал зардал эзэлж байгаа тул эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байр бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах, ард иргэдийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, иргэдийн амьдрах орчныг сайжруулах зэрэг хөгжлийн бодлогын түвшний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төсвийн эх үүсвэр хангалтгүй байна.
- 2016-2020 онд аймгийн төсвийн нийт зарлагын 11.9-14.1 хувийг орон нутгийн өөрийн орлогоор бүрдүүлсэн байна.
- Завхан аймгийн 2016-2020 оны төсвийн нийт зарлагад цалин, тогтмол зардлын эзлэх хувь жил бүр өсөж, нийт зарлагын 82.5 хувьд хүрч, хангамж бараа материалын зардал жилээс жилд буурсаар байгаа нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орон нутгийн чиг үүрэг, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөрөг нөлөөллийг бий болгохоор байна.
- 2020 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээллээс харахад СӨБ болон ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ Засгийн газрын тогтоолоор баталсан нормативаас өндөр дүнтэй байгаа бөгөөд үүний шалтгаан нь 2016 оноос хойш үнийн өсөлт, инфляц, цалингийн өсөлт зэргийг харгалзан үзэж нормативыг шинэчлээгүйтэй холбоотой байна. Иймд боловсролын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэх, үнийн өсөлт, инфляцтай уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож байх зайлшгүй шаардлага байна.
- 2020 оноос эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйг шинэчлэн, эрүүл мэндийн багц хуульд өөрчлөлт оруулсан. Ингэснээр эмнэлгүүд үзсэн, эмчилсэн хүний тоогоор ЭМД-ын сангаас санхүүжилт авч эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх эх үүсвэр болгохоор хуульчилсан ч сумын эмнэлгүүд төлөвлөсөн хэмжээндээ санхүүжилт авч чадахгүй бол эмнэлгийн ажиллагсдын цалинг нэмэгдүүлэх боломжгүй болж, зардлаа бүрэн хэмжээнд санхүүжүүлж чадахгүйд хүрэх эрсдэл байна.

ТӨСВИЙГ ӨРГӨН БАРИХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ, БАТЛАХ ҮЙЛ ЯВЦЫН ТАЛААР

- ИТХ-д төсвийн төслийг өргөн барихдаа төсвийн тухай хуулийн 67.2-т заасны дагуу дэлгэрэнгүй танилцуулгыг ойлгомжтой байдлаар бэлтгэж хүргүүлээгүй байна.
- Аймгийн ИТХ-ын төсөв баталсан тогтоолоор аймаг сумын нийт төсвийн орлогын хэмжээг баталсан байгаа нь доод шатны ИТХ-ыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болгож сумын хурал нь сумын төсвийн орлого зарлагыг ёсчлох төдийгөөр тогтоол гаргаж байна.
- Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлахдаа зөвхөн орлого зарлагын гүйцэтгэлийг хэлэлцэн баталж байна. Тухайн жилийн төсөв болон төсвийн гүйцэтгэлийг хэлэлцсэн ИТХ-ын хуралдааны тэмдэглэлээс үзэхэд, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөлт, шалгуур үзүүлэлт болон хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнгийн талаар хэлэлцсэн зүйлгүй байгаа нь төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд ач холбогдол өгөхгүй байгааг харуулж байна.
- Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ИТХ-аар батлаагүй, харин аймаг, сумын Засаг даргын захирамжаар баталсан байна.

СХС-ИЙН ТӨСВИЙН ТАЛААР

- Завхан аймгийн бүх сумдын хэмжээнд 2016-2020 онд нийт 6,704.7 сая төгрөгийн зээлийг 1,322 хүнд олгож 1,300 шинэ ажлын байр бий болгосон байна. Сумдын “Сум хөгжүүлэх сан”-гийн нийт эх үүсвэр 2021 оны эхний хагас жилийн байдлаар 6,482.0 сая төгрөг байгаа бөгөөд сангийн дансанд 995.0 сая төгрөг, 1,663 зээлдэгчдэд 5,487.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлийн үлдэгдлийн 57.1 хувь нь хугацаа хэтэрсэн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа нь зээлийн эргэлтэд муугаар нөлөөлж сангийн үндсэн зорилгыг хангаж чадахгүйд хүрэх эрсдэлийг дагуулж байна. Иймээс СХС-ийн зээлийн олголт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналтад онцгой анхаарч, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
- Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын төсвийг сумын ИТХ-ын тогтоолоор баталж, гүйцэтгэл нь сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдэж байна.
- Сум хөгжүүлэх сангаас тухайн жилд санхүүжүүлэх төслийн зориулалт болон нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг ИТХ-ын тогтоолоор баталдаг бөгөөд сум хөгжүүлэх сангийн зээлийн ажлын хэсэг төслийг сонгон шалгаруулж, санхүүжүүлэх эрхийг сумын төрийн санд олгож, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралд тайлагнаж байна.
- Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн үр дүнг Төсвийн тухай хуульд заасан цагалбарын дагуу сумын сар, улирал, жилийн мэдээ, тайланд нэгтгэж, улмаар аймгийн мэдээ тайланд тусгагдах замаар Сангийн яаманд тайлагнагдаж байна. Мөн сумын ЗДТГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн сангийн бүрдүүлэлт зарцуулалтын мэдээг сум хөгжүүлэх сангийн мэдээллийн санд шивж, мэдээлэл нь ХХААХҮ-ийн яамны ЖДҮ-ийн газарт нэгтгэгдэж байна.
- Төрийн аудитын байгууллагаас сумдын СХС-ийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт хийж

байна. Тухайлбал, Төрийн аудитын зүгээс СХС-гийн үйл ажиллагаанд 2019 онд хяналт, шалгалт хийсэн тайланд тус оны эхэнд аймгийн дүнгээр СХС 5,120.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд 1,435.6 сая төгрөгийн зээл олгож, 1,064.4 сая төгрөгийн зээлийг төлүүлэн, оны эцэст 5,491.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагийн 59.8 хувь буюу 3,253.9 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, үүний 41.4 хувь буюу 1,347.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар шүүхэд хандсан, шүүхийн захирамжийн 39.8 хувь буюу 536.1 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар ШШГГ-ай гэрээ байгуулсан гэж дурдсан байна. Энэ дүгнэлтээс харахад сум хөгжүүлэх сангийн зээлийн олголт, бүрдүүлэлт нь орон нутгийн удирдлагуудын ажилд ихээхэн ачаалал бий болгож, хүндрэл учруулж байгаа бөгөөд санхүүгийн зөрчилд орох эрсдэлтэй байгаа тул зээлийг банкаар дамжуулан олгох, Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

ОНХС-ИЙН ТӨСВИЙН ТАЛААР

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг судалж үзэхэд 2017 онд өмнөх жилээс 59.2 хувиар буурч 1.7 тэрбум төгрөгийн эх үүсвэртэй болсон нь сүүлийн 5 жилийн хамгийн бага үзүүлэлт байгаа бөгөөд Засгийн газраас 2018 оноос Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авснаар 2018 онд 20.3 хувиар, 2019 онд 48.4 хувиар өссөн ба цар тахлын нөхцөл байдлын улмаас үүссэн орлогын эх үүсвэрийн бүрдүүлэлттэй уялдаж 2020 онд 17 хувиар буурсан байна. ОНХС-гийн эх үүсвэр Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэртэй уялдан жил бүр шахам өөрчлөгдөж байгаа нь орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан урьдчилан төлөвлөх боломжгүй болгож байна.
- 2017 оноос ОНХС-гаас аймагт хуваарилагдсан эх үүсвэрийн 30 хувийг суманд, 70 хувийн аймагт хуваарилдаг болсон ба 2018 онд Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр улсын төсвөөс олгож байсан мал эмнэлгийн үйлчилгээний зардал, нийтийн тээврийн үйлчилгээний хөнгөлөлт, усны хөнгөлөлт, гэрэлтүүлэг, цэвэрлэгээ хог зайлуулахтай холбогдох зардлыг ОНХС-гаас санхүүжүүлдэг болсноор хөрөнгийн зардлын хэмжээ буурч байна. ОНХС-гаас урсгал зардалд жилд дунджаар 300 гаруй сая төгрөг зарцуулж байна.
- ОНХС-гийн үйл ажиллагааны үнэлгээнд нийт эх үүсвэрийн ихэнх хувийг зарцуулж байгаа аймгийн ОНХС хамрагдахгүй байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр хийсэн нийт хөрөнгө оруулалтын 10.6 хувийг боловсролын салбарт, 11.8 хувийг эрүүл мэндийн салбарт, 15.7 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 6.8 хувийг байгаль орчинд, 7.7 хувийг усан хангамжид, 12.9 хувийг барилга байгууламжид, 3.6 хувийг төрийн удирдлагын үйл ажиллагаанд зарцуулж 30.9 хувийг тээвэр, холбоо, цахилгаанжуулалт зэрэг дэд бүтцийг сайжруулахад тус тус зарцуулсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлийн зохион байгуулалт сайжирч жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр жил бүр сайжирсан үр дүн үзүүлж байгаа боловч үзүүлэлт бүр улсын дунджаас доогуур байгаа тул орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналт, үнэлгээ, иргэдийн оролцоо, ил тод байдлыг илүү сайжруулж, хүрсэн түшинг ахиулахад анхаарах шаардлагатай.

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН ТАЛААР

- Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолын дагуу төсвийн байгууллага бүрт дотоод хяналтын баг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилготой Санхүүгийн хяналт, аудитын алба нь Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Санхүүгийн хяналт дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан дотоод хяналт, аудит хийхээс илүү санхүүгийн хяналт, шалгалтад чиглэсэн байдлаар явагдаж байна. Аймгийн СТСХ нь төсвийн тухай хуулийн 36.6-д заасны дагуу сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ыг мөрдлөж байна. Сумдын төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах талаар арга хэмжээ авч, хэрэгжүүлсэн.
- Хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсвийн гадаад хяналтын төрийн аудитын байгууллага, шат шатны ИТХ, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хэрэгжүүлж байна. 2016-2020 онд аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хөгжлийн бодлого, салбарын тулгамдсан асуудлуудад судалгаа, хяналт-үнэлгээ хийж ИТХ-аар асуудал хэлэлцүүлэн батлуулах зорилготой бодлогын хороодыг байгуулсан байна. Эдгээр хороод нь аймгийн ИТХ-аар асуудал хэлэлцүүлэхэд хариуцсан салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, зөвлөмж, шаардлагатай дүгнэлтийг танилцуулах үүрэгтэй боловч төдийлөн зорилгод чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж чадахгүй байна. Ялангуяа төсвийн хяналтад иргэд, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулсан талаар мэдээлэл байхгүй байна.
- Төрийн аудитын байгууллагаас аймаг, сумдын санхүүгийн нэгтгэсэн тайланд болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд гүйцэтгэлийн аудит хийж байна. Жилд дунджаар 300 гаруй байгууллагад аудит хийж байгаа ба 2020 онд санхүүгийн тайлангийн аудит-305, гүйцэтгэлийн аудит-8, нийцлийн аудит 5-ыг гүйцэтгэсэн байна. 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд гарсан зөрчил, алдааны 59.5 хувь нь НББ, тайлагналтай холбоотойбайгаа бол төсвийн арвилан хэмнэлт, үр ашигтай зарцуулах тал дээр гаргасан зөрчил 16 хувийг, төсвийн болон бусад санхүүгийн хууль, тогтоомжийг зөрчсөн зөрчил 24.4 хувийг тус тус эзэлж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТТЭЙ ТӨСВИЙГ УЯЛДУУЛАХ ТАЛААР

- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн үндсэн чиглэлийг төлөвлөж батлахдаа тухайн арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүжүүлэх эх үүсвэрийг тусган баталж, гүйцэтгэлийг тайлагнахдаа мөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө, эх үүсвэрийн мэдээллийг арга хэмжээ тус бүрээр тайлагнасан байна.
- Сүүлийн 5 жилийн байдлаар орон нутгийн нийт зардлын 8 орчим хувийг эзэлж байгаа хөрөнгийн зардал нь тухайн жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангахад чиглэж байгаа бөгөөд энэ нь

шаардлагатай хөрөнгийн 15-18 хувьтай тэнцэж байна. Бусад шаардлагатай эх үүсвэрийг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн байна. Дээрх байдлаас дүгнэлт хийхэд бага ч гэсэн орон нутгийн төсвийг төлөвлөхдөө хөгжлийн бодлого зорилттой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, САЛБАРЫН САЙДТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

- Завхан аймгийн Засаг дарга 2020 онд Засгийн газрын гишүүн салбарын сайдтай 15 гэрээ байгуулсан бөгөөд эдгээр гэрээний хэрэгжилт 96.1 хувь байна. Аймгийн Засаг даргаас салбарын сайдтай байгуулах гэрээнд тусгах санал хүргүүлдэг боловч эдгээрийг гэрээнд бүрэн тусгахгүйгээр, харин орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, хэрэгжих боломжгүй, хөрөнгө их шаардсан ажлуудыг гэрээнд тусгасан нь гэрээний биелэлтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний 8.1 дэх заалтад "Аймгийн шүүхийн шинжилгээний албанд хэргийн газрын үзлэг болон шинжилгээ хийхэд шаардлагатай орчин үеийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх", 8.3 дах заалтад "Шүүхийн шинжилгээний албанд томилогдсон албан хаагчдын албаны орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх" зэрэг асуудлууд тусгагдсан байна. Иймээс салбарын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулах гэрээний төлөвлөлт, боловсруулалтыг хийхдээ ЗЗНДНТУ-ын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх орон нутгийн чиг үүрэгт хамаарах асуудлыг тусгах, харин чиг үүрэгт хамаарахгүй асуудлыг тусгасан тохиолдолд үүнд шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэсэн нөхцөлд гэрээнд тусгах нь зүйтэй.
- Аймгийн Засаг дарга, ЗДТГ болон салбар хариуцсан агентлагууд Аймгийн Засаг даргын салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллагын болон ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилт үр дүнг тооцон дүгнэж ажилласан байна.

Аймгийн Засаг даргаас ХНХ-ын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсвийн хэрэгжилт, үр дүнг төслийн үйл ажиллагаатай холбогдуулан нарийвчлан судалж үзсэний үндсэн дээр судалгаа, шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Завхан аймгийн хөдөлмөрийн салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн судалгаанд хамрагдсан бусад орон нутгийн байгууллагуудын нэгэн адил тодорхойгүй байна.
- Завхан аймагт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө 2020 онд огцом буурсан нь сангийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд бий болдог ажлын байр 38.4 хувиар буурахад нөлөөлсөн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас болон Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа нь хөрөнгийн үр ашгийг бууруулж энэ чиглэлээр зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орох эрсдэлтэй болж байна. Төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийг сайн судалж, зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах замаар зээлийн эрсдэлийг бууруулж, төсвийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай.

- Аймаг, сумын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хамрагдалтын талаарх мэдээллийг тодорхой болгож, мэдээллийн хүртээмжийг сайжруулах.
- Завхан аймаг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгайлсан хөтөлбөргүй ч аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг бий болгох зорилтот арга хэмжээг тусган, хэрэгжилтийн үр дүнг тооцон ажиллаж байна.
- Төсвийн тухай хуулийн 58-р зүйлд аймаг, нийслэл өөрийн төсвөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Харин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь дэд сантай байх бөгөөд дэд санд аймаг, нийслэл, дүүргийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байхаар журамласан. Завхан аймгийн хувьд одоогоор орон нутгийн төсвөөс дэд санд хуваарилалт хийгдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.6-д “хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх”-аар хуульчилсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь тухайн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй хувийг хөдөлмөр эрхлэлтийн дэд санд төвлөрүүлэхээр тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

6.2 Орон нутгийн төсөвт тулгамдаж буй зарим асуудлыг шийдвэрлэх санал зөвлөмж

1. Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлтөд чиглэсэн Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал” зэрэг эрх зүйн актууд байгаа боловч орон нутгийн төсвийн орлогыг төлөвлөх арга аргачлалаар хангасан зүйл байхгүй байна. Иймээс төсвийн орлогыг төлөвлөх арга, аргачлалаар хангасан эрх зүйн акт бий болгож мөрдүүлэх шаардлагатай.
2. Малын тоо толгойн албан татварыг малын төрлөөс үл хамааруулан 0-2000 төгрөгөөр тогтоохоор хуульчилсан нь татварыг 0 төгрөгөөр тогтоож татвар авахгүй байх нөхцөл бүрдэж байгаа тул хуулийн заалтыг эргэн харж бага ч гэсэн татвар тогтоон авч, зориулалтын дагуу зарцуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх.
3. ОНХС-аас хөрөнгийг хуваарилахдаа уул уурхай хөгжсөн орон нутагт илүү хөрөнгө хуваарилагдах зарчим үйлчилж байгаа нь бүс нутгийн хөгжлийн ялгаатай байдлыг нэмэгдүүлж байгаа тул хөрөнгийг хуваарилахдаа орон нутгийн хөгжлийн индексийг гол харгалзах үзүүлэлт болгож, ОНХС-ын хөгжил сул орон нутагт түлхүү хуваарилах бодлогыг хэрэгжүүлж, ОНХС-ийн зорилготой нийцүүлэх.
4. ОНХС-ийн үйл ажиллагаанд жилийн гүйцэтгэлийн үнэлгээ нь ОНХС-ын 30 хүрэхгүй хувийг хамарч байгаа тул хөрөнгийн ихэнх хувийг зарцуулж байгаа аймаг, нийслэлийн ОНХС-ын хөрөнгийн зарцуулалтыг жилийн гүйцэтгэлийн үнэлгээнд хамруулдаг болох.

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа нь хөрөнгийн үр ашгийг бууруулж, энэ чиглэлээр зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орох эрсдэлтэй болж байгаа тул сангийн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлэлт, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээ авах.
6. Орон нутгийн төсвийн нийт зарлагад цалин, тогтмол зардлын эзлэх хувь жил бүр өсч, нийт зарлагын 80 гаруй хувьд хүрч, харин бусад бараа үйлчилгээний зардал жилээс жилд буурсаар байгаа нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орон нутгийн чиг үүрэг, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд сөрөг нөлөөллийг бий болгохоор байгаа тул орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцохдоо бараа үйлчилгээний зардлыг нэмэгдүүлэх, хөдөө орон нутагт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг чадавхжуулах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад чиглэсэн сургалтын болон хөрөнгийн зардлыг суурь зарлагад тооцон тусгадаг болох шаардлагатай. Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлалд өөрчлөлт оруулах.
7. ЗЗНДНТУТ хуулийн шинэчлэл, Төсвийн тухай хуульд заасан орлогын ангиллын өөрчлөлтөөр аймаг, суманд нэмэгдэж байгаа орлогыг тухайн нутаг орны хөгжилд зарцуулах бодит эх үүсвэр болгох нөхцөлийг бүрдүүлэх.
8. Салбарын сайд нар орон нутгийн Засаг даргатай гэрээ байгуулахдаа салбарынхаа зарим хөрөнгө шаардсан асуудлыг орон нутгийн төсвөөр шийдүүлэх тухай заалт оруулдаг буруу практикийг өөрчлөх, гэрээг ЗЗНДНТУ-ын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх, чиг үүрэгт хамаарах асуудлыг тусгах, чиг үүрэгт хамаарахгүй асуудлыг хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэсэн нөхцөлд гэрээнд тусгах.
9. СӨБ болон ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээ Засгийн газрын тогтоолоор баталсан нормативаас өндөр дүнтэй байна. Иймээс үнийн өсөлт, инфляц, цалингийн өсөлт зэргийг харгалзан нормативыг шинэчлэх.
10. 2020 оноос эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйг шинэчлэн, эрүүл мэндийн багц хуульд өөрчлөлт оруулсан. Ингэснээр эмнэлгүүд үзсэн, эмчилсэн хүний тоогоор ЭМД-ын сангаас санхүүжилт авч, эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх эх үүсвэр болгохоор хуульчилсан ч хүн ам цөөн сумын эмнэлгүүд төлөвлөсөн хэмжээндээ санхүүжилт авч чадахгүй байх нөхцөл бий болж байна. ЭМД-ын санхүүжилт нь эмнэлгийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх хөшүүрэг болж чадаж байгаа эсэхийг нарийвчлан судалж үзэх шаардлагатай.
11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгтгэдэг болох. Ингэснээр улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн салбарын нийт хөрөнгө оруулалт нэгдсэн байдлаар гарах боломжтой болно.
12. Төсвийн тухай хуулийн 6.4.6-д “хуульд өөрөөр заагаагүй бол төсвийн орлогыг аль нэг этгээд, эсхүл үйл ажиллагаанд тусгайлан оноохгүй байх” – аар хуульчилсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журамд аймаг нийслэл дүүрэг нь тухайн төсвийн орлогын 0,3-с доошгүй хувийг хөдөлмөр эрхлэлтийн дэд санд төвлөрүүлэхээр тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна.

ХАВСРАЛТУУД



Хавсралт 1.

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, НЭР ТӨРЛИЙН АНГИЛЛААР, ЖИЛЭЭР

Орон нутгийн төсвийн орлогын ангилал	2016	2017	2018	2019	2020
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	21,738.9	62,789.0	67,606.2	62,518.6	78,863.4
ТАТВАРЫН ОРЛОГО	6,771.3	8,443.1	8,445.5	9,302.8	9,292.3
Орлогын албан татвар	5,088.6	6,641.4	5,800.7	6,185.8	6,976.2
Хувь хүний орлогын албан татвар	5,539.2	6,194.0	6,449.0	6,771.8	7,650.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	5,217.1	5,423.7	5,244	5,790.9	6,533.9
Үйл ажиллагааны орлого	184.6	564.9	398.1	292.8	686.1
Хөрөнгийн орлого			172.4	341.7	227.5
Хөрөнгө борлуулсны орлого	16.7	28.8	50.4	21.4	2.2
Шууд бус орлого	120.7	176.6	583.6	324.9	200.1
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(811.8)	(917.6)	(932.0)	(849.8)	(753.0)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(811.8)	(917.6)	(932.0)	(849.8)	(753.0)
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	361.3	365.0	283.7	263.8	79.2
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	361.3	365.0	283.7	263.8	79.2
Хөрөнгийн албан татвар	431.0	872.1	651.2	700.4	749.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	121.2	540.7	307.1	326.0	331.9
Бууны албан татвар	44.3	52.0	55.9	52.2	59.0
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	265.4	279.3	288.1	322.1	358.5
Бусад татвар, төлбөр, хураамж	1,251.6	1,929.4	1,993.6	2,416.5	1,566.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	280.3	302.3	396.8	350.0	407.7
Улсын тэмдэгтийн хураамж	171.3	160.8	225.7	217.6	262.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.1	9.4	43.4	29.0	27.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	98.1	131.0	127.6	103.3	117.6
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	0.6	0.9			

Бусад татвар	0.1				
Газрын төлбөр	174.9	191.4	354.1	407.3	276.7
Газрын төлбөр	174.9	191.4	354.1	407.3	276.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	417.9	715.0	666.7	1,019.3	865.4
Ойн нөөц ашигласны төлбөр	194.7	235.6	240.3	294.4	324.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	42.7	48.9	137.8	435.5	5.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	173.0	349.8	281.3	280.1	318.5
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.4	80.5	7.3	9.3	217.1
Бусад татвар	378.4	720.7	575.8	639.9	16.7
Бусад татвар	378.4	720.7	575.8	639.9	16.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,967.6	54,345.8	59,160.6	53,036.9	69,232.2
Нийтлэг татварын бус орлого	3,918.4	4,374.5	3,643.6	2,259.6	3,626.3
Хүүгийн орлого				552.9	1,094.3
Торгуулийн орлого				27.8	763.1
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,931.9	2,135.8	2,080.9	1,672.6	1,639.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,274.8	1,958.1	1,668.1	1,672.6	1,615.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	326.9	177.7	412.7		23.6
Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		2.7			
Бусад орлого	764.7	819.2		6.2	129.6
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	1,221.7	1,419.5	1,562.7		
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	11,049.1	49,971.3	55,517.3	50,777.3	65,605.9
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35,432.4	37,656.1	38,914.7	36,294.9	42,431.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого		1,708.6	3,471.2		4,276.7
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	11,049.1	10,606.5	13,131.0	14,482.3	18,897.9
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО				178.9	338.8
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				178.9	338.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих				178.9	338.8

Хавсралт 2.

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, НЭР ТӨРЛИЙН АНГИЛЛААР, ЖИЛЭЭР, САЯ ТӨГ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7
УРСГАЛ ЗАРДАЛ	53,540.6	56,725.1	58,044.3	59,458.5	68,886.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,095.5	44,823.9	47,865.6	58,105.4	67,672.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,804.8	28,627.5	29,854.3	36,204.2	43,552.3
Үндсэн цалин	23,788.0	23,726.0	22,856.2	27,474.9	31,116.3
Нэмэгдэл	2,334.1	2,508.9	4,379.6	5,989.2	8,765.8
Унаа хоолны хөнгөлөлт	49.8	60.9	188.4	268.3	327.4
Урамшуулал	1,357.3	1,051.7	1,264.0	1,798.2	2,594.7
Гэрээт ажлын хөлс	1,275.7	1,280.1	1,166.1	673.6	748.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,313.9	3,160.7	3,592.9	4,554.5	5,728.5
Тэтгэврийн даатгал	2,279.8	2,190.6	2,496.5	3,151.0	4,006.6
Тэтгэмжийн даатгал	196.0	223.8	262.4	364.2	443.1
ҮОМШӨ-ний даатгал	245.1	218.3	219.9	276.6	343.5
Ажилгүйдлийн даатгал	63.4	55.7	61.5	69.0	91.5
Эрүүл мэндийн даатгал	529.6	472.3	552.6	693.7	843.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,904.4	5,448.7	5,778.6	6,284.8	7,495.3
Гэрэл, цахилгаан	354.9	373.2	389.7	460.0	397.2
Түлш, халаалт	4,400.6	4,915.3	5,219.3	5,657.6	6,940.0
Цэвэр, бохир ус	137.6	151.6	161.1	167.0	158.2
Байрны түрээс	11.2	8.6	8.6	0.3	0.0
Хангамж, бараа материалын зардал	1,344.7	1,360.4	1,772.8	1,751.9	1,930.8
Бичиг хэрэг	159.2	178.1	225.7	295.2	332.2
Тээвэр, шатахуун	786.5	860.9	1,034.4	1,072.2	1,002.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	125.6	124.5	136.9	158.2	205.7
Ном, хэвлэл	17.7	17.0	20.6	21.0	47.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51.5	44.8	66.5	17.8	20.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	204.3	135.0	288.7	187.6	322.8
Нормативт зардал	2,643.5	2,572.8	2,702.1	2,991.8	2,428.8
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300.3	337.9	317.1	452.8	437.3
Хоол, хүнс	2,252.8	2,110.4	2,219.3	2,368.2	1,782.0

Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.4	124.5	165.7	170.8	209.5
Эд хогшил, урсгал засварын зардал	341.3	473.9	549.5	453.4	384.2
Багаж, техник, хэрэгсэл	27.2	30.5	32.5	97.6	136.3
Тавилга	27.3	0.0	4.7	3.1	17.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3.4	0.0	0.0	3.4	6.5
Урсгал засвар	283.4	443.3	512.3	349.3	224.2
Томилолт, зочны зардал	207.6	230.5	255.1	484.3	214.6
Дотоод албан томилолт	207.6	230.5	255.1	484.3	214.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	957.8	978.5	1,260.7	2,825.8	2,599.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	925.6	947.2	1,231.9	2,580.8	2,328.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8.4	8.5	8.6	14.2	19.7
Даатгалын үйлчилгээ	10.6	7.6	7.0	18.2	19.6
Тээврийн хэрэгслийн татвар	3.3	3.3	6.7	6.5	7.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.5	1.0	1.1	2.3	2.3
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7.6	7.8	2.0	7.5	215.1
Газрын төлбөр	1.1	1.0	0.3	4.1	4.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.7	2.1	3.2	192.2	1.4
Бараа үйлчилгээний бусад зардал	1,577.5	1,970.7	2,099.5	2,554.6	3,338.5
Бараа үйлчилгээний бусад зардал	1,555.8	1,918.1	1,812.6	2,063.7	2,645.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21.7	52.7	286.8	491.0	693.4
ТАТААС	20.0	29.5	20.3	34.0	13.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20.0	29.5	20.3	34.0	13.8
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	20.0	29.5	20.3	34.0	13.8
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,425.1	11,871.7	10,158.4	1,319.0	1,200.8
Бусад урсгал шилжүүлэг	9,425.1	11,871.7	10,158.4	1,319.0	1,200.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,921.4	6,944.5	7,245.5	278.3	127.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12.7	476.5	51.6	47.3	68.5
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	689.8	660.5	723.0	724.1	383.7
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,328.1	883.0	1,144.0	247.8	563.1

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	349.0	1,692.4	865.3	0.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	124.0	1,214.8	129.1	21.5	58.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,545.4	3,155.3	6,366.7	5,670.2	6,179.3
Их засвар	203.8	302.2	0.0	0.0	0.0
Бусад хөрөнгө	4,341.5	2,853.1	6,366.7	5,670.2	6,179.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	829.4	1,476.6	1,414.0	1,579.6	1,390.6
Эргэж төлөгдөх зээл	829.4	1,476.6	1,414.0	1,579.6	1,390.6
ЗАРДЛЫ Г САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,472.7	60,664.0	66,149.3	66,691.5	76,746.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,431.9	37,656.1	38,914.7	36,276.7	42,431.1
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	35,431.9	37,656.1	38,914.7	36,276.7	42,431.1
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,371.0	20,877.7	25,153.6	28,563.3	32,337.1
Орон нутгийн төсвөөс	22,371.0	19,169.1	21,682.4	23,410.5	28,060.3
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		1,708.60	3,471.2	5,152.8	4,276.8
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				178.9	338.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих				178.9	338.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,669.8	2,135.8	2,080.9	1,672.6	1,639.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,506.0	1,958.1	2,063.4	1,630.6	1,615.7
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	163.8	177.7	17.4	41.9	23.6

Хавсралт 3.

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГО, САЯ ТӨГ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
ТАТВАРЫН ОРЛОГО	6,771.4	8,443.1	8,445.6	9,302.8	9,292.4
Орлогын албан татвар	5,088.6	5,641.5	5,800.8	6,185.9	6,976.2
Хувь хүний орлогын албан татвар	5,539.2	6,194.1	6,449.1	6,771.9	7,650.0
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	5,217.0	5,423.7	5,244.4	5,790.9	6,534.0
Үйл ажиллагааны орлого	184.7	564.9	398.1	292.8	686.1
Хөрөнгийн орлого	0.0	0.0	172.4	341.7	227.6
Хөрөнгө борлуулсны орлого	16.8	28.8	50.4	21.4	2.2
Шууд бус орлого	120.7	176.6	583.6	324.9	200.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-811.9	-917.7	-932.0	-849.9	-753.1
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	361.3	365.1	283.7	263.9	79.2
Хөрөнгийн албан татвар	431.1	872.1	651.2	700.4	749.6
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	121.2	540.7	307.2	326.0	331.9
Бууны албан татвар	44.4	52.1	55.9	52.3	59.1
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	265.5	279.3	288.1	322.1	358.5
Бусад татвар, төлбөр, хураамж	1,251.7	1,929.5	1,993.6	2,416.6	1,566.6
Бусад нийтлэг төлбөр, хураамж	280.3	302.3	396.8	350.0	407.7
Улсын тэмдэгтийн хураамж	171.3	160.9	225.8	217.6	262.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.2	9.5	43.4	29.1	27.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	98.2	131.1	127.6	103.3	117.7
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж	0.6	0.9	0.0	0.0	0.0
Бусад татвар	0.1	0.0	0.0	0.0	0.0
Газрын төлбөр	175.0	191.4	354.1	407.3	276.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	418.0	715.0	666.8	1019.3	865.5
Ойн нөөц ашигласны төлбөр	194.7	235.7	240.3	294.4	324.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	42.8	49.0	137.8	435.5	5.3
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	173.0	349.8	281.3	280.1	318.6
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.4	80.6	7.4	9.4	217.1
Бусад татвар	378.4	720.7	575.9	639.9	16.7

Хавсралт 4.

ЗАВХАН АЙМГИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ, СУМААР

Сумын нэр	Татварын орлого /сая төгрөгөөр/				
	2016	2017	2018	2019	2020
УЛИАСТАЙ	122.0	577.2	711.0	386.5	406.2
ТОСОНЦЭНГЭЛ	121.9	222.6	293.8	401.4	356.1
ИХ УУЛ	91.8	198.9	157.2	148.2	393.4
ДӨРВӨЛЖИН	44.6	45.4	69.1	111.7	191.7
ЭРДЭНЭХАЙРХАН	68.0	97.2	105.6	100.6	80.7
ИДЭР	51.1	72.6	116.4	97.9	98.8
НӨМРӨГ	26.7	61.6	76.4	183.3	42.2
ШИЛҮҮСТЭЙ	60.4	55.4	89.3	108.5	34.4
ЯРУУ	25.7	36.2	67.6	146.1	56.0
ТЭЛМЭН	31.3	48.7	68.3	90.4	58.1
ТҮДЭВТЭЙ	34.5	39.8	44.2	85.6	81.4
АЛДАРХААН	31.1	32.5	51.4	70.5	72.2
БАЯНХАЙРХАН	36.5	48.0	48.7	49.5	47.5
ОТГОН	23.0	35.2	51.2	63.5	42.7
ЦЭЦЭН-УУЛ	24.9	36.5	50.5	48.4	50.5
БАЯНТЭС	29.9	39.4	42.4	42.6	46.1
СОНГИНО	32.7	49.3	49.4	24.5	32.0
ТЭС	27.0	53.2	51.6	25.3	29.1
САНТМАРГАЦ	29.4	37.0	54.7	49.5	12.1
УРГАМАЛ	23.2	27.6	34.9	57.9	28.1
ЦАГААНХАЙРХАН	22.8	36.6	35.6	42.8	33.4
ЗАВХАНМАНДАЛ	28.9	28.5	36.2	16.5	32.1
АСГАТ	19.3	29.2	30.4	27.3	13.5
ЦАГААНЧУЛУУТ	19.7	26.8	34.3	16.3	20.6
Сумын төсвийн орлогын дүн	1,026.4	1,935.5	2,370.4	2,394.7	2,259.0
Аймгийн төсвийн орлого	5,745.0	6,507.7	6,075.1	6,908.2	7,033.4
Аймгийн нийт дүн	6,771.4	8,443.1	8,445.6	9,302.8	9,292.4

Хавсралт 5

ЗАВХАН АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, СУМААР

Сумын нэр	Татварын орлого /сая төг/				
	2016	2017	2018	2019	2020
ЭРДЭНЭХАЙРХАН	1,125.8	1,304.2	1,265.2	1,555.3	1,596.6
ИХ УУЛ	2,552.8	2,714.9	2,690.5	3,362.9	3,696.6
ДӨРВӨЛЖИН	1,379.1	1,327.0	1,327.6	1,614.6	1,912.5
ТОСОНЦЭНГЭЛ	3,930.7	4,504.2	4,510.1	5,281.3	6,426.2
ШИЛҮҮСТЭЙ	1,134.6	1,235.0	1,293.0	1,425.8	1,594.0
ЯРУУ	1,226.2	1,081.5	1,129.1	1,365.1	1,630.1
ИДЭР	1,427.8	1,655.7	1,466.2	1,871.4	2,098.8
НӨМРӨГ	1,564.9	1,560.2	1,509.6	1,796.9	2,039.4
ТҮДЭВТЭЙ	1,117.3	1,187.0	1,425.2	1,497.4	1,609.7
АЛДАРХААН	1,101.7	1,155.0	1,173.4	1,454.9	1,596.2
УЛИАСТАЙ	10,053.9	10,765.9	10,946.6	11,666.1	12,577.5
ТЭЛМЭН	1,531.7	1,499.1	1,555.0	2,003.4	2,372.6
БАЯНХАЙРХАН	1,258.6	1,212.3	1,227.3	1,613.1	1,742.8
ЦАГААНХАЙРХАН	1,023.3	1,057.9	1,016.8	1,224.0	1,482.9
ЦЭЦЭН-УУЛ	1,288.3	1,339.7	1,449.7	1,623.3	1,845.0
СОНГИНО	1,256.4	1,287.7	1,278.7	1,575.1	1,715.0
ОТГОН	1,420.0	1,527.9	1,458.5	1,857.2	2,059.1
УРГАМАЛ	1,055.7	1,239.0	1,268.2	1,408.8	1,746.0
ЗАВХАНМАНДАЛ	986.8	1,114.2	1,075.7	1,285.1	1,432.6
САНТМАРГАЦ	1,352.3	1,407.5	1,351.5	1,678.1	2,048.2
БАЯНТЭС	1,830.1	1,692.3	1,760.8	2,015.2	2,304.3
АСГАТ	1,074.2	1,062.0	1,129.4	1,394.4	1,742.4
ТЭС	1,900.0	2,040.7	1,942.3	2,209.9	2,461.2
ЦАГААНЧУЛУУТ	1,210.0	1,184.4	1,156.2	1,608.7	1,853.0
Сумын дүн	43,802.3	46,155.5	46,406.5	54,387.7	61,582.7
Аймгийн төсөв	15,113.1	15,201.5	19,418.4	12,320.6	14,874.0
Дүн	58,915.3	61,357.0	65,824.9	66,708.3	76,456.7

Хавсралт 6.

ЗАВХАН АЙМГИЙН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ШИЛЖҮҮЛГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, СЯЯ ТӨГ

ТЗШ-ын байгууллагууд	2016	2017	2018	2019	2020
	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	19,818.00	21,430.10	21,570.00	24,009.10	28,281.60
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ	7,737.40	8,101.80	8,617.30	9,795.10	10,882.90
НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР	230.30	329.40	629.20	1,119.30	1,074.10
ЭМ-ЫН АНХАН ШАТНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	5,199.80	5,216.50	5,281.50	6,737.50	7,615.00
СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	2,268.00	2,447.80	2,419.10		
ХҮҮХЭД ХАМГААЛАЛ	154.70	158.90	190.50	283.50	317.80
ГАЗРЫН ХАРИЛЦАА КАДАСТР	236.30	221.60	444.10	527.50	649.50

Хавсралт 7.

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ТООЦООЛОЛ, СУМААР

Сумын нэр	Малын тоо /мянган толгой/						Сумын ИТХ-аар	
	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Адуу	Үхэр
АЛДАРХААН	282.9	17.4	16.9	0.5	108.6	139.6	540	415
АСГАТ	47.4	3.2	3.8	0.0	21.7	18.8	550	450
БАЯНТЭС	172.5	8.9	9.5	0.2	64.9	89.1	600	500
БАЯНХАЙРХАН	121.1	6.5	7.7	0.0	67.7	39.2	500	300
ДӨРВӨЛЖИН	176.7	12.0	4.3	2.4	64.4	93.5	650	475
ЗАВХАНМАНДАЛ	101.8	4.6	2.3	0.2	44.9	49.8	600	500
ИДЭР	125.8	10.1	10.9	0.0	70.5	34.3	500	300
ИХ-УУЛ	249.1	19.7	31.9	0.1	139.6	57.8	500	400
НӨМРӨГ	123.4	13.5	11.0	0.0	65.7	33.2	600	500
ОТГОН	202.8	13.9	14.7	0.2	99.4	74.6	600	400
САНТМАРГАЦ	155.7	10.8	6.9	0.8	72.6	64.6	500	300
СОНГИНО	124.3	8.2	7.1	0.0	65.7	43.2	550	450
ТОСОНЦЭНГЭЛ	166.1	17.8	19.0	0.0	77.1	52.1	775	650
ТҮДЭВТЭЙ	114.8	9.8	8.2	0.0	65.1	31.8	450	400
ТЭЛМЭН	150.9	12.7	11.1	0.2	92.3	34.7	1000	800
ТЭС	119.2	7.7	8.3	0.1	53.2	49.9	500	350
УРГАМАЛ	114.1	6.2	2.5	2.1	53.4	49.9	800	600
ЦАГААНХАЙРХАН	99.0	4.2	6.0	0.0	47.7	41.1	500	400
ЦАГААНЧУЛУУТ	104.4	7.5	4.0	0.4	49.5	43.0	500	400
ЦЭЦЭН-УУЛ	170.4	7.2	6.8	0.3	100.5	55.7	500	300
ШИЛҮҮСТЭЙ	122.1	6.0	6.5	0.2	51.8	57.6	500	400
ЭРДЭНЭХАЙРХАН	213.4	10.3	7.3	0.2	132.5	63.2	400	400
ЯРУУ	202.5	12.5	8.3	0.1	128.4	53.2	500	300
УЛИАСТАЙ	147.3	6.4	10.1	0.1	62.6	68.3	400	400
Дүн	3,607.8	236.8	225.0	8.1	1,799.8	1,338.2	540.6	415.6

баталсан татварын хэмжээ /төгрөгөөр/			Малын тоо толгойн албан татварын төсөөлөл /сая төг/					
Тэмээ	Хонь	Ямаа	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа	Дүн
	250	350	9.4	7.0	0.0	27.2	48.8	92.4
0	267	350	1.7	1.7	0.0	5.8	6.6	15.8
0	200	400	5.3	4.7	0.0	13.0	35.7	58.7
0	200	400	3.2	2.3	0.0	13.5	15.7	34.8
0	275	375	7.8	2.1	0.0	17.7	35.1	62.7
0	400	300	2.8	1.1	0.0	17.9	14.9	36.8
0	400	200	5.0	3.3	0.0	28.2	6.9	43.4
0	300	200	9.8	12.8	0.0	41.9	11.6	76.1
	300	400	8.1	5.5	0.0	19.7	13.3	46.6
	350	650	8.4	5.9	0.0	34.8	48.5	97.5
	200	400	5.4	2.1	0.0	14.5	25.9	47.8
	225	350	4.5	3.2	0.0	14.8	15.1	37.6
	450	650	13.8	12.4	0.0	34.7	33.9	94.7
	250	350	4.4	3.3	0.0	16.3	11.1	35.1
	500	600	12.7	8.9	0.0	46.1	20.8	88.5
0	250	350	3.8	2.9	0.0	13.3	17.5	37.5
	200	300	5.0	1.5	0.0	10.7	15.0	32.1
	200	300	2.1	2.4	0.0	9.5	12.3	26.4
	200	300	3.7	1.6	0.0	9.9	12.9	28.1
	200	350	3.6	2.0	0.0	20.1	19.5	45.2
	200	300	3.0	2.6	0.0	10.4	17.3	33.2
	100	200	4.1	2.9	0.0	13.3	12.6	32.9
0	200	400	6.3	2.5	0.0	25.7	21.3	55.7
	200	300	2.5	4.0	0.0	12.5	20.5	39.5
0.0	252.8	351.0	127.1	91.6	0.0	444.3	443.8	1,199.1

